

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 52
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	53 – 157

1.	“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	53 – 157
----	--	----------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 23-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Э.Батшугар, А.Ундраа, С.Цэнгүүн, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Р.Батболд, Х.Баттулга;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, О.Цогтгэрэл.*

***Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр
өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Салбаруудын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Түвшин, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Баясгалан, Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Өнөржаргал, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балжинлуvsан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мягмардорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Үйлдвэр, технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нэмэхбаяр, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын Геологи, цөмийн энергийн хэлтсийн дарга Х.Санчигдорж, Сангийн яамны Хөгжлийн

санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Д.Бямбадорж, Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Эрхэмбаяр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, мөн яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сэргэлэн, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Цахим бодлого, статистикийн мэдээллийн хэлтсийн дарга Ч.Энхтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, мөн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Отгонцэцэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Л.Ариунтунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, Г.Очирбат, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2 дахь дэд заалт нэмэх:

“2/Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ өмнөх онуудад ажил нь эхэлсэн төсөл, арга хэмжээг зогсоохгүй байх, түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөр техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжинд эрэмбэлэн

тухайн ондоо хэрэгжүүлдэг байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын 3.5.1 дэх заалтын Бодлогын үндэслэл баганаас “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн эшлэлийг тохиолдол бүрт хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.1.Экспортыг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бүс нутгийн эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн экспортын чөлөөт бүсийг “Хархорум” хотод байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.3.Орхоны хөндийд “Хархорум” хот байгуулахад шаардлагатай төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах” төсөл, арга хэмжээний “Нийт санхүүжилтийн дүн сая.төг” гэсэн баганад “30,707.30” гэж нэмж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганын “20,707.30” гэснийг “10,707.30” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу саналыг хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Р.Сэддорж: Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.3.Орхоны хөндийд “Хархорум” хот байгуулахад шаардлагатай төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах” төсөл, арга хэмжээний “Нийт санхүүжилтийн дүн сая.төг” гэсэн баганад “30,707.30” гэж нэмж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганын “20,707.30” гэснийг “10,707.30” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.9.Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.4.11.Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангана” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын “1.6.1.2.Байдрагийн усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.4.10.Байдрагийн усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх

бэлтгэл ажлыг хангана” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар хавсралтын “1.9.1.3.Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” гэсэн төсөл, арга хэмжээ”-ний “4 эгнээ” гэснийг “6 эгнээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар хавсралтын “1.9.1.4.Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.9.Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар хавсралтын “1.10.1.1.Дархан-Уул аймагт орон нутгийн лавлагаа шатлалын эмнэлэг шинээр барих” гэсэн төсөл, арга хэмжээний “Нийт санхүүжилтийн дүн сая.төг” гэсэн баганад “150,000.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганад “28,800.0” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар хавсралтын “1.11.1.2.Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ барих” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “1.2.5.Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ барих төслийн бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 2 дугаар хавсралтын “1.11.1.3.“Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн ажлыг эхлүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “1.2.6.“Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар хавсралтын “1.11.1.5.Тусгай замын автобус /BRT/-ны сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “1.2.7.Тусгай замын автобус /BRT/-ны сүлжээ байгуулах төслийн бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 2 дугаар хавсралтын “2.5.1.2.Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “2.1.14.Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл хэрэгжүүлнэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 2 дугаар хавсралтын “2.9.1.3.Боловсролыг дэмжих жилийн хүрээнд гэр бүлийн боловсролыг дэмжих үндэсний хэмжээний үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 2 дугаар хавсралтын “2.10.1.1.Хүүхдийн амралт, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдийн зусланг 4 ээлжээр зохион байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 2 дугаар хавсралтын “2.12.1.1.Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 2 дугаар хавсралтын “2.2.1.1.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “2.1.14.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 2 дугаар хавсралтын “2.13.2.1.Хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг төслийн 1 дүгээр хавсралттай давхцаж байгаа тул хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 2 дугаар хавсралтын “3.3.1.1.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 2 дугаар хавсралтын “3.3.1.3.Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноос боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээний “Хэмжих нэгж” баганын “Хялгас ялгах, тонн, Ээрэх, тонн, Сүлжих, сая.ш, Нэхэх, сая.метр, Ноосон бордоо, тонн” гэснийг мөрөөр нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.3.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах” төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.6. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.5.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.7.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 2 дугаар хавсралтын “3.13.1.3.Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Хэрлэн-Тооно, Онги-Цагаан бургастай төслийн бэлэн байдлыг хангах” гэсэн төсөл, арга хэмжээний Шалгуур үзүүлэлт

баганын “Хэрлэн-Тооно усан цогцолборын төслийн хэрэгжилт” гэснийг мөрөөр нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 2 дугаар хавсралтын “3.15.1.5.Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газрыг байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.8.Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газрыг байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 2 дугаар хавсралтын “3.16.3.2.Бичигт боомтод ачааны терминал байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.9.Бичигт боомтод ачааны терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 2 дугаар хавсралтын “3.16.3.3.Хавирга боомтод ачааны терминал байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.10.Хавирга боомтод ачааны терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Төслийн 2 дугаар хавсралтын “4.2.1.11.Засгийн газраас хэрэгжүүлж буй "Мега" төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчнийг оролцуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “4.3.5.Засгийн газраас хэрэгжүүлж буй "Мега" төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчнийг оролцуулна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төслийн 2 дугаар хавсралтын “4.15.1.2.Үндэсний хиймэл дагуул хөөргөх бэлтгэл ажлыг хангах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “4.5.6. Үндэсний хиймэл дагуул хөөргөх бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төслийн 2 дугаар хавсралтын “2.12.1.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг төслийн 1 дүгээр хавсралттай давхцаж байгаа тул хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Төслийн 2 дугаар хавсралтын “3.3.1.4.Арьс, шир боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /Дархан арьс, ширний цогцолбор/” гэсэн төсөл, арга хэмжээний “Дархан арьс, ширний цогцолбор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, М.Мандхай, М.Бадамсүрэн нар үг хэлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.6.Дарханы үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.2.7.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөх” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Г.Лувсанжамц нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Төслийн 2 дугаар хавсралтын “3.14.1.4.Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг татварын бодлогоор дэмжих” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.1.11.Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг татварын бодлогоор дэмжинэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Төслийн 2 дугаар хавсралтаас “4.1.1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Төслийн 2 дугаар хавсралтын “4.8.1.1.Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэн архивын үйлчилгээн дэх нэгдсэн цахим системийг нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээний “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганад “2,155.00” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Төслийн 2 дугаар хавсралтын “4.16.1.1.Улсын хэмжээний тооллого, түүвэр судалгааг зохион байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “4.1.5. Улсын хэмжээний тооллого, түүвэр судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Төслийн 2 дугаар хавсралтын “3.14.1.6.Төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилттэй инновацын төслүүдийг хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээний Үндсэн хариуцагч баганын “Эдийн засаг, хөгжлийн яам” гэснийг “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Төслийн 2 дугаар хавсралтын “3.14.1.9.Инновацийн сангаас технологи, инновацийн бүтээгдэхүүн болон инновацийн дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төсөл, арга хэмжээний Үндсэн хариуцагч баганын “Эдийн засаг, хөгжлийн яам” гэснийг “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Төслийн 2 дугаар хавсралтын 2.9.1 дэх заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.3.2. ЗГҮАХ-2.1.1.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Монгол Улсын хэмжээний бүх сургуулийн бага ангийн нийт сурагчдын 30-аас доошгүй хувийг хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу гадаад хэл суралцах спортоор хичээллэх авьяас, ур чадвараа нээх, хувь хүнийг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийн сургалтад хамруулах зорилгоор бүх хэвшлийн сургалтын төв, дугуйлангууд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан хүүхэд” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь түвшин “0” гэж, “Зорилтот түвшин “114000” гэж, Нийт санхүүжилтийн дүн “18,810.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “18,810.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв болон бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 2.9.1.1 дэх заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Жаргалмаа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15

40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

40.Төслийн 2 дугаар хавсралтын 2.10 дахь хэсэгт Бодлогын үндэслэл “АХ-2.3.2, ЗГҮАХ-2.1.1.5, 2.1.1.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулж, санхүүгийн урамшуулал болон техник, тоног төхөөрөмжөөр хангах хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан ажилтан” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1900” гэж, Нийт санхүүжилтийн дүн “9,120.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “9,120.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж 2.10.1.3 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, М.Бадамсүрэн нар үг хэлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Төслийн 2 дугаар хавсралтын 3.Эдийн засгийн бодлого хэсгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “3.19.Бичил, жижиг, дунд бизнесийн эдийн засагт оруулах хувь нэмэг нэмэр нэмэгдсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “3.19.1.Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоо өсөж, ажлын байр нэмэгдэн, импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-3.3.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “3.19.1.1.Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих, урт хугацаатай бага хүүтэй зээлийн хүртээмж, бүтээгдэхүүний төслийг нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Улсын хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний эзлэх хувь” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “5.5” гэж, Зорилтот түвшин “7” гэж, Нийт санхүүжилтийн дүн “58 тэрбум” гэж, тухайн жилд шаардагдах санхүүжилт “58 тэрбум” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв болон бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 3.19.1.1 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, М.Мандхай нар үг хэлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, 8.1.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум, Хөх нуур чиглэлийн хатуу хучилттай 50 км авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Зам, барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “115 тэрбум” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “38.3 тэрбум” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.2 дахь заалтад Төсөл, арга хэмжээ “Чойбалсан нисэх буудлын хөөрөх буух зурвасыг шинэчлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “79,068.9” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “26,356.3” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж 1.9.2.3 дахь дэд заалтыг өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Жаргалан нар үг хэлж, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Төсөл, арга хэмжээ “Хэрлэн голын 217,6 у/м төмөр бетон гүүр, 1.0 км авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Зам барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “28,910.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “9,636.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2 дахь заалтад Төсөл, арга хэмжээ “Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос Баянхошуу боомт, Халхгол сум чиглэлийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Зам барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “483,397.4” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “161,132.5” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Төслийн 2 дугаар хавсралтын 4.9 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.1.9, ШСБ-6.1, ЗГҮАХ-4.1.5.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорнод аймаг дахь Шүүхийн Тамгын газрын барилга” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “13,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “4,600.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Шүүхийн ерөнхий зөвлөл” гэсэн 4.9.3.1 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл ЗГҮАХ-4.2.4.1, 4.2.4.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар метрополитан бүс дэх Хүннү ухаалаг хотын хөгжлийг удирдах чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төслийг хэрэгжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Бэлтгэл ажлын хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “7,000.0” гэж, Тухайн жилд шаардлагтай санхүүжилтийн хэмжээ “2,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Гадаад тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар” гэсэн 1.1.1.10 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Төслийн 2 дугаар хавсралтын 1.4.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “1.4.1.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй хот, суурин газрын тоо нэмэгдсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-4.2.4.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Хороо, багийн хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын бичил, жижиг төслүүдийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр иргэдийн бүлэг, хөршийн холбоо тухайн нэгжийн хувийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Тухайн нэгжийн оршин суугчаар гүйцэтгүүлсэн ажлын нийт төсөвт эзлэх

хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх дүн” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх дүнгийн 30 хувь” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Нийслэлийн засаг даргын Тамгын газар, аймгуудын засаг даргын Тамгын газар” гэсэн "1.4.1.2. дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Төслийн 2 дугаар хавсралтын 3.10 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Байгалийн гамшигт үзэгдлийг судлах, урьдчилан мэдээлэх техник, технологийг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл АХ-9.2.13, ЗГҮАХ-1.4.2.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон зээлийн дэмжлэг үзүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Энергийн хэмнэлтийн улмаас буурсан нүүрс төрөгчийн ялгаруулалт /PM2.5/” гэж, Хэмжих нэгж “мкг/м³” гэж, Суурь түвшинд “194.6” гэж, Зорилтот түвшин “155” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,872,300.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “300,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Орон нутгийн төсөв, гадаадын тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар,” гэсэн "3.10.1.4 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Төслийн 2 дугаар хавсралтын 3.10 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Байгалийн гамшигт үзэгдлийг судлах, урьдчилан мэдээлэх техник, технологийг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.2.13, ЗГҮАХ-1.4.2.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Бүх хот суурин газарт суурин болон зөөврийн станцуудыг шинээр суурьлуулж мэдээллийн нэгдсэн системд холбох” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “21” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,500.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Гадаадын тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэсэн

3.10.1.5 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Төслийн 2 дугаар хавсралтын 1.7.4 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Инженерийн дэд бүтцээр хангагдсан бүс, орон нутаг, сум суурингийн тоо нэмэгдсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.3.2., ШСБ-4.2.1, ЗГҮАХ-2.4.3.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Үерийн далан /Дархан-Уул, Шарын гол/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “3,592.5” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “3,592.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэсэн 1.7.5.2 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Төслийн 2 дугаар хавсралтын 1.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, ЗГҮАХ-1.3.4.6.” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Уул аймгийн Шарын гол суманд 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “40” гэж, Нийт санхүүжилтийн дүн “473,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “142,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.12 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, 8.1.2, ЗГҮАХ-3.3.2.16.” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Баянцагаан-Баян чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “109,619.5” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “36,539.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.1. 8.1.2. ЗГҮАХ-3.3.2.16.” гэж, Төсөл, арга хэмжээ “Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа өртөөний төмөр зам дээгүүр явах 2 урсгалтай гүүрэн байгууламж барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “27,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “9,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.17 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.35. ШСБ-2.1, ЗГҮАХ-3.3.3.32.” гэж,

Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам дагуу цахилгаан автомашин цэнэглэх зориулалттай нарны эрчим цахилгаан эх үүсвэртэй үйлчилгээний жишиг төвийг байгуулах төслийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,100.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Төслийн 2 дугаар хавсралтын 3.14 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эрдэм шинжилгээний ажлын үр дүн, чанарыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.4.11, ЗҮАХ-3.3.7.3” гэж, Төсөл, арга хэмжээ “10 мянга нарны дээвэр хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “15” гэж, Нийт санхүүжилтийн дүн “100,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “15,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Гадаад дотоодын хөрөнгө оруулалт, Гадаадын зээл, тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэсэн 3.14.1.13 дахь дэд заалтыг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Төслийн 2 дугаар хавсралтын 2.5.1 дэх заалтад Төсөл, арга хэмжээ “2.5.1.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын орчин, дэд бүтцийг сайжруулах, хөрөнгийн менежментийн үр ашгийг нэмэгдүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Стандартын шаардлага хангасан оюутны байрны эзлэх жин” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “35” гэж, Зорилтот түвшин “46” гэж, Нийт санхүүжилтийн дүн “435,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “105,000.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэж,

Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэсэн 2.5.1.4 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Төслийн 2 дугаар хавсралтын 4.17 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “4.17.Хүний эрхийг хамгаалах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагын олон талт хамтын ажиллагаа бэхжинэ.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “4.17.1.Хүний эрхийн Үндэсний Комиссыг Парисын зарчимд бүрэн нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага болгож бэхжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5.1. 5.5.2, ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “4.17.1.1.Ази, номхон далайн бүсийн хүний эрхийн төв шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “25,096.3” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “8,365.4” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүний эрхийн Үндэсний Комисс” гэсэн 4.17.1.1 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь хэсгийн Зорилтот үр дүн “Өрсөлдөх чадвартай тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Стандартын шаардлага хангасан оюутны байрны эзлэх жин” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “35” гэж, Зорилтот түвшин “46” гэж, Мэдээллийн эх сурвалж “Дээд боловсролын статистик” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Захиргааны статистик” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жилд 1 удаа” гэж, Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “4.3.1” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Төслийн 2 дугаар хавсралтын “1.7.3.2 дэд заалтын төсөл, арга хэмжээг “Орон нутагт ажиллах төрийн албан хаагчдын болон сумдад хөдөлмөр эрхлэж байгаа залуучуудын түрээслэх орон сууц барих” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.3.44, 9.3.46, ЗГҮАХ-1.4.2.6, 2.4.3.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрчим хүчний хяналтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх системүүдийг /WAMPAC, SCADA, MDMS/-г шинэчлэх”, “Эрчим хүчний ухаалаг сүлжээ төсөл” гэж, Шалгуур үзүүлэлтд “Шинээр суурьлуулах тоног төхөөрөмж” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “25” гэж, Нийт санхүүжилтийн дүн “183,230.6” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “45,557.6” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Гадаад зээл” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлж, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 14
Бүгд: 15
6.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

62.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, автотээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.16.” гэж, Төсөл, арга хэмжээ “Говь-Алтай, Алтай-Бургастай чиглэлийн авто замаас Алтай сум хүртэлх хатуу хучилттай авто замын зураг төсөл, төсөв боловсруулах” Шалгуур үзүүлэлт Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “2,600.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 14
Бүгд: 15
6.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

63.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.2 дахь хэсэгт “Ховд аймаг, Булган сум, Булган боомтын үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх бэлтгэл хангана.” гэсэн 3.2.6 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Төслийн 2 дугаар хавсралтын 1.6 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.35, ЗГҮАХ-1.3.2.4.” гэж, Төсөл, арга хэмжээ “Шинээр баригдах 220/110/35 Кв-ын “Городок” транзит дэд станц, Городок-сэргэлэн чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, Городок Налайх чиглэлийн 110 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ-ын ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг 5 дугаар хороо/.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “кВа” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “35” гэж, Нийт санхүүжилтийн дүн “144,427.7” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “50,549.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.12 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 15
Бүгд: 15
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

65.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Налайх Цахилгааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “56,354.9” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “18,785.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн нар үг хэлж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Өрсөлдөх чадвартай, тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн Дээд боловсролын үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, Эрдэнэт хотод хотхон байгуулан шилжүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн

хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “80,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж 2.5.1.4 дэх дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут үг хэлж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал:

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон Улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “46,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “28,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон Улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто

замын үргэлжлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “137,500.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “30,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.11 дэх дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хэрэгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.3.5.1, 1.3.1.4, 3.3.2.5, 3.3.2.22” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрдэнэт хотод байгуулагдах бүсийн тээвэр логистикийн төвийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, батлуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “ТЭЗҮ” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “2,000.00” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, ТӨҮГ” гэсэн 1.1.1.13 дахь дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 2.3 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Олон улсад өрсөлдөхүйц чанартай, тэгш хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг бууруулсан байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.1.19”, “ЗГҮАХ-2.2.1.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Олон жил гацсан ерөнхий боловсролын сургуулийн барилга барьж дуусгах” гэж, Шалгуур үзүүлэлт “Ашиглалтад орох сургууль” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн “40,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “40,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг

даргын Тамгын газар” гэсэн 2.3.1.9 дэх дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.10 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Иргэдэд бүс нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “Зоонозын өвчин судлалын төвийн барилгын төсөл хэрэгжсэнээр баруун бүсэд зонхилон тохиолдох зоонозын халдварт өвчин, шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний эрт илрүүлэг, оношлогоог хурдан шуурхай оношлох, Монгол Улсын болон олон улсын стандартын дагуу шинжилгээ, судалгаа хийгдэх нөхцөл бүрдэнэ. Эмч мэргэжилтнүүдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах орчин бүрдэх, халдвартай материал сорьц алдагдахаас бүрэн сэргийлэх, мөн шаардлагатай тоног төхөөрөмж байрлуулж ажиллах орчин бүрдэнэ.” гэж, Төсөл, арга хэмжээ “1.10.1.2.Баруун бүсэд Зоонозын өвчин судлалын төвийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “4,018.00” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,009.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэсэн 1.10.1.2 дахь дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “Улаангом, Баруунтуруун чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замыг барьснаар Увс аймгийн зүүн талын 6 сум /Баруунтуруун, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Малчин, Тэс/ хатуу хучилттай авто замд холбогдох боломж бүрдэнэ. Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан баруун бүсийн газар тариалангийн гол бүс нутаг болох Баруунтурууны улаанбуудай, тэжээлийг зах зээлд нийлүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, гурил тэжээлийн үйлдвэр амжилттай ажиллах нөхцөл бүрдэх өндөр ач холбогдолтой авто зам болно” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаангом-Баруунтуруун чиглэлийн 180 км хатуу хучилттай

авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн “360,000.00” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “36,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 6 цаг 34 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дүгээр сарын 23-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 40 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин, Р.Сэддорж нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Р.Батболд гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Х.Баттулга гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Э.Батшугар гишүүн гадаад томилолттой, А.Ундраа гишүүн гадаад томилолттой, С.Цэнгүүн гишүүн орон нутагт томилолттой, М.Энхцэцэг гишүүн гадаад томилолттой байна.

Ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.0 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газраас 2025 оны 04 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх бусад Байнгын хороод санал, дүгнэлтээ ирүүлснийг Та бүхэндээ тараасан байгаа.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе. М.Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хоёр дахь хэлэлцэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, Г.Очирбат, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан.

Ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хураалтад дараах үндсэн чиглэлийг мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх багийн бүрэлдэхүүнд даалгавар болгосон. Үүнд:

1.2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт болон эхлүүлсэн боловч царцаагдсан төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлын талаар танилцуулгыг бэлтгэх.

2.Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан 4 реформыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчилсан мэдээлэл бэлтгэж танилцуулах.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын зорилт тус бүрийг 2 дугаар хавсралтын төсөл, арга хэмжээтэй болон 3 дугаар хавсралтын шалгуур үзүүлэлттэй нийцүүлэх.

4.Сургууль, цэцэрлэг, дотуур байр барих арга хэмжээг ерөнхий тоо тавих биш, бүс бүрээр болон нийслэлд хэрэгцээ шаардлагад тулгуурлан мэдээллийн их өгөгдөл үндэслэн тэнцвэртэй байдлаар хувааж тодорхой тоо тавих. Орон

сууц барих арга хэмжээг мөн бүс тус бүрээр болон нийслэл гэж тодорхой зааж танилцуулах.

5.Засгийн газраас зохион байгуулсан бүсийн зөвлөгөөнүүдээс гарсан саналуудыг хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн тусгасан талаар танилцуулах.

6.Цаашид техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн бол төслийг заавал хэрэгжүүлдэг байх.

Төсвийн хөрөнгийг ТЭЗҮ-д зарцуулаад жил бүр ямар нэгэн хөрөнгө оруулалт тусгахгүйгээр орхидог явдлыг зогсоолгох талаар тодорхой санал танилцуулга бэлтгэх. Жишээ нь, Зам, тээврийн яамны танилцуулгаар 10 жилийн хугацаанд бүтээн байгуулалт хийхээр төлөвлөсөн техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн 175 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байгаа тухай мэдээллийг танилцуулсан.

Энэ нь магадлалын дүгнэлт 2 жилийн хугацаанд хүчинтэй байх гэдэг энэ бодлоготой нийцэхгүй байгаа асуудлыг залруулах шаардлагатай гэж үзсэн.

Ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тогтоолын төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн нэг бүрчлэн санал хурааж, залруулж энэхүү Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Түүнчлэн ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй 100 саналыг дээрх хуулийн шаардлагад нийцүүлэн бэлтгэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэгт заасны дагуу Та бүхэндээ танилцуулж байна.

Цаашид анхаарах зүйлийн талаар 5 саналыг дэвшүүлье.

▷ **Нэгдүгээрт**, Хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт хангалттай ажиллах хугацааг гаргаж өгөх шаардлагатай.

▷ **Хоёрдугаарт**, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хугацаа дуусгавар болохоос буюу 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 04 сарын өмнө энэ 5 жилийн хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулна гэсний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 28-наас өмнө тайлагнах байсан тайланг одоогоор Улсын Их Хуралд ирүүлээгүй байна.

▷ **Гуравдугаарт**, Засгийн газар Монгол Улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болохоос 2 сарын өмнө буюу 2025 оны одоо 08 дугаар сарын 28-наас өмнө 06 дугаар сарын одоо 28-ны өдөр Улсын Их Хуралд одоо мэдүүлнэ гэж заасны дагуу энэ хугацаанд багтаж өргөн мэдүүлэх шаардлагатай.

▷ **Дөрөвдүгээрт**, Дээрх төслийг өргөн мэдүүлэхдээ хуульд заасны дагуу Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөж хавсаргах.

▷ **Тавдугаарт**, Эдийн засаг, хөгжлийн яам хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа холбогдох яам, байгууллагаас санал авахдаа зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр зэрэг задаргаагаар нарийвчлан боловсруулж салбар яамдын саналыг аваад зөвхөн нэгтгэх биш бодлогын хувьд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж Засгийн газарт танилцуулж, дараа нь яамдаас санал авч, санал авахдаа хуульд заасан шалгуур, шаардлагыг авах, тодруулах, саналуудыг авах шаардлага байна.

Өөрөөр хэлбэл Эдийн засаг, хөгжлийн яам хөгжлийн төлөвлөгөөг бүрэн түрүүлж санаачилж ажиллах шаардлагатай байна гэдгийг энд хэлье.

Ингээд “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбаруудын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Түвшин, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Баясгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ж.Өнөржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балжинлуvsан, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Д.Бямбадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Үйлдвэр, технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нэмэхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сэргэлэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Цахим бодлого, статистикийн мэдээллийн хэлтсийн дарга Ч.Энхтуяа, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын Геологи, цөмийн энергийн хэлтсийн дарга Х.Санчигдорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мягмардорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Отгонцэцэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Л.Ариунтунгалаг, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Манай улсад энэ түр орлон гүйцэтгэгч гээд Төрийн албаны хууль дээр энэ заалтыг эргэж харахаар л юм шиг санагдаж байна. Одоо энэ хүмүүс юу гэж хэлэгдэх вэ дараа нь.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэллээ.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2 дахь дэд заалт нэмэх:

2/Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ өмнөх онуудад ажил нь эхэлсэн төсөл, арга хэмжээг зогсоохгүй байх, түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөр техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжинд эрэмбэлэн тухайн ондоо хэрэгжүүлдэг байх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, Г.Очирбат, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал тайлбар байхгүй. Шууд Санал хураалт. /алх цохив/ /алх цохив/

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын 3.5.1 дэх заалтын Бодлогын үндэслэл баганаас “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн эшлэлийг тохиолдол бүрт хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Би сүүлийн 2 санал хураалтад дэмжиж санал өгсөн. Энэ төхөөрөмж ажиллахгүй байна.

3.Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.1.Экспортыг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бүс нутгийн эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн экспортын чөлөөт бүсийг “Хархорум” хотод байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.3.Орхоны хөндийд “Хархорум” хот байгуулахад шаардлагатай төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах” төсөл, арга хэмжээний “Нийт санхүүжилтийн дүн сая.төг” гэсэн баганад “30,707.30” гэж нэмж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганын “20,707.30” гэснийг “10,707.30” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын саналыг цуцлаад дахиж санал хураалт хийж өгөөч ээ гэж хүсье.

Р.Сэддорж: М.Мандхай гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томьёоллоор Санал хураалт. /алх цохив/ /алх цохив/

Төхөөрөмжүүд ажиллахгүй байна. М.Бадамсүрэн гишүүн горимын санал гаргая гэж байна. М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Энэ төхөөрөмж үнэхээр ажиллахгүй байна. Тэгээд дахин санал хураалт явуулж өгөөч. Хүчингүй болгох талаар.

Р.Сэддорж: Техникийн Санал хураалт. /алх цохив/ Дахин явуулъя. Ирцийн Санал хураалт. /алх цохив/ Бүгдээрээ ирцийн санал хураалтад ороодохдоо. Ирцийн Санал хураалт. /алх цохив/ /алх цохив/

Яах вэ, сольж суух уу? Дахиад техникийн, ирцийн Санал хураалт. /алх цохив/ /алх цохив/

4 дүгээр санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн. М.Мандхай гишүүний хүчингүй болгох саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор Санал хураалт. /алх цохив/

Одоо дэгийн тухай хууль уншина. Ирц бүрдэж байна уу? Гар өргөөд явуулбал.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.4 ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна гэсэн ийм заалт байгаа.

Үнэхээр техник ажиллахгүй байгаа тул, олон гишүүд удаа дараа техник ажиллахгүй байгааг микрофонд хэллээ. Миний техник үнэхээр ажиллахгүй байна. Ингээд гараар санал хураалтыг үргэлжлүүлэн явуулъя.

Ингээд М.Мандхай гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөө.

13-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо М.Бадамсүрэн гишүүний гаргасан хүчингүй болгох саналыг дэмжье гэсэн томьёоллоор Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, хувийг бол протокол тэмдэглээд явна. Тийм ээ. Дэмжиж санал дэмжигдлээ.

Одоо 4 дүгээр саналыг дахиж санал хураана.

Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.3.Орхоны хөндийд “Хархорум” хот байгуулахад шаардлагатай төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах” төсөл, арга хэмжээний “Нийт санхүүжилтийн дүн сая.төг” гэсэн баганад “30,707.30” гэж нэмж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганын “20,707.30” гэснийг “10,707.30” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын “1.1.1.9.Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.4.11.Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангана” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Боловсролын сайд П.Наранбаяр орж ирсэн байна.

6.Төслийн 2 дугаар хавсралтын “1.6.1.2.Байдрагийн усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.4.10.Байдрагийн усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар хавсралтын “1.9.1.3.Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” гэсэн төсөл, арга хэмжээ”-ний “4 эгнээ” гэснийг “6 эгнээ” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар хавсралтын “1.9.1.4.Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.9.Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар хавсралтын “1.10.1.1.Дархан-Уул аймагт орон нутгийн лавлагаа шатлалын эмнэлэг шинээр барих” гэсэн төсөл, арга хэмжээний “Нийт санхүүжилтийн дүн сая.төг” гэсэн баганад “150,000.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганад “28,800.0” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар хавсралтын “1.11.1.2.Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ барих” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “1.2.5.Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ барих төслийн бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Төслийн 2 дугаар хавсралтын “1.11.1.3.“Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн ажлыг эхлүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “1.2.6.“Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар хавсралтын “1.11.1.5.Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж,

Төслийн 1 дүгээр хавсралтад “1.2.7.Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төслийн бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Г.Лувсанжамц гишүүн. Ажлын хэсгийн гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Энэ санал хураалтын 38 хүртэлх бүх саналууд нь хөгжлийн төлөвлөгөөн дээр буруу тусгагдсан зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр 2, 3 дугаар хавсралт дээр ямар ч юм бичээгүй, шалгуур үзүүлэлтгүй, төсөв хөрөнгөгүй, хариуцсан хүнгүй тийм төслүүдийг нь хариуцсан байгууллага нь өөрсдийнхөө урсгал зардлын хүрээнд хавсралт 1 рүүгээ шилжүүлээд тэгээд өөрсдөө бэлтгэл ажлаа хангах гэсэн голцуу ажлууд байгаа.

Зарим нь нэршил нь буруу байдаг ч юм уу, эсвэл аль хэдийн хэрэгжээд эхэлсэн төслүүд дээр төсвийн хөрөнгө мөнгөнийх нь заалт байгаагүй гэсэн тийм алдаатай зүйлүүдийг нь засаж өгсөн саналууд нь 38 дугаар санал хүртэл байгаа учраас бүгдээрээ хөгжлийн төлөвлөгөөгөө зөв болгох л саналууд учраас агуулгын хувьд ямар нэгэн юм хасаад, нэмээд байгаа гэсэн тийм зүйлүүд байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

13.Төслийн 2 дугаар хавсралтын “2.5.1.2.Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “2.1.14. Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл хэрэгжүүлнэ.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

14.Төслийн 2 дугаар хавсралтын “2.9.1.3.Боловсролыг дэмжих жилийн хүрээнд гэр бүлийн боловсролыг дэмжих үндэсний хэмжээний үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

15.Төслийн 2 дугаар хавсралтын “2.10.1.1.Хүүхдийн амралт, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдийн зусланг 4 ээлжээр зохион байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Н.Учрал орж ирсэн байна.

16.Төслийн 2 дугаар хавсралтын “2.12.1.1.Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ бол хууль нь батлагдсан учраас эндээс хасаж байгаа юм байна.

17.Төслийн 2 дугаар хавсралтын “2.2.1.1.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “2.1.14.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

14-өөс 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Төслийн 2 дугаар хавсралтын “2.13.2.1.Хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг төслийн 1 дүгээр хавсралттай давхцаж байгаа тул хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Төслийн 2 дугаар хавсралтын “3.3.1.1.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

20.Төслийн 2 дугаар хавсралтын “3.3.1.3.Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноос боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” гэсэн

төсөл, арга хэмжээний “Хэмжих нэгж” баганын “Хялгас ялгах, тонн, Ээрэх, тонн, Сүлжих, сая.ш, Нэхэх, сая.метр, Ноосон бордоо, тонн” гэснийг мөрөөр нь хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

21.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.3.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах” төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.6. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ дээр тайлбар авъя. Г.Лувсанжамц гишүүн. Г.Лувсанжамц гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Сая хэлсэнчлэн 38 дугаар заалт хүртэлх бүх заалтууд нь хөгжлийн төлөвлөгөөнийхөө зарчмыг баримтлаагүй тийм зүйлүүд байгаа.

Одоо жишээ нь, нүүрс-хими, кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах гээд 2026 ондоо багтаад яагаад ч амжихгүй. Логикийн хувьд алдаатай.

Тэгэхээр бэлтгэл ажлыг хангана гэдгээр нь 1 дүгээр хавсралт руу оруулж байгаа гэсэн үг.

Сая дээд талын өмнөх зарим хасаж байгаа зүйлүүд нь яамнаасаа өргөн барихдаа төсөв байхгүй, хариуцагч байхгүй, шалгуур үзүүлэлт байхгүй.

Тэгэхээр төлөвлөгөөгөө буруу боловсруулсан зүйлүүдийг нь засаж өгч байгаа л саналууд юм. Техникийн саналууд. 38 дугаар санал хүртэл. Тийм. Тооцоолол байхгүй. Тийм юм байхгүй. Угаасаа хуулийнхаа дагуу 6.10 дугаар заалт. Бэлтгэл ажлаа бол хийнэ. Гэхдээ 2026 ондоо багтаж энэ чинь ашиглалтад оруулж чадахгүй шүү дээ. Тийм. Тэгэхийн тулд 1 дүгээр хавсралтад оруулсан нь зохистой юм билээ. 2 дугаар хавсралт биш.

Одоо энэ хасах гэж байгаа нь 2 дугаар хавсралтаас л хасаад байгаа юм. Түүнээс биш 1 дүгээр хавсралтаа байлгаж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.3.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах” төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.6. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 12 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

22.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.5.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.7.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 13 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Ажлын албанаас энд дахиад нэг хүн байх хэрэгтэй байна.

23.Төслийн 2 дугаар хавсралтын “3.13.1.3.Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Хэрлэн-Тооно, Онги-Цагаан бургастай төслийн бэлэн байдлыг хангах” гэсэн төсөл, арга хэмжээний Шалгуур үзүүлэлт баганын “Хэрлэн-Тооно усан цогцолборын төслийн хэрэгжилт” гэснийг мөрөөр нь хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Тайлбар авъя. М.Бадамсүрэн гишүүн. Ажлын хэсгийн дарга.

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлаас баталсан мега төслүүдийг Засгийн газраас хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангаж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаатай холбогдуулаад энэ хавсралт 2 буюу энэ хөгжлийн төлөвлөгөөний жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ нь хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байгаа юм.

Өөрөөр хэлбэл техник, эдийн засгийн үндэслэл байхгүй, зураг төсөв байхгүй, аль эх үүсвэрээс гарах нь тодорхойгүй, хариуцах эзэн нь тодорхойгүй. Ийм байгаа учраас бид бүхэн энэ төслийг хэрэгжүүлэхийн тулд тэргүүлэх чиглэл дээр нь оруулаад явахгүй бол энэ шалгуураараа бол бүрэн хасагдах гээд байгаа юм. Нэг. Нэмж тайлбарлаж байгаа юм.

Хоёрдугаарт нь, энэ төслийн хувьд хоёр зүйл оруулж ирсэн байгаа. Хэрлэн-Тооно, Онги, Цагаанбургастай гээд. Онги-Цагаанбургастай нь болохоор хэлэлцүүлгийн явцад салбарын яамнаас энэ шалгуураа хангуулах боломжтой юу гээд төсөв дүнг нь тавиад, боломжтойг нь бид дэмжээд явсан байгаа. Боломжгүй байгаа, ямар ч судалгаа, тооцоо байхгүй зүйлүүдийг нь энэ жагсаалтаас Эдийн засаг, хөгжлийн яамны тайлбарын үндсэн дээр хасаад явж юм.

Ер нь нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Энэ 4 жилийн үйл ажиллагааны төслүүдэд тусгагдсан ажлуудыг энэ нэг жилд тусгахад энэ дээр юмнуудыг бэлтгэлийг хангаад ороод ирэх боломж бүрэн байсан гэж үзэж байгаа юм. Байхгүй учраас бидэнд ажиллах хугацаа бага.

Тийм учраас бид бүхэн үүнийг шаардлагад нь нийцүүлээд аль болох засгаас өргөн мэдүүлсэн бүгдийг нь дэмжихийг бодсон. Үнэхээр хангаагүйг нь өөрсөдтэй нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас тайлбарыг нь авч байгаад шийдээд явсан гэсэн үг.

Энэ судалгаа, тооцоо байхгүй, хаанаас санхүүжих нь тодорхойгүй, төсөв нь байхгүй.

Тийм учраас үүнийг хэрэгжих боломжгүй байна л гэж үзэж байгаа юм. Бусад бодлогын баримт бичгүүд энэ бүгдээрээ тусгагдсан байгаа шүү дээ. Ганцхан 2026 он дээрээ шаардлагыг нь хангаж оруулж ирээгүй байна л гэдэг үндэслэл болно.

Тэгэхээр 2026 ондоо амжуулж хэрэгжүүлэх л ёстой юмнуудаа бэлтгэлээ л хангах ёстой байхгүй юу. Нэгэнт 5 жил, 4 жилийн хөтөлбөрт орсон байгаа зүйлийг энэ жилд нь хэрэгжүүлэх бэлтгэл, судалгаа тооцоогоо хийгээд ороод ирсэн бол бүгдийг нь дэмжээд явж байгаа юм. Оруулж ирээгүй учраас дэмжих боломжгүй. Тэгвэл хууль зөрчсөн болоод байгаа учраас бид хууль зөрчсөн санал хурааж болохгүй байгаа юм.

Р.Сэддорж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам тайлбар авъя. Байна уу? Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат дарга. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат.

Энэ төсөл бол их чухал төсөл учраас бид хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж энэ төслийн 2, 3 дугаар хавсралтад орсон.

Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд яг эцсийн санхүүжилт нь тодорхойгүй байгаа учраас санхүүжилт нь тавигдаагүй.

Тийм учраас ажлын хэсэг дээр ийм санал гараад явж байгаа юм. Тийм.

Р.Сэддорж: Санал хураалт. Боомтын сайд Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга орж ирсэн байна.

Санал хураалт. 23 дугаар санал хураалт.

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

24.Төслийн 2 дугаар хавсралтын “3.15.1.5.Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газрыг байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.8.Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газрыг байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

13-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

25.Төслийн 2 дугаар хавсралтын “3.16.3.2.Бичигт боомтод ачааны терминал байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.9.Бичигт боомтод ачааны терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

26.Төслийн 2 дугаар хавсралтын “3.16.3.3.Хавирга боомтод ачааны терминал байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.10.Хавирга боомтод ачааны терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

27.Төслийн 2 дугаар хавсралтын “4.2.1.11.Засгийн газраас хэрэгжүүлж буй "Мега" төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчнийг оролцуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “4.3.5.Засгийн газраас хэрэгжүүлж буй "Мега" төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчнийг оролцуулна.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ ажлын хэсгийн дарга энэ юуг нь өөрчилж байгаа юм? М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Энэ мөн адилхан. Хавсралт дээр ямар нэгэн тоо, шалгуур үзүүлэлт дээр нь тавиагүй.

Тийм учраас үүнийг тэргүүлэх чиглэл рүү нь оруулаад, хэрэгжүүлэхийг нь бодлогоор Засгийн газраас өргөн мэдүүлснийг дэмжье. Гэхдээ энэ дээр шалгуур үзүүлэлт дээр нь тоо байхгүй. Энэ нь бас тодорхой шалтгаантай юм билээ. Тийм учраас тэргүүлэх чиглэл рүү нь оруулсан.

Р.Сэддорж: Санал хураалт.

28.Төслийн 2 дугаар хавсралтын “4.15.1.2.Үндэсний хиймэл дагуул хөөргөх бэлтгэл ажлыг хангах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1

дүгээр хавсралтад “4.5.6. Үндэсний хиймэл дагуул хөөргөх бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

29.Төслийн 2 дугаар хавсралтын “2.12.1.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг төслийн 1 дүгээр хавсралттай давхцаж байгаа тул хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Г.Лувсанжамц гэсэн микрофон дээр хэлье. Тайлбарлая.

П.Батчимэг гишүүн орсон байгаа юу? Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Энэ бас яг адилхан. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа 1 дүгээр хавсралт дээр байхад хангалттай зүйлийг 2 дээр оруулж ирсэн буюу урсгал зардал. Жишээ нь, зохион байгуулах ажил ч байдаг юм уу, бэлтгэл ажлыг хангах гэсэн зүйлүүд 2, 3 дугаар хавсралт дээр орж ирэх ёсгүй. Тэгээд оруулаад ирсэн байсан. Хөгжлийн төлөвлөгөөний хувьд бид ямар шаардлага хангасан байх ёстой гэдгээр нь хуулийнх нь дагуу засаж өгч байгаа л асуудал.

Түүнээс биш хийхээ болино, хэрэгжүүлэхгүй гэсэн тийм зүйл ерөөсөө байхгүй. 1 дүгээр хавсралт дээрээ бүгдээрээ байгаа. Хэрэгжүүлэх боломжтой, хэрэгжинэ бэлтгэл ажил хангагдана.

38 дугаар санал хүртэл бүгд яг ийм зарчмын ажлын хэсгээс гаргасан саналууд байгаа.

Р.Сэддорж: 29 дүгээр санал дээр санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

30.Төслийн 2 дугаар хавсралтын “3.3.1.4.Арьс, шир боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /Дархан арьс, ширний цогцолбор/” гэсэн төсөл, арга хэмжээний “Дархан арьс, ширний цогцолбор” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Тайлбарлая. Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Энэ бас яг адилхан. Нэрийг нь л өөрчилж байгаа болохоос биш төсөл бол хэрэгжинэ. Тийм. Дархан гэдэг нэрийг нь л авч байгаа.

Яагаад гэхээр Хөдөө аж ахуйн яамнаас тайлбар хийсэн. Хувийн хэвшлээрээ хэрэгжүүлж байгаа төсөл дээр улсаас хөрөнгө оруулалт тавиад явдаг. Дараа нь төсвөө зарцуулъя гэхээр болдоггүй. Өмнө нь бас өнгөрсөн жил яг ийм нөхцөл байдал үүссэн гэсэн.

Тэгэхээр энэ нэрийг нь сольж өгөх юм бол бид хэрэгжүүлэх боломжтой гэсэн яамны тайлбар байсан учраас энэ нэрийг нь л засаж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Хөдөө аж ахуйн яам. Хэдэн номер вэ? 5 номер дээр суучих. 5 номер.

Ц.Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Өчигдөр ажлын хэсэг дээр үүнийг бүхэлд нь хасъя гэдэг санал хураагаад уг нь дэмжсэн шүү дээ. Тэгээд одоо болохоор зөвхөн “Дарханы арьс ширний цогцолбор” гэсэн хэсгийг нь хасъя гэсэн байна.

Р.Сэддорж: 5 номер. Дахиад тодорхой тайлбарлая.

Ц.Болорчулуун: Арьс, шир боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих гээд энэ саналыг нөгөө хувийн хэвшил хийж байгаа учраас бүхэлд нь хасъя гэдэг томъёоллоор санал хураагаад дэмжсэн байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр зөвхөн нэрийг нь хасъя гэдэг байдлаар орсон явж байна.

Тэгэхээр бүхэлд нь хасъя гэдгээр л хасуулах саналтай байгаа.

Р.Сэддорж: 5 номер тодорхой тайлбарлаад, гишүүдийн эргэлзээг тайлаадах даа. 5 номер.

Ц.Болорчулуун: Энэ Дарханы арьс, ширний цогцолбор байгуулах гээд хувийн компанийн хийж байгаа ажил.

Энэ дээр яамны оролцоо байхгүй. Яамны оролцож хийж байгаа ажил нь “хөнгөн, хүнсний үйлдвэр, технологийн парк” гэдгээр явж байгаа учраас энэ дээр төсөв тавиад явахаар санхүүжих боломжгүй гэдгээрээ бүхэлд нь хасъя гэдэг саналыг өчигдөр хураалгасан байгаа.

Улсын төсөв дээр мөнгө тавиад энэ санхүүжих боломжгүй шүү дээ.

Р.Сэддорж: М.Мандхай гишүүн горимын санал.

М.Мандхай: Ц.Болорчулуун дарга төсвийн төлөлт дээр чинь 3.3.1.4 дээр арьс, шир боловсруулах үйлдвэрийг нь дэмжинэ, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гээд хаалт дотор Дархан арьс, ширний цогцолбор гэсэн.

Тэгээд энэ дээр чинь өөрөө 33.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн төсөвтэй мөртлөө энэ жил 13.5 тэрбум төгрөгийг зарцуулна гээд төсөвтэй юм байна шүү дээ, энэ чинь. 33.3 тэрбум төгрөгийн төсөвтэй.

Үгүй үгүй. Тэгэхдээ ийм байхгүй юу. Хөнгөн үйлдвэр биш ерөөсөө арьс, шир боловсруулах үйлдвэр гэдэг нэрээрээ явж байна. Зөвхөн хаалт дотор л Дархан гэдгийг тодотгосон байгаад байгаа байхгүй юу. Түүнээс биш Дарханы арьс, шир гэсэн юм бол байхгүй байна л даа.

Миний ойлголтоор хэрэв тэгж байгаа бол энэ хаалт дотор байгаа тодотгож байгаа Дархан арьс, ширний цогцолбор гэдгийг л хасъя гэдэг санал оруулсан юм байна. Ажлын хэсэг. Зөв үү?

Энэ тэгэхээр чинь өөр улсын үйлдвэр яваад байгаа биз дээ.

Р.Сэддорж: 5 номер.

Ц.Болорчулуун: Улсын үйлдвэрийн газрын нэр нь болохоор “Дарханы хөнгөн, хүнсний үйлдвэр, технологийн парк” гэж явж байгаа юм. Хувийн компанийнх болохоор “Дархан арьс, ширний цогцолбор” гэж явж байгаа юм.

Тэгэхээр “хөнгөн хүнсний үйлдвэр, технологийн парк” дээр 23 тэрбум төгрөгийн төсөвтэй. Энэ жил 7.1 тэрбум төгрөгтэй ингээд тусдаа явж байгаа төсөл байхгүй.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч саналаа томъёолоодох.

М.Бадамсүрэн: “Дарханы арьс, ширний цогцолбор” гэдэг хувийн компанийн нэр байна. Энэ нэрийг нь хасъя. Ер нь арьс, ширний үйлдвэр хэрэгтэй гэж өчигдөр ярилцсан.

Гэхдээ Байнгын хороон дээр үүнийг тухайн салбарынх нь мэдээллийг нарийвчилж аваад эцсийн байдлаар шийдье гэж ийм санал гарсан байгаа.

Тэгэхээр маргаантай байгаа, тэгээд хувийн хэвшлийн компанийн нэр байгаа учраас үүнийг бүхэлд нь хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзээд хасъя гэсэн томъёоллоор санал хурааж өгөөч ээ. Байнгын хороон даргад.

Р.Сэддорж: Ингээд 30 дугаар санал хураалт.

Төслийн 2 дугаар хавсралтын 3.3.1.4 арьс, ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн

үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэсэн төсөл, арга хэмжээг бүхлээр нь хасахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

31.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.1.6.Дарханы үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

М.Бадамсүрэн гишүүн, ажлын хэсгийн дарга тайлбарлая.

М.Бадамсүрэн: Энэ Дарханы үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх гэдэг бол төсөв шаардагдахгүй ажил.

Энэ зүгээр л яамны зохион байгуулалтын ажлыг энэ төлөвлөгөө дээр жагсаалтад тусгасан учраас бид үүнийг шаардлагагүй гэж үзээд хасъя гэж.

Зөвшөөрөл олгох асуудал энэ урсгал өөрийнх нь зохион байгуулах л ажил шүү дээ. Ийм шаардлагагүй юмыг улсын хөгжлийн төлөвлөгөө дээр ийм юмыг оруулах ямар шаардлага байна гэж үзэж байна.

Р.Сэддорж: Ямар яам оруулсан юм? Тэрийгээ яамдууд хэлчих. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам.

Манай яамнаас яг нэмэлт саналаар ирсэн бичиг нь байгаа. Тэгээд би бичгийг нь Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлье.

Р.Сэддорж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирсэн юм уу?

Ц.Эрдэнэбат: Тийм. Тайлбар нь болохоор бодлогын баримт бичиг дээр заавал тусгаж өгөөч ээ гэсэн хүсэлтээ ирүүлсэн. Юу гэсэн гэхээр ингэж байж бид энэ зөвшөөрлөө авахгүй бол энэ ажил нь удаад явахгүй байгаа юм гэсэн тайлбартайгаар ирээд, ингээд яамных нь саналаар оруулсан юм.

Р.Сэддорж: Ингээд 31 дүгээр асуудлаар санал хураалт. Ажлын хэсгийн 31 дүгээр саналаар санал хураалт. Хасъя гэсэн.

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

32.Төслийн 2 дугаар хавсралтын “3.5.2.7.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөх” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ дээр тайлбараа өгөөч ажлын хэсгийн дарга аа.

М.Бадамсүрэн: Мөн л адилхан. Бид нэг л юмыг сайн ойлгоё. Төслийн 2 дугаар хавсралт гэдэг бол өөрөө шалгуур үзүүлэлттэй байх ёстой. Тэгээд шалгуур үзүүлэлт дээр ямар ч шаардлага хангаагүй, тоо байхгүй, хоосон.

Тэгэхээр зарим боломжтой зүйлүүдийг нь тэргүүлж чиглэл рүү нь оруулаад, давхацсан буюу эсвэл өөрөө урсгал хийх боломжтой энэ зүйлүүдийг нь энэ дээрээ тусгах шаардлагагүй гэж үзэж байгаа юм. Нэг.

Хоёр гэвэл энэ үндсэндээ Эдийн засгийн яамны боловсруулж, Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хөгжлийн төлөвлөгөө гэдэг бол нэн шаардлагатай чухал улс орны жилийн хөгжлийн бодлогын зорилтуудыг оруулах ёстой болохоос биш урсгал, байнга хийгддэг өөрийнх нь эрхлэх асуудлын хүрээнд байгаа ийм өдөр тутмын ажлыг оруулахгүй л гэж бид үзсэн юм.

Р.Сэддорж: Нэмэлт тайлбар. Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: М.Бадамсүрэн ажлын хэсгийн ахлагчийн хэлж байгаатай яг адилхан.

Энэ 2 дугаар хавсралтаар орох зүйл биш. Угаасаа хийх ёстой ажил нь. Яамдын.

1 дүгээр хавсралт дээр 3.5.2 дээр хайгуулын ажлыг өргөжүүлж, геологийн нөөцийг нэмэгдүүлж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн олголтыг эрчимжүүлнэ гээд орсон байгаа.

Тэгэхээр 1 дүгээр хавсралтад орсон төсөв шаардлагагүй зүйлийг 2 дугаар хавсралтаар оруулах хэрэггүй.

Тэгэхээр хөгжлийн төлөвлөгөө ямар байх ёстой. Түүгээрээ л хийж байгаа. Үүнийг 2 дугаар хавсралтаас хассанаараа хайгуулыг болино, ашиглалтыг багасгана гэсэн тийм юм бол болохгүй гэсэн үг. 1 дүгээр хавсралтын тэргүүлэх чиглэл дээр “эрчимжүүлнэ” нэрээр орсон байгаа.

Р.Сэддорж: 32 дугаар санал дэмжигдсэн.

33.Төслийн 2 дугаар хавсралтын “3.14.1.4.Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг татварын бодлогоор дэмжих” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.1.11.Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг татварын бодлогоор дэмжинэ.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

34.Төслийн 2 дугаар хавсралтаас “4.1.1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

О.Батнайрамдал гишүүн тайлбар өгчих.

О.Батнайрамдал: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг энэ хэрэгжиж байгааг бол ажлын хэсэг бүгдээрээ 100 хувь дэмжиж байгаа.

Тэгээд яг 1 дүгээр хавсралт дээр 4.4.1 дээр авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх гээд энэ агуулга байгаа.

Тийм учраас зүгээр давхар нөгөө 2 дугаар хавсралт дээр давхцаж орох шаардлагагүй учраас үүнийг 2 дугаар хавсралтаас хасах гэсэн томъёоллоор орсон байгаа шүү гэдгийг бас тайлбарлая. Гишүүддээ.

Р.Сэддорж: 34 дүгээр санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

35.Төслийн 2 дугаар хавсралтын “4.8.1.1.Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэн архивын үйлчилгээн дэх нэгдсэн цахим системийг нэмэгдүүлэх” гэсэн төсөл, арга хэмжээний “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг” гэсэн баганад “2,155.00” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

36.Төслийн 2 дугаар хавсралтын “4.16.1.1.Улсын хэмжээний тооллого, түүвэр судалгааг зохион байгуулах” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Төслийн 1 дүгээр хавсралтад “4.1.5. Улсын хэмжээний тооллого, түүвэр судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

37.Төслийн 2 дугаар хавсралтын “3.14.1.6.Төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилттэй инновацын төслүүдийг хэрэгжүүлэх” гэсэн төсөл, арга

хэмжээний Үндсэн хариуцагч баганын “Эдийн засаг, хөгжлийн яам” гэснийг “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

3 номер дээр тайлбар хэлье гэсэн. 3 номер.

Д.Баттогтох: Эдийн засаг, хөгжлийн яам, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох.

Энэ 37, 38 дугаар арга хэмжээ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 4 жилийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр хариуцагч нь Эдийн засаг, хөгжлийн яамаар тусгагдаад батлагдсан байгаа.

Тэгээд энэ ажил маань үндсэндээ инновацын асуудал бол салбар дундын асуудал.

Тийм учраас шинжлэх ухаан, технологи, оюуны өмчийн асуудал дээр нь эдийн засгийн асуудлууд Эдийн засаг, хөгжлийн яам дээр шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын хүрээнд зохицуулагдаж явж байгаа учраас Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар нь үлдээх ийм саналтай байгаа.

Ер нь энэ санхүүжилтийг бид Шинжлэх ухаан, технологийн сангаа өөрчлөлт оруулах байдлаар инновацын хамтарсан санхүүжилттэй төслүүдийг дэмжих ийм зохицуулалтаар анхнаасаа төлөвлөөд явж байсан юм.

38 дугаар асуудал дээр мөн ялгаа байхгүй. Ер нь Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан нэгжүүдээс тэдний харьяа байгууллагуудаас үндсэн мэдлэгийг бүтээдэг. Түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлээд инновац бий болгох ёстой.

Тэгэхээр тэр тогтолцоо үндсэндээ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр зохион байгуулалт хийх бүрэн бололцоотой байгаа.

Тэгэхээр энэ агуулгаасаа 38 дахь агуулга бол бид анхнаасаа 4 жилийн хөтөлбөр, тэрийг дагасан төлөвлөгөө дээр хариуцагчаар нь Эдийн засаг, хөгжлийн яам гээд явж байсан.

Тэгэхээр энэ агуулгын хүрээнд гишүүдээс хариуцагчийг нь хэвээр үлдээж дэмжих саналыг одоо дэмжихгүй байх талаас нь анхаарч өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Р.Сэддорж: 9 номер. Нөгөө Цахим хөгжил, инновац технологийн яамнаас тайлбар. 9 номер.

П.Алтан-Од: Гишүүний асуултад хариулъя. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од.

Өчигдөр ажлын хэсэг дээр энэ санал гарч ирэхдээ инновацын тогтолцоо, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх ажил нь цахим яаман дээр Засгийн газрын тухай хуулиараа чиг үүрэг нь ирсэн.

Сая өнгөрсөн долоо хоног Засгийн газрын хуралдаанаар инновацын шийдэл, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх журмыг батлуулсан.

Цаашид бүх яамд дээр ер нь инновацын төсөл, хөтөлбөрүүд явж байгаа. Гэхдээ гол санхүүжилтийн эх үүсвэр нь хаана явах вэ гэдгийг Засгийн газар сая хуралдаанаараа журмаараа тогтоогоод өгсөн.

Инновацын сантай болох асуудал энэ 37, 38 дээр бас давхар хөндөгдөж байгаа.

Тэгэхээр инновацын сангийн асуудал ирэх жил хэрэвзээ бий болох юм бол мэдээж бас энэ чинь үндсэн Засгийн газрын чиг үүрэгт байгаа Цахим хөгжлийн яам талаасаа батлагдаж орж явах байх гэдэг байдлаар санал орж Их Хурлын гишүүд маань ажлын хэсэг дээр дэмжсэн байгаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн гишүүн. Энэ хоёр саналыг хасах уу, яах вэ?

М.Бадамсүрэн: Энэ Цахим хөгжлийн яамны Төрийн нарийн өчигдөр ажлын хэсэгтээ танилцуулга хийгээд, яг энэ тайлбараа өгөөд, түүний дагуу бид ажлын хэсэг шийдсэн. Олонхын саналаар.

Ер нь бол нэг зарчим баримталсан. Ажлын хэсэг холбогдох Засгийн газар, түүний харьяа яамдын санал дээр тулгуурлаж төсөл, арга хэмжээнд нь өөрчлөх. Энэ дээр мөн бидний асуусан асуултад хариулаад, тэр нь үнэхээр боломжтой байвал дэмжээд л ингээд явсан байгаа.

Тэгэхээр энэ бол хоёр яам та хэд хоорондоо арай хол суусан байна. Уг нь цуг суугаад яриад тэгээд үүнийгээ шийдээд явах ёстой шүү дээ.

Тэгэхээр өчигдөр нэг ийм юм ярьчихаад, тэгээд өнөөдөр болохоор өөр юм яриад байх юм. Энэ Эдийн засгийн яам, Цахим хөгжлийн яам хоёр чинь хоёулаа удирдах албан тушаалтнууд нь байж байгаад өчигдөр үүнийг нь шийдсэн биз дээ.

Тэгээд цахимын Төрийн нарийн нь ийм санал гаргая гэхэд Эдийн засаг, хөгжлийн яам нь тэрийг нь зөвшөөрөөд эсэргүүцээгүй шүү дээ. Тэгээд өнөөдөр болохоор ингээд хэдэн цагийн дараа, 24 цаг хүрэхгүй хугацаанд орж ирээд өөр юм яриад байх юм.

Бид нарт хэрэгжилт нь чухал болохоос биш, тийм ээ Эдийн засгийн яам уу, Цахим хөгжлийн яам уу гэдгийг чинь тэр засгийнхаа бодлогын дагуу л та нар оруулж ирэх ёстой шүү дээ.

Тэгээд ийм дэмий юман дээр. Ер нь ташрамд хэлэхэд ийм юман дээр цаг алдаад байгаа юм. Байнгын хороон дарга аа. Ер нь яг үнэндээ энэ оруулж ирсэн зүйл дээр чинь бид маш их ажиллаж байж үүнийг чинь хуулийн шаардлагад нийцүүлж байгаа байхгүй юу.

Ер нь хуулийн шаардлагад нийцээгүй зүйлийг өргөн барьсан гэдгийг энд тодотгож хэлэх нь зүйтэй.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч өөрөө саналаа хэллээ. Энэ хоёрыг хураах юм уу, татах юм уу?

М.Бадамсүрэн: Цахим хөгжлийн яаманд нь тэр хэрэгжүүлэх гэж байгаа яамныхан Төрийн нарийн үүнийг манайх хэрэгжүүлнэ, Засгийн бодлого ингээд гарсан гээд байгаа. Тэрийг бид дэмжинэ шүү дээ. Энэ оруулж ирсэн томъёоллоор санал хураая гэсэн саналтай.

Р.Сэддорж: Санал хураалт. Шинэ яам нь шинэ л байгуулагдсан биз дээ.

Эдийн засаг, хөгжлийн яам ч гэсэн одоо энэ чинь байгуулагдаад хэдэн жил болж байна? Тийм. Тэгээд Их Хурлын гишүүд л шийд саналаа өгөөд л шийднэ шүү дээ.

Ингээд 37 дээр санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

38.Төслийн 2 дугаар хавсралтын “3.14.1.9.Инновацийн сангаас технологи, инновацийн бүтээгдэхүүн болон инновацийн дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төсөл, арга хэмжээний Үндсэн хариуцагч баганын “Эдийн засаг, хөгжлийн яам” гэснийг “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

39.Төслийн 2 дугаар хавсралтын 2.9.1 дэх заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.3.2. ЗГҮАХ-2.1.1.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Монгол Улсын хэмжээний бүх сургуулийн бага ангийн нийт сурагчдын 30-аас доошгүй хувийг хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу гадаад хэл суралцах спортоор хичээллэх авьяас, ур чадвараа нээх, хувь хүнийг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийн сургалтад хамруулах зорилгоор бүх хэвшлийн сургалтын төв, дугуйлангууд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр

хэрэгжүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан хүүхэд” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь түвшин “0” гэж, “Зорилтот түвшин “114000” гэж, Нийт санхүүжилтийн дүн “18,810.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “18,810.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв болон бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 2.9.1.1 дэх заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтаас өмнө ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт, хүүхдийн хөгжлийн талаар илүү анхаарах ёстой гэдгийг Засгийн газраас баримталж байгаа.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хамгийн сүүлийн хуралдаанаараа ийм зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээндээ хүүхдийн хөгжлийн асуудлыг чухалчилж байгаа учраас энэ зүйлийг ажлын хэсэг дэмжсэн.

Энэ 114 мянган бага ангийн хүүхдүүдийг хамруулна. Энэ нь нийт Монгол Улсын хэмжээний бүх сум, суурин газар, нийслэл, аймаг, сумын хүүхдүүдийн 30-аас доошгүй хувь байна.

Тэгээд санхүүжилт нь улсын төсөв болон үндэсний баялгийн сангаас үүнийг шийдвэрлэх гэсэн ийм томъёоллоор үндсэндээ орж байгаа.

Дээр нь орон нутгийн төсөв байж болно. Санхүүжилт дээр ийм тайлбар хэлье.

Энэ 114 мянгыг нэг хүүхдийг 5 сарын туршид сард 30 мянган төгрөгийн дэмжлэгтэй сургахад 150 мянга гэж тооцоод энэ дүн гарсан байгаа.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Үндэсний баялгийн сангийн төсөв дээр гэж оруулж ирэхийн тулд тэр Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээрээ бас харах ёстой байх.

Тэгээд яах вэ, энэ бол нөгөө ноднингийн төсөв дээр яригдсан ваучертай бас их төстэй арга хэмжээ харагдаж байна. Тэгээд яг хаанаас санал нь орж ирсэн юм бол гэдэг асуулт байгаад байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Засгийн газрын үйл ажиллагааны ирэх 4 жилийн хөтөлбөр дээр энэ заалт байгаа. Батлагдсан байгаа.

Тэгээд энэ хүрээндээ ажлын хэсгийн гишүүний хувьд энэ зарчмын зөрүүтэй саналыг миний хувьд, Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд гаргасан. Ингээд ажлын хэсэг дэмжсэн санал байгаа юм.

Ер нь хэрэгжих боломжтой гэж үзэж байгаа. Ер нь болно. Туршигдсан, хэрэгжсэн ийм жишгүүд байна.

Р.Сэддорж: Энэ бол дэмжих эрхтэй санал. Манай гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Санал хураалт. /алх цохив/

15-аас 6 гишүүн санал өгч, санал дэмжигдсэнгүй.

40.Төслийн 2 дугаар хавсралтын 2.10 дахь хэсэгт Бодлогын үндэслэл “АХ-2.3.2, ЗГҮАХ-2.1.1.5, 2.1.1.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулж, санхүүгийн урамшуулал болон техник, тоног төхөөрөмжөөр хангах хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан ажилтан” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1900” гэж, Нийт санхүүжилтийн дүн “9,120.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “9,120.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж 2.10.1.3 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Асуулт П.Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтан гэж бас орон тоо байдаг юм уу? Тийм ээ. Тэгээд энд бас л санхүүгийн урамшуулал гээд л ороод ирлээ.

Тэгэхээр үүнийг ямар хэмжээний санхүүгийн урамшууллийг тэр хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтан гэдэгт олгох гэж байгаа юм бэ? Энэ дээр тодруулга авъя.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт орж энэ хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудтай болсон. Бүх аймгийн төвийн баг, хөдөө сумдад.

Дээр нь одоо энэ салбарын зүгээс ямар санал дэвшүүлж байна гэхээр хүүхэд хамгааллын ажилтнуудын цалин урамшуулал хэт бага байгаагаас ерөөсөө тогтворгүй байна.

Тийм учраас урамшууллын хэмжээг нэмэгдүүлж, ажиллах нөхцөл боломжоор хангахгүй бол хүүхэд хамгааллын асуудал ер нь орхигдоод байна. Сумдад бараг мал аж ахуй хариуцсан 5 хүнтэй мөртлөө нэг ч хүн байхгүй байна.

Тэгээд тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд үүнийг дэмжиж, тоног төхөөрөмж, ажиллах нөхцөл боломж, урамшууллаар дэмжье. Хүүхэд хамгааллын асуудал их хүнд байна шүү. Хүүхдийн хүчирхийллийн эсрэг зүйл дээр онцгой анхаарахгүй бол болохгүй байна гэдэг ийм саналыг дэвшүүлсэн. Тэр дагуу л энэ явж байгаа гэж ойлгож болно.

Р.Сэддорж: П.Батчимэг гишүүн тодруулж асууя.

П.Батчимэг: Хуулиараа хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтан гэж бий болсон гэж ойлгож болно.

Гэхдээ бас энэ чинь дүүрэг, хороон дээр бас тийм орон тоо бас байдаг. Хараа хяналтгүй хүүхдүүдийг. Гэхдээ хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудад олгох санхүүгийн урамшуулал гэж оруулсан нь сум, багт яг ийм орон тоо хэрэгтэй байгаа байхгүй юу. Багийн асуудал илүү тэнд харагдаж байгаа юм. Сум, баг эзэнгүй байгаа шүү дээ. Ерөөсөө баг дээр.

Тийм учраас бараг багийн асуудлаа илүү анхаарч өгч, багийн асуудлыг энэ дээр оруулбал илүү үр дүнтэй болох байх гэж бодож байна.

Р.Сэддорж: Яамнаас хүн байна уу? Хариулт 5 номер.

Б.Алимаа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа. Гишүүний асуултад хариулъя.

Хүүхэд хамгааллын хууль батлагдаад хэрэгжиж байгаа. Улсын хэмжээнд 2025 оны 01 сараас эхлээд 630 “хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” гэж орон тоогоор шинээр ажиллуулж эхэлсэн.

Одоогийн байдлаар сум, хороо болгонд ажиллахаар төлөвлөгдөөд явж байгаа.

Одоогоор Төрийн үйлчилгээний албан хаагчдын ангилал, зэрэглэлээр цалин хөлсөө аваад явж байгаа. Цаашдаа тоног төхөөрөмж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах асуудал маш хүндээр тулгамдаж байгаа.

Тийм учраас энэ асуудлыг бас оруулж ажлын хэсэг дэмжсэн байх гэж бодож байна.

Р.Сэддорж: Санал хураалт. 40 дүгээр санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

41.Төслийн 2 дугаар хавсралтын 3.Эдийн засгийн бодлого хэсгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “3.19.Бичил, жижиг, дунд бизнесийн эдийн засагт оруулах хувь нэмэг нэмэр нэмэгдсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр

дүн “3.19.1.Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоо өсөж, ажлын байр нэмэгдэн, импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-3.3.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “3.19.1.1.Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих, урт хугацаатай бага хүүтэй зээлийн хүртээмж, бүтээгдэхүүний төслийг нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Улсын хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний эзлэх хувь” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “5.5” гэж, Зорилтот түвшин “7” гэж, Нийт санхүүжилтийн дүн “58 тэрбум” гэж, тухайн жилд шаардагдах санхүүжилт “58 тэрбум” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв болон бусад эх үүсвэр” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 3.19.1.1 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Тайлбар Б.Жаргалан гишүүн.

Яам гишүүдэд тайлбарлая. Саяын саналыг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Ажлын хэсгийн гишүүд гарч явахгүй шүү. Ц.Болорчулуун даргыг дуудъя.

Тэгвэл үүнийг хасах юм уу?

42.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, 8.1.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум, Хөх нуур чиглэлийн хатуу хучилттай 50 км авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Зам, барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “115 тэрбум” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “38.3 тэрбум” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

42.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.2 дахь заалтад Төсөл, арга хэмжээ “Чойбалсан нисэх буудлын хөөрөх буух зурвасыг шинэчлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “79,068.9” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “26,356.3” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж 1.9.2.3 дахь дэд заалтыг өөрчлөн найруулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсгийн дарга тайлбарлая. Энэ одоо шинээр барих гэж байгаа юу? Эсвэл өргөтгөх гэж байна уу?

М.Бадамсүрэн: Энэ өөрчлөн найруулж байгаа нь оруулж ирсэн төслөөрөө төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ гэж заасан байсан.

Дээр нь 4 нисэх буудлийг нэгтгээд заасан байсан. Үүнээс Чойбалсан нисэх буудлын зөвхөн хөөрөх, буух зурвасыг нь шинэчилье. Барилга, байшин тэр бусад юмнууд шаардлагагүй.

Чойбалсан хот руу онгоц нисэх боломжгүй байгаа. Яагаад гэвэл хөөрөх, буух зурвас нь шаардлага хангахгүй байгаа. Тэгээд зүүн бүсийн хамгийн алслагдмал аймаг. Энэ үүднээсээ зураг төсөв, ТЭЗҮ, магадлал, бүх юм нь шаардлагаа хангасан энэ төслийг улсын төсвөөс санхүүжүүлээд, зөвхөн зурвасыг нь шинэчилье гэдэг ийм саналыг ажлын хэсэг дэмжиж оруулж ирж байгаа юм.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Энэ оруулж ирсэн хөгжлийн төлөвлөгөөнд туссан 1.9.2 дугаар заалт нийт 4 нисэх буудлын асуудлыг хөндсөн байхад энэ дээр зөвхөн Чойбалсанг тусад нь аваад, өөр санхүүжилт тавьж байна гэж ойлгоод байна л даа.

Тэгэхээр бодлого алдагдах юм биш үү гэдэг санаа байна.

Р.Сэддорж: Тайлбарлая. Зам, тээврийн яамнаас байна уу? 8 номер. Сайдуудыг дуудъя.

Г.Батбаяр: Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр байна.

Дорнод аймаг зүүн талын алслагдсан аймаг байгаа. Аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлагын дагуу бид нисэх буудлын хөөрч, буух зурвасыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс ирсэн ажлын даалгаврын хүсэлтийн дагуу бид ажлын даалгавар боловсруулаад өгсөн. Одоо зураг төсөл нь хийгдэж байгаа.

Тэгэхээр үүнийг шийдэх нь зүйтэй үзэж байгаа. Зам, тээврийн яамнаас Дорнод аймгийн нисэх буудал, Ховд, Өмнөговь, Увс аймгийн нисэх буудлуудыг өргөтгөж шинэчлэх ажлыг дэмжиж бодлогоор оруулсан.

Р.Сэддорж: 8 номер нэмж хариулъя. Тодорхой хариулаарай. Гишүүний асуултад.

Г.Батбаяр: Манайх бүгдийг нь л оруулна гэдгээрээ л дэмжиж байгаа. Бид бүгдийг нь л гэдгээрээ явж байгаа шүү дээ.

Р.Сэддорж: 43 дээр Чойбалсангийн нисэх онгоцны буудлын талаарх санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ц.Болорчулуун дарга гарч явсан учраас энэ 41 дэх санал дээр тайлбар авъя. 9 номер. Ажлын хэсгийн гишүүд гарч явахгүй байхыг хүсье.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун гишүүний асуултад тайлбар хэлье.

Тэгээд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээл ер нь 2019 оноос хойш улсын төсөв дээр ерөнхийдөө мөнгө тавигдахгүй байгаа. Дандаа урд олгосон зээлүүдийн эргэн төлөлтөөс энэ зээлүүдийг олгоод жилд 20 орчим тэрбум төгрөгийн зээлийг 21 аймаг, нийслэлд олгоод явж байгаа.

Дээрээс нь бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбоотойгоор бүсийн хурлууд дээр жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, бүсүүдэд, орон нутагт дэмжих тал дээр их хэмжээний эрэлт байна гэдэг хүсэлтүүд гарч байгаа. Өнгөрсөн хурлуудаас дандаа энэ бүстэй холбоотойгоор жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ гэсэн заалтууд тогтоолд ороод байгаа учраас энэ дээр төсөв тавьж өгөхөөр тусгасан байгаа.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: 2025 оны улсын төсөвт зээлийн хүүгийн дотаци гээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр тодорхой нэр бүхий 4, 5 хөтөлбөрийн хүрээнд бараг хагас их наяд төгрөгийн зээлийн хүүгийн дотаци тавигдсан явж байгаа.

Би ер нь зарчмын хувьд зээлийн хүүгийн дотаци тавиад, зарим аж ахуйн нэгжид 3 хувийн хүүтэй зээл өгөөд, бусад аж ахуйн нэгж нь бүр ингээд 30-аас дээш хувийн зээлтэйгээр ажлаа хийгээд явж байгаад давхар зах зээл үүсгэж байгаа явдал Монголын бизнесүүдийн өрсөлдөх чадварыг бүр улам хумьж байгаа гэсэн ийм байр суурьтай байдаг.

Тэгээд нөгөө жижиг, дунд үйлдвэр сан дээр юу болсныг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр давхар зах зээл үүсгэж, улсын төсөв дээр дотаци тавих тусмаа улс төрд ойрхон, шийдвэр гаргах түвшинд ойрхон нөхөд зээл аваад, тэгээд манай энэ бизнесийн салбар чинь ерөөсөө давжаараад, өрсөлдөх чадваргүй болоод, тэгээд дандаа ийм давхар зах зээлүүд үүсээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ энэ бодлогоо өөрчлөхгүй юм уу? Нийтээр нь зээлийн хүүгээ бууруулах хэрэгтэй байна.

Тэгэхээр танай салбарыг дэмжинэ гэж оруулж ирээд байгаа бүх хөтөлбөрүүд чинь эргээд салбараа тэжээвэр болгоод, өрсөлдөх чадваргүй болгоод, тэгээд ерөөсөө тэр экспортод бүтээгдэхүүн гаргах мөрөөдөл ч талаар болоод. Ийм асуудал үүсээд байна. 35 жил бид яг ийм бодлого хэрэгжүүлж ирсэн. Тэр дундаас бойжсон аж ахуйн нэгж нэг ч алга.

Тэгэхээр хэдүүлээ бүр сэтгэлгээний хувьд өөрчлөлт хиймээр байна. Зээлийн хүүг бүр тэнхлэгээр нь буулгах боломж байхад та нар янз бүрийн хөтөлбөр оруулж ирээд л. Одоо тэр жижиг, дунд үйлдвэр сан дээр ахиад 58 тэрбум нэмнэ гэж байна. Тэгээд үүнийг чинь хэн авах юм? Нөгөө улс төрчид нь хувааж авах юм уу?

Тэгэхээр энэ дээр би зарчмын хувьд маш хатуу тийм эсрэг байр суурьтай байгаа. Яагаад гэхээр энэ Их Хурал реформын шинж чанартай өөрчлөлтүүд хийе гэж зорьсон гэж ойлгож байгаа.

Тэгэхээр эдийн засгийн бодлого арай өөрөөр явах ёстой шүү.

Тэгэхээр яамдын бодлого тодорхойлж байгаа дарга нар үүнийгээ хармаар байна. Тэгээд 35 жил бид энэ замаар явж ирлээ шүү дээ. Тэгээд 35 жилийн дотор хөнгөлөлттэй зээл авсан хүмүүс чинь сайжрах нь яасан юм бэ?

ЖДҮ сан дээр гэхэд тухайлах юм бол эргэн төлөлт ч маш муу байгаа. Тэр аудитынхаа дүгнэлтүүдийг хар. Дандаа ийм хязгаарлалттай дүгнэлтүүд авсан.

Тэгэхээр энэ дээр би энэ саналыг эрс эсэргүүцэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: 9 номер тайлбарлая.

Ц.Болорчулуун: Гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

Зээлийн хүүгийн дотациатай санхүүжилтийн схем сүүлийн 35 жил яваагүй гэдгийг бас хэлмээр байна.

Сүүлийн 4 жил арилжааны банкууд дээр байгаа чөлөөт эх үүсвэрийг зах зээлд оруулах чиглэлд төсөвт ачаалал бага байлгах үүднээс зээлийн хүүгийн дотациатай банкуудын эх үүсвэрийг ашигласан зээлийн санхүүжилтээр 2 хөтөлбөр дээр зээл гарч явж байгаа.

Би хариуцлагатайгаар хэлж байна танд.

Тэгээд ер нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд зээлийн

хүүгийн дотациатай явсан. Энэ нь 3 хувьтай биш. Бид Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулж дотацийг олгоод аж ахуйн нэгжүүд дээр очиж байгаа зээл одоо 7-гоос 8 хувьтай.

Зээлийн санхүүжилт явж, энэ хүнсний хөтөлбөр, дээрээс нь энэ оноос хэрэгжиж байгаа “Цагаан алт” хөтөлбөр хоёрыг хэрэгжүүлж байгаа.

Жижиг, дунд үйлдвэр гэдэг бол өөрөө тусдаа хуультай. Нийт борлуулалтын орлого нь 2.5 тэрбум хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа ийм зээлийн эх үүсвэр. Энэ бас арилжааны банкаар явж байгаа.

Яг жижиг, дунд үйлдвэртэй холбоотой аудитын тайлан, бусад ямар нэгэн улсын төсөв болоод Хөгжлийн банкны тэр бүх төлбөрүүдээ Жижиг, дунд үйлдвэрийн газар бүрэн төлж барагдуулсан. Энэ тухай тайланг танд албан ёсоор хүргүүлье.

Р.Сэддорж: М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Яалт ч үгүй Б.Жаргалан гишүүний хэлж байгаа ер нь энэ бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг ер нь улсын түвшинд реформ хийх шаардлага байгаа.

Яагаад гэхээр зээлийн санхүүжилт, урамшуулал ч гэдэг юм уу, эсвэл тухайн бүтээгдэхүүнд өгч байгаа урамшуулал гээд маш олон хэлбэрээр санхүүжилт олгогдоод тэгээд тухайн салбар яг үндсэндээ үр дүн, өгөөжөө өгсөн үү, авсан төсөв нь өөрөө эргээд эдийн засагт хэр хэмжээний өгөөж өгч байгаа вэ гэдэг нь хэмжигдэхэд хангалтгүй байгаа.

Гэхдээ би юу гэж хэлэх гэж байна гэхээр нийт аж ахуйн нэгжийн бараг 70, 80 орчим хувь нь бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид явж байгаа.

Бид өөрсдөө ажилгүйдлийг нэмэгдүүлэхийн тулд бичил жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг орлоготой ажилтай байлгахаас бид нарт өөр сонголт байхгүй байгаа юм.

Тийм учраас бичил жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан ажлын байртай байх, орлоготой байх үүднээс тодорхой хэмжээний хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг улсаас шийдэж өгөхгүй бол энэ хүмүүс чинь одоо үндсэндээ ажил хийх ямар ч хөдөлмөр эрхлэх боломж нь байхгүй.

Тэгэхээр энэ дээр Ц.Болорчулуун дарга хамгийн гол нь энэ төсвөө өөрөө хамгаалахын тулд маш сайн тайлбар хийх хэрэгтэй. Чуулган дээр ч гэсэн. Тэгэхгүй бол үүнийг гишүүд Б.Жаргалан гишүүн шиг буруу ойлгоод. Тийм. Буруу ойлгох юм уу, эсвэл ер нь энэ төсвийг буцаад эргүүлэн татах ийм эрсдэл байгаа байхгүй юу.

Гэхдээ энэ бол яг өнөөдрийн нөхцөл байдалтай харьцуулахад байх шаардлагатай юу гэхээр байх шаардлагатай байгаа юм. Энэ дээр тайлбар сайн хэлж өгөөрэй.

Р.Сэддорж: 41 дүгээр санал хураалт. Санал хураалт. /алх цохив/

15-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

44.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Төсөл, арга хэмжээ “Хэрлэн голын 217,6 у/м төмөр бетон гүүр, 1.0 км авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Зам барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “28,910.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “9,636.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

45.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16.2 дахь заалтад Төсөл, арга хэмжээ “Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос Баянхошуу боомт, Халхгол сум чиглэлийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Зам барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “483,397.4” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “161,132.5” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 хүн дэмжиж, санал дэмжигдлээ.

46.Төслийн 2 дугаар хавсралтын 4.9 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.1.9, ШСБ-6.1, ЗГҮАХ-4.1.5.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорнод аймаг дахь Шүүхийн Тамгын газрын барилга” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “13,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “4,600.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Шүүхийн ерөнхий зөвлөл” гэсэн 4.9.3.1 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Тайлбар. Ажлын хэсгийн дарга.

М.Бадамсүрэн: Дорнод аймгийн шүүх хуучин хүүхдийн дотуур байранд буюу 10 жилийн 1 дүгээр сургуулийн яг залгаа байранд үйл ажиллагаа явуулдаг юм.

Өөрөөр хэлбэл 90-ээд онд өмч хувьчлалын дараа дотуур байрны барилгад шүүх нь ороод, тэгээд яг сургуулийнх нь хажууд шүүх. Ингээд сургууль, цэцэрлэг гээд бүх суурьшлын бүсийн дунд нь байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт нь, өнгөрсөн онд Хууль зүйн байнгын хороо руу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирэх үед газраа шийдэж чадаагүйгээс болоод энэ ганцаараа үлдсэн юм билээ. Тийм үндэслэлээр энэ зүйлийг оруулж ирснийг ажлын хэсэг дэмжсэн.

Р.Сэддорж: Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

47.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл ЗГҮАХ-4.2.4.1, 4.2.4.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар метрополитан бүс дэх Хүннү ухаалаг хотын хөгжлийг удирдах чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төслийг хэрэгжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Бэлтгэл ажлын хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “7,000.0” гэж, Тухайн жилд шаардлагтай санхүүжилтийн хэмжээ “2,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Гадаад тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар” гэсэн 1.1.1.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

48.Төслийн 2 дугаар хавсралтын 1.4.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “1.4.1.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй хот, суурин газрын тоо нэмэгдсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-4.2.4.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Хороо, багийн хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын бичил, жижиг төслүүдийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр иргэдийн бүлэг, хөршийн холбоо тухайн нэгжийн хувийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Тухайн нэгжийн оршин суугчаар гүйцэтгүүлсэн ажлын нийт төсөвт эзлэх хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх дүн” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “Орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх дүнгийн 30 хувь” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Нийслэлийн засаг даргын Тамгын газар, аймгуудын засаг даргын Тамгын газар” гэсэн 1.4.1.2. дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

49.Төслийн 2 дугаар хавсралтын 3.10 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Байгалийн гамшигт үзэгдлийг судлах, урьдчилан мэдээлэх техник, технологийг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл АХ-9.2.13, ЗГҮАХ-1.4.2.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон зээлийн дэмжлэг үзүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Энергийн хэмнэлтийн улмаас буурсан нүүрс төрөгчийн ялгаруулалт /PM2.5/” гэж, Хэмжих нэгж “мкг/м³” гэж, Суурь түвшинд “194.6” гэж, Зорилтот түвшин “155” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,872,300.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “300,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Орон нутгийн төсөв, гадаадын тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар,” гэсэн “3.10.1.4 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

50.Төслийн 2 дугаар хавсралтын 3.10 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Байгалийн гамшигт үзэгдлийг судлах, урьдчилан мэдээлэх техник, технологийг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.2.13, ЗГҮАХ-1.4.2.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Бүх хот суурин газарт суурин болон зөөврийн станцуудыг шинээр суурьлуулж мэдээллийн нэгдсэн системд холбох” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “21” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,500.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Гадаадын тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэсэн 3.10.1.5 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

51.Төслийн 2 дугаар хавсралтын 1.7.4 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Инженерийн дэд бүтцээр хангагдсан бүс, орон нутаг, сум суурингийн тоо нэмэгдсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.3.2., ШСБ-4.2.1, ЗГҮАХ-2.4.3.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Үерийн далан /Дархан-Уул, Шарын гол/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “10” гэж,

Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “3,592.5” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “3,592.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэсэн 1.7.5.2 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

52.Төслийн 2 дугаар хавсралтын 1.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, ЗГҮАХ-1.3.4.6.” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Уул аймгийн Шарын гол суманд 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “40” гэж, Нийт санхүүжилтийн дүн “473,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “142,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.12 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсгийн дарга тайлбар авъя. Энэ бусад аймгуудынхаа 50 мегаваттын асуудлаа шийдчихээд Дарханыг нэмж байгаа юм уу, эсвэл тусад нь Дарханыг явуулж байгаа юм уу?

М.Бадамсүрэн: Эх үүсвэрийн ангилал нь төр, хувийн хэвшлийн түншлэл нэмэх нь дотоодын хөрөнгө оруулалт.

Өөрөөр хэлбэл төсөв дээр ямар нэгэн ачаалал үүсэхгүй. Төсвийн хязгаарт энэ шаардлагагүй ийм төсөл, арга хэмжээ учраас бид бодлогын хувьд дэмжсэн. Нэг.

Хоёрдугаарт, ажлын хэсгийн баримталсан бодлого импортыг орлох, экспортыг дэмжих эрчим хүчний үйлдвэртэй холбоотой төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийхийг ер нь дэмжээд явъя. Энэ бол төсөвт ямар ч ачаалал өгөхгүй, төсвөөс мөнгө гарахгүй учраас дэмжсэн гэсэн үг.

Р.Сэддорж: Яамнаас хариулт авъя. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдсэн ажил одоогоор нэг ч байхгүй байгаа. Тийм ээ. Яам байна уу? Эрчим хүчний яам яасан юм.

Энд хариулах Засгийн газраас хүмүүс байна уу? Ажлын хэсэг хангалтгүй байна. Зарим яамд алга байна. 2 номер. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулъя.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат.

Төр, хувийн хэвшлийн түншлэл, дотоодын хөрөнгө оруулалтыг Эдийн засаг, хөгжлийн яам бодлогын хувьд дэмжиж байгаа. Гагцхүү яг тэр улсын төсөв, гадаадын зээлтэй хэсгүүд дээр Та бүхэн тоогоо анхаарч үзнэ үү гэсэн хүсэлт байна. Тийм.

Р.Сэддорж: Үүнийг тэгвэл яах вэ? Үүнийг хойшлуулъя. Санал хураалтыг түр байлгаж байя. Хариуцсан хүн нь ирэхээр яая.

53.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, 8.1.2, ЗГҮАХ-3.3.2.16.” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Баянцагаан-Баян чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “109,619.5” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “36,539.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

54.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.1. 8.1.2. ЗГҮАХ-3.3.2.16.” гэж, Төсөл, арга хэмжээ “Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа өртөөний төмөр зам дээгүүр явах 2 урсгалтай гүүрэн байгууламж барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “27,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “9,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.17 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

49 дүгээр санал хураалт дээр энэ 1 их наяд 873.3 тэрбум юм байна. 49 дээр тухайн жилийн санхүүжилтийн хэмжээ нь л 300 тэрбум юм байна.

Энергийн хэмнэлтийн улмаас буурсан нүүрстөрөгчийн ялгаруулалт гэж. Энэ сая санал хураагаад явсан ийм санал байгаа.

Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Энэ 1.8 их наяд нь 2032 он хүртэл төсөвлөсөн.

Яг юу хийх гээд байгаа вэ гэхээр өнөөдрийг хүртэл бид сайжруулсан түлш, утаагүй зуух гээд баахан хэрэглээн дээр дотациуд тавьж эхэлсэн. Энэ дотациудыг бүгдээрэнг нь буцаагаад “дулаалгыг дэмжих” буюу “хэмнэлтийг дэмжих” бодлого руу чиглүүлъя гэж байгаа.

Өнгөрсөн жил Тавантолгой түлш дээр л гэхэд 400 тэрбум төгрөгийн дотациар сайжруулсан түлшийг үйлдвэрлэсэн. Энэ дотацийг л хэмнэлтийг дэмжих бодлого руу явуулъя гэж байгаа.

2026 онд 300 тэрбум төгрөгийг төсөвлөө гэж байгаа. Тавантолгой түлш дээр гэхдээ 400 тэрбум байгаа шүү дээ. Тийм. Тэрийгээ буцаагаад Байгаль орчны яаман дээр “ногоон санхүүжилтийг дэмжье” гэсэн тийм бодлого руу шилжүүлэх юм.

Үүнийг хийх юм бол 2026 ондоо 20 мянган гэр, 20 мянган байшин, 10 мянган эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэсэн ийм зүйлүүд дээр ногоон зээлийн хүүгийн дотаци байдлаар оруулж өгье гэж байгаа юм.

Тэгэхээр өмнө нь дандаа бид мөнгөө шатаагаад байсан бол одоо хэмнэлтийг дэмждэг гэсэн тийм юм руу оръё гэж байгаа тийм санал юм.

Тэгээд сая 3 орныг нь дутуу тавьчихсан байсан болохоор 3 оронг нь нэмж нэмж дахиж санал хураагаад дэмжиж өгөхийг хүсэж байна.

Р.Сэддорж: 49 дүгээр санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн. Г.Лувсанжамц гишүүний саналаар хүчингүй болгох санал хураалт. Эхлээд хүчингүй болгоно. Дараа нь санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүй болсон. 49 дүгээр санал хураалт.

Хамгийн гол нь энэ үнийн дүн бол 1 их наяд 872 тэрбум 300 сая төгрөг юм байна.

Тухайн жилийн санхүүжилт нь 300 тэрбум юм байна. Энэ дээр тайлбар хийх Сангийн яам байна уу? 6 номер. Сангийн яам тайлбар хэлье.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал.

Энэ санал дээр нэгдүгээрт нийт дүн болон тухайн онд санхүүжих дүн маш өндөр байна.

Тэгээд маш олон эх үүсвэрүүд тавьсан. Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад зээл гээд. Жишээ нь, гадаад тусламжууд ирэх он дээр дандаа гэрээ хэлэлцээр нь байгуулагдсан хэрэгжээд явж байгаа төслүүд байгаа.

Тэгэхээр одоогоор гадаад зээлийн тусламжийн эх үүсвэр дээр ямар нэгэн ийм төсөл, арга хэмжээтэй эх үүсвэр төсөл батлагдаагүй байгаа. Улсын төсөв гээд аваад үзэх юм бол улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр одоогоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байхгүй байгаа. Орон нутгийн төсөв гэх юм бол орон нутгийн төсөв бол өөрөө баталдаг эрхтэй. Улсын төсөв батлагдсаны дараа.

Тэгэхээр энэ дээр эргэж харах шаардлагатай болов уу гэж бодож байна.

Р.Сэддорж: Тайлбар. Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: 2024 онд утааг бууруулах чиглэлээр 1 их наяд төгрөгийг зарцуулсан байгаа юм. Гэхдээ эд нар бүгдээрээ хэрэглээг дэмжсэн. Яагаад улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын тусламж гэж байгаа вэ гэхээр үүнээс цааш бид гал түлдэг зүйл дээр татварын мөнгө зарцуулахаа больё. Гал түлэхгүй буюу дулаалгаа дэмжье гэж байгаа.

Ногоон санхүүжилтийн ажлын хэсгийг би ахалж байгаа. Санал, дүгнэлтээ боловсруулаад дууссан. Энэ ажлынхаа хүрээнд бүх яамд, нийслэлийн хийх ажлын төлөвлөгөөг нь гаргасан байгаа.

Эдийн засгийн байнгын хороо, Байгаль орчны байнгын хороогоор үүнийг Их Хурлын тогтоолын төсөл болгож оруулна. Тэрийгээ хэрэгжүүлэхдээ өмнө нь байсан энэ зарцуулж байгаа татвар төлөгчдийн мөнгийг шатаагаад байгаагаа дулаалга болгоё л гэсэн, шатаахаа больё гэсэн тийм л зарчмын зөрүүтэй санал.

Төсөв дээр мөнгө нэмэх гээгүй. Намрын төсөв орж ирэхэд зохицуулалтуудыг нь бүгдийг нь оруулаад Их Хурлын тогтоолын төслөөр үүнийгээ боловсруулсан байна.

Тэгэхээр ачаалал бол нэмэгдэхгүй. Одоо нэгэнтээ бид 1 их наяд төгрөгийг сайжруулсан түлш гээд бүх юман дээр зарцуулж байгаа. Шөнийн цахилгааны хөнгөлөлт гэж байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг ч гэсэн бид дулаалга руу чиглүүлэх ёстой байгаа.

Тэгэхээр та хэдийгээ дэмжиж өгөхийг хүсэж байна.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Хэдхэн сарын өмнө бид Их Хурал дээр нүүрсний сонсгол хийсэн.

Тэгээд түүгээр маш олон зүйлүүд яригдсан. Өнгөрсөн хугацаанд маш их хэмжээний улсын төсвийн хөрөнгийг яг агаарт хийсгэсэн байдаг. Дандаа утаа гаргадаг яндан зуух гэх мэтчилэн. Тийм ээ.

Тэгэхээр энэ асуудал дээр Г.Лувсанжамц гишүүний саналыг бүрэн дэмжиж байгаа. Тэгээд энэ жилийн төсөв дээр ч гэсэн бараг их наяд шахам төгрөг ямарваа нэгэн байдлаар тойруу замаар агаарын бохирдлыг бууруулах нэрийдлээр агаарт хийсэж байгаа.

Тэгэхээр ирэх жилийн төсөв дээр эдгээр санхүүжилтүүдийг илүү агаарын бохирдлыг яг бодитоор бууруулах чиглэл рүү шилжүүлэх бүрэн боломжтой гэж харж байгаа. Тэгээд сая нүүрсний сонсголын ар дээр гарсан ажлын хэсгийн дүгнэлттэй хамт Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр бас нэг тогтоолын төсөл явж байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд эрх зүйн орчин нь шийдэгдэх байх гэж бодож байна.

Тэгэхээр энэ саналыг дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсье.

Р.Сэддорж: Сангийн яам нэмж хэлэх үү? 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Нэмэлт мэдээлэл өгье.

Яг нэгдсэн төсвийн нийт зардлын хувьд урсгал болон хөрөнгийн зардал. Хөрөнгийн зардал дээр одоогоор яг энэ чиглэлийн төслүүд тавигдаад хэрэгжсэн санхүүжилт байхгүй.

Магадгүй хэрвээ зохицуулалт хийнэ гэж байгаа бол энэ дээр урсгал зардал дээр байгаа ямар ангиллын ямар зардлыг шилжүүлж байгаа гэдгээ тодорхой тусгах хэрэгтэй болов уу.

Хоёрт нь, улсын төсөв, орон нутаг, гадаад зээл ямар ч эх үүсвэрийг хөрөнгө оруулалт хийсэн заавал төрийн болон орон нутгийн өмчид бүртгэгддэг хуулийн заалттай.

Тэгэхээр дулаалгын төсөл бол нөгөө хувь айлын дулаалахаар тэр өмчийн асуудал хөндөгдөх учраас яг энэ орох асуудал хэрэгжих дээр маш асуудал үүснэ.

Тэгэхээр илүү тодорхой болгох нь зөв болов уу л гэж бодож байна. Одоо хэрвээ энэ хэмжээний эх үүсвэр байгаа бол тэр нь яг ямар зардлын ангилал дээр байгаа гэдгийг дурдаж байж тийшээ шилжүүлэх асуудлыг тусгах нь зүйтэй.

Р.Сэддорж: Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Хэдүүлээ ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөө батлах гэж байгаа. Төсөв шууд тавих гээгүй.

Би сая хэлсэн. Их Хурлын тогтоолын төслийг ногоон санхүүжилтийн ажлын хэсгээрээ ажил нь төлөвлөгдсөн байгаа. Сая Сангийн яамнаас тайлбар хийсэн. Аль урсгал зардлыг, аль хөрөнгө оруулалтын зардлыг дулаалга буюу хэмнэлтийн бодлого руу шилжүүлэх юм бэ гэдэг ажлын төлөвлөгөө боловсруулаад дууссан байгаа.

Гэхдээ бид хөгжлийн төлөвлөгөөндөө үүнийгээ тусгаад. Сая хэлсэн шүү дээ. Тавантолгой түлш дээр гэхэд л 400 тэрбум төгрөг байгаа байхгүй юу. Урсгал зардал дээр. Одоо нийслэл рүү шилжсэн. Тийм.

Тэгэхээр тэр зүйлүүдийг нь ийш нь чиглүүлэх гээд байгаа гэсэн үг. Мөнгө төсөв нэмэх гээгүй. Зүгээр хөгжлийн төлөвлөгөө дотроо л үүнийгээ оруулж өгөөд хэдүүлээ намар дахиад үүнийгээ хэлэлцэнэ. Тэр үед нь тодорхой болгох ажлыг нь бэлдсэн байгаа. Тэрийгээ Их Хурлын тогтоолын төслөөр өргөн бариад батлуулна гэсэн үг.

Р.Сэддорж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хүн байна уу?

Одоо санал хураалт явагдана. 49 дүгээр санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

15-аас 7 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

55.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.35. ШСБ-2.1, ЗГҮАХ-3.3.3.32.” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам дагуу цахилгаан автомашин цэнэглэх зориулалттай нарны эрчим цахилгаан эх үүсвэртэй үйлчилгээний жишиг төвийг байгуулах төслийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,100.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр юм уу, эсвэл гадаадын зээлээр юм уу, алинаар нь юм? Эрчим хүчний яам энэ дээр хариулъя. 5 номер. Хариултаа

Б.Ерэн-Өлзий: Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглаж цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх санаачилгуудыг яам тухай бүрд нь дэмжиж ажиллаж байгаа.

Ерөнхийдөө Эрчим хүчний яам руу яг ийм концепцтой төслүүд дандаа хувийн хөрөнгө оруулалтаар хувийн хэвшил өөрөө хэрэгжүүлэх маягаар ийм саналууд орж ирж байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар явах ер нь бараг шаардлагагүй.

Р.Сэддорж: Сангийн яам энэ дээр тайлбар хэлээч. Хувийн хөрөнгө оруулалтаар хийх юм байна. Тийм үү? 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Жилийн төлөвлөгөөний гол ялгаа бол төсвөөс ялгаатай нь ер нь 2026 онд улсын хэмжээнд хийгдэх нийт хөрөнгө оруулалтуудын хүрээнд яригддаг учраас хэрвээ хувийн хэвшил төр, хувийн хэвшлийн түншлэлээр салбар яам нь боломжтой гэвэл тусгагдах боломжтой.

Р.Сэддорж: Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ гэж ойлголоо. Мөн үү? 5 номер. Эрчим хүчний яам хариулт хэлье.

Б.Ерэн-Өлзий: Яг ийм концепцтой төслүүдийг Эрчим хүчний яам тухай бүрд нь дэмжээд ажиллаж байгаа. Дандаа хувийн хэвшлийн санал орж ирж байгаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Би түрүүн хэлсэн.

Нэгдүгээрт, импортыг орлох, экспортыг дэмжих эрчим хүчний төслүүдийг хувийн хэвшлийн саналаар буюу улсын төсвөөс хөрөнгө гарахгүйгээр хэрэгжүүлэхийг бид дэмжих ёстой. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ хөгжлийн төлөвлөгөө дээр төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаад дотоодын хувийн хөрөнгө оруулалт гээд батлагдсан тохиолдолд Сангийн яам төсөв боловсруулахдаа улсын төсвөөс энэ дээр мөнгө тусгахгүй.

Тийм учраас хувийн хэвшлийн үүнийг дэмжих нь зүйтэй гэж үзэж байгаа.

Р.Сэддорж: Санал хураалт. 55 санал хураалт явуулъя. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

52.Төслийн 2 дугаар хавсралтын 1.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, ЗГҮАХ-1.3.4.6.” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Уул аймгийн Шарын гол суманд 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “40” гэж, Нийт санхүүжилтийн дүн “473,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “142,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.12 дахь дэд заалт нэмэх.

Тэгээд Эрчим хүчний яамнаас асуух гээд байгаа юм. Дархан-Уул аймаг одоогоор цахилгаан станцтай. Хэвийн байгаа. Одоо нэмэх гэж байна. Бусад аймгуудаа ийм байдлаар хийж байгаа юу? Адилхан бусад аймгуудын 50 мегаватт эд нар чинь адилхан явж байгаа юу? Эсвэл бусдыгаа огт танайх дэмжихээ байсан уу? Энэ дээр хариулт авъя. 5 номер.

Б.Ерэн-Өлзий: Асуултад хариулъя.

Энэ болохоор Шарын гол суманд буюу Шивээ-Овоогийн уурхай дээр 50 мегаваттын станц барина гэж Шарын гол компаниас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барина гэж ТЭЗҮ-гээ 2002 онд батлуулсан.

Тодруулахад одоогоор тусгай зөвшөөрлөө аваагүй байгаа юм билээ. Эрчим хүчний яам хувийн хэвшлийн оруулж ирж байгаа саналыг нь тухай бүрд нь дэмжиж байгаа. Энэ төсөл дээр.

Тэгэхдээ энэ дээр хувийн хөрөнгө оруулагч нь өөрөө төслөө хэрэгжүүлэх асуудлаар тодорхой үйлдэл хийхгүй бол биелэлт гарахгүй төлөвлөгөө болно гэсэн үг.

Р.Сэддорж: Н.Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Эрчим хүчний яамнаас үүнийг далимдуулаад би нэг асуулт асууя.

Тэр 10 станцын асуудал яригдаад байдаг шүү дээ. Солонгостой хамтарсан билүү. Тэр ер нь ямар байдалтай явж байгаа вэ? Тэр мэдээллийг өгөөч.

Ер нь танай яам руу нэг бичиг явуулахаар ерөөсөө хариу ирэхгүй алга болох юм. Ус руу чулуу шидсэн юм шиг. Хариу энэ тэрээ өгч баймаар байх юм. Үүнийг нь тэмдэглэлд оруулъя.

Р.Сэддорж: Санал хэллээ. Тийм ээ. 5 номер хариулт.

Б.Ерэн-Өлзий: Төвлөрсөн дулаан хангамжийн системгүй 10 аймгийн төвд дулааны станц барих төсөл Солонгосын ЭКСИМ банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа.

ЭКСИМ банкны зээлийн нөхцөл нь зөвхөн Солонгос гүйцэтгэгч байх нөхцөлтэй. Тэгээд 2022 онд тухайн төслийн гүйцэтгэгчийг Эрчим хүчний яамнаас ЭКСИМ банкны шалгуурын дагуу сонгон шалгаруулсан. Тендерт зөвхөн Солонгосын аж ахуйн нэгж оролцох ёстой.

Шалгарсан гүйцэтгэгч ажлаа хийж байгаад тухайн компани нь Солонгостоо ер нь санхүүгийн хувьд дампуурлаа зарлах ийм процесс гаргасантай холбогдуулан гүйцэтгэгч компани ажлаа түр зогсоочоод байгаа.

Р.Сэддорж: Одоо энэ чинь хувийн хэвшлийн компани хийнэ л гэж байгаа. Тийм үү? Шарын голын станцыг. 5 номер хариулъя.

Б.Ерэн-Өлзий: Шарын гол суманд 50 мегаваттын станц барих энэ төслийн санаачилга хувийн хэвшлээс хувийн хөрөнгө оруулалтаар барина гэж ТЭЗҮ-гээ Эрчим хүчний яамаар батлуулсан.

Р.Сэддорж: Гишүүд санал хураалтад бэлдье. 52 дахь саналаар санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

56.Төслийн 2 дугаар хавсралтын 3.14 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эрдэм шинжилгээний ажлын үр дүн, чанарыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.4.11, ЗҮАХ-3.3.7.3” гэж, Төсөл, арга хэмжээ “10 мянга нарны дээвэр хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “15” гэж, Нийт санхүүжилтийн дүн “100,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “15,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр, хувийн хэвшлийн түншлэл, Гадаад дотоодын хөрөнгө оруулалт, Гадаадын зээл, тусламж” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэсэн 3.14.1.13 дахь дэд заалтыг нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн дарга тайлбарлая. М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Түрүүн би хэлсэн. Эрчим хүчний төсөл, тэр дундаа сэргээгдэх эрчим хүчний төслийг хувийн хэвшлийн хөрөнгөөр хийхдээ үүнийг бол дэмжинэ. Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр зааж байгаа юм.

Яагаад гэвэл энэ чинь тодорхой байршил нь судалгаан дээр үндэслээд гарч байгаа шүү дээ. Тийм ээ. Яах вэ, тийм тооцоонууд байгаа юм билээ. Гэхдээ улсын хэмжээнд үүнийг хэрэгжүүлбэ.

Р.Сэддорж: Эрчим хүчний яам үүнийг дэмжиж байгаа юу? Тодорхой хариулаарай.

Б.Ерэн-Өлзий: Төслийн концепц нь болохоор айл өрх өөрийнхөө одоо юу гэдэг юм орон сууцын дээвэр дээр нарны станц, бага оврын хэрэглээний ийм нарны станц барьж байгуулахад түүнд нь ямар нэг санхүүгийн механизмын дэмжлэг үзүүлбэ гэсэн ийм л концепцтой агуулга байгаа.

Үүнийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас саналыг оруулсан. Энэ бол орон нутагтайгаа хамтарч л хэрэгжих төсөл. Шууд Эрчим хүчний яам одоо энэ айл өрхийн тухайн ахуйн хэрэглээний зүйл рүү ороход хүндрэлтэй ийм төсөл байгаа.

Ямар нэг санхүүжилтийн эх үүсвэр яригдаагүй.

Р.Сэддорж: Эдийн засаг, хөгжлийн яам 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат.

Яг энэ асуудлыг Тэргүүн шадар сайд нэгдсэн чуулган дээр бас тайлбар өгч байсан. Юу гэхээр Ногоон санхүүжилтийн корпорац гэж удахгүй байгуулагдаж байгаа. Хөгжлийн банк болон **GCF /GREEN CLIMATE FUND/** гээд “НОГООН САНХҮҮЖИЛТИЙН КОРПОРАЦ” нь гаднын болон дотоодын хувийн хэвшлийн хамтарсан корпорац байгуулаад, тэрний эх үүсвэрээр санхүүжих боломжтой. Үндэслэл нь болохоор сая өнгөрсөн жил өвлийн улиралд тог тасарсан.

Тэгэхээр айл өрхүүдэд нэлээд хүнд байдалд байсан учраас томоохон эрчим хүчний төслүүд хэрэгжихийн хажуугаар бага оврын жижиг төслүүдийгээ явуулах нь зүйтэй гэж үзэж үүнийг оруулж байгаа юм.

Тэгэхээр үүнийг дэмжиж өгнө үү.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн гишүүн саналаа томьёолъё.

М.Бадамсүрэн: М.Мандхай гишүүний асууж байгаа нь зөв өө.

Үүнийг 3.14 дэх заалтад оруулах биш 3.6.1 дэх заалтын 8 дахь хэсэг болгоод ангилал нь “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний үнийн өсөлтийг хангасан байна.” гэдэг ангилал руу оруулах нь зүйтэй юм байна гэж үзэж байна.

Тэгээд энэ өөрчлөлтийг оруулж баталж өгөөч ээ.

Р.Сэддорж: Энэ өөрчлөлтийг оруулаад 56 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

15-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

57.Төслийн 2 дугаар хавсралтын 2.5.1 дэх заалтад Төсөл, арга хэмжээ “2.5.1.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын орчин, дэд бүтцийг сайжруулах, хөрөнгийн менежментийн үр ашгийг нэмэгдүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Стандартын шаардлага хангасан оюутны байрны эзлэх жин” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “35” гэж, Зорилтот түвшин “46” гэж, Нийт санхүүжилтийн дүн “435,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “105,000.0” гэж, Эх үүсвэрийн ангилал “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэсэн 2.5.1.4 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

58.Төслийн 2 дугаар хавсралтын 4.17 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “4.17.Хүний эрхийг хамгаалах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагын олон талт хамтын ажиллагаа бэхжинэ.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “4.17.1.Хүний эрхийн Үндэсний Комиссыг Парисын зарчимд бүрэн нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага болгож бэхжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5.1. 5.5.2, ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “4.17.1.1.Ази, номхон далайн бүсийн хүний эрхийн төв шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “25,096.3” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “8,365.4” гэж, Эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүний эрхийн Үндэсний Комисс” гэсэн 4.17.1.1 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

59.Төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь хэсгийн Зорилтот үр дүн “Өрсөлдөх чадвартай тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Стандартын шаардлага хангасан оюутны байрны эзлэх жин” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “35” гэж, Зорилтот түвшин “46” гэж, Мэдээллийн эх сурвалж “Дээд боловсролын статистик” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Захиргааны статистик” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жилд 1 удаа” гэж, Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “4.3.1” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг санал. Санал хураалт. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

60.Төслийн 2 дугаар хавсралтын “1.7.3.2 дэд заалтын төсөл, арга хэмжээг “Орон нутагт ажиллах төрийн албан хаагчдын болон сумдад хөдөлмөр эрхлэж байгаа залуучуудын түрээслэх орон сууц барих” гэж өөрчлөн найруулах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

61.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.3.44, 9.3.46, ЗГҮАХ-1.4.2.6, 2.4.3.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрчим хүчний хяналтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх системүүдийг /WAMPAC, SCADA, MDMS/-г шинэчлэх”, “Эрчим хүчний ухаалаг сүлжээ төсөл” гэж, Шалгуур үзүүлэлтд “Шинээр суурьлуулах тоног төхөөрөмж” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “25” гэж, Нийт санхүүжилтийн дүн “183,230.6” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “45,557.6” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Гадаад зээл” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн.

Эрчим хүчний яам энэ дээр хариулт хэл дээ. 5 номер.

Б.Ерэн-Өлзий: Эрчим хүчний систем, ялангуяа төвийн бүсийн эрчим хүчний системийн одоогийн диспетчерийн удирдлагыг шинэ түвшинд гаргах, системийн автоматжуулалтыг шинэчлэх ийм төсөл байгаа.

Одоо ер нь хэрэглээ байнга хувьсаж байдаг. Та бүхэн мэднэ. Одоо сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр нэмэгдэхийн хэрээр хувьсдаг цахилгаан үйлдвэрлэгчийн оролцоо улам нэмэгдэж байна. Энэ үед системийн автоматжуулалтаа цогц байдлаар нь сайжруулах шаардлагатай байгаа.

Азийн хөгжлийн банктai хамтран бид энэ төслийн суурь судалгааг өнгөрсөн хугацаанд хийгээд ТЭЗҮ-гээ баталсан байгаа. Одоо Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэхэд бэлэн.

Тэгэхдээ Сангийн яамнаас тухайн төсөлд зээл авъя гэсэн зээлийн хүсэлт өгөх асуудал хүлээгдэж байгаа ийм ажил байгаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Ажлын хэсэг дээр үүнийг хэлэлцээд дэмжигдээгүй. Гэхдээ энд дэгийнхээ дагуу хэлэлцүүлэхээр, санал хураахаар орж ирж байгаа.

Р.Сэддорж: 61 дүгээр саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй. 1 хүний санал авч байна.

62.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, автотээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.16.” гэж, Төсөл, арга хэмжээ “Говь-Алтай, Алтай-Бургастай чиглэлийн авто замаас Алтай сум хүртэлх хатуу хучилттай авто замын зураг төсөл, төсөв боловсруулах” Шалгуур үзүүлэлт Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “2,600.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,600.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт. Санал хураалт. /алх цохив/

15-аас 1 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

63.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.2 дахь хэсэгт “Ховд аймаг, Булган сум, Булган боомтын үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх бэлтгэл хангана.” гэсэн 3.2.6 дахь заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

64. Төслийн 2 дугаар хавсралтын 1.6 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.35, ЗГҮАХ-1.3.2.4.” гэж, Төсөл, арга хэмжээ “Шинээр баригдах 220/110/35 Кв-ын “Городок” транзит дэд станц, Городок-сэргэлэн чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, Городок Налайх чиглэлийн 110 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ-ын ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг 5 дугаар хороо/.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “кВа” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “35” гэж, Нийт санхүүжилтийн дүн “144,427.7” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “50,549.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.12 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир. Санал хураалт.
/алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

65.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6 дахь заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Налайх Цахилгааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “56,354.9” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “18,785.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир.

Эрчим хүчний яам энэ төсөл амжилттай хэрэгж хэрэгжих одоо үндэслэлтэй юу? 5 номер.

Б.Ерэн-Өлзий: Техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн. Санхүүжилт шийдэгдвэл тэгээд шууд үе шаттайгаар хэрэгжинэ гэсэн үг.

Р.Сэддорж: Сангийн яам 6 номер. Энэ дээр эх үүсвэрийн талаар тайлбар хэлээрэй.

Ж.Дэлгэржаргал: Налайхын хувьд өнгөрсөн жилийн 2025 оны төсөв анх батлахад тусгагдсан байж байгаад алдагдалгүй төсөв батлах хүрээнд хасагдсан төсөл байгаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Энэ дээр ажлын хэсэг санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал дээр нь Сангийн яамнаас тодруулж байгаад тавья гээд сая тайлбар хэллээ. Ж.Дэлгэржаргал дарга.

Улсын төсвөөс санхүүжих, мөн үндсэн хариуцагч нь Эрчим хүчний яам гэж нэмэх. Тэгээд шалгуур үзүүлэлт нь хэмжих нэгж нь “хувь”, суурь түвшин нь “0”, зорилтот түвшин нь “33 хувь” гээд. Санхүүжилтийн дүнгүүд нь энэ дээр байна. Энэ нэмэлтүүдийг оруулаад дэмжиж өгөөч ээ гэсэн саналтай байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн гишүүн Ш.Бямбасүрэн гишүүн. Ш.Бямбасүрэн гишүүний микрофоныг нээе.

Ш.Бямбасүрэн: Налайх дулааны шинэ эх үүсвэр гэсэн байгаа. Энэ дээр зөвхөн нэг дулааны станц шиг харагдаад байгаа юм л даа. Тэгээд энэ 79 мегаваттын дулааны станц гэж байхгүй л дээ.

Тэгэхээр “цахилгааны” гэж үг нэмж оруулах ёстой.

Тэгээд түрүүн М.Бадамсүрэн гишүүний хэлж байгаа тэр хэмжих нэгж нь “мегаватт” гэж байхгүй “хувь” гэж орох ёстой.

Тэгээд тэр санхүүжилтийн хэмжээ нь яг гуравт хуваагаад гарч байгаа юм уу, үгүй юм уу. Сайн мэдэхгүй байна.

Р.Сэддорж: 65 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

15-аас 8 хүн дэмжиж, санал дэмжигдлээ.

66.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.2.2.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, бүтээн байгуулалтын нэгдүгээр үе шатны дэд бүтцийн ТЭЗҮ зураг төсөл боловсруулах /Төв аймаг, Сэргэлэн сум /” гэж, Шалгуур үзүүлэлт “баримт бичгийн тоо” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн “975.8” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “975.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Монгол Улсын Шадар сайд” гэсэн 1.1.1.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан. Санал хураалт. /алх цохив/

15-аас 2 хүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

67.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд “Цахим шилжилтийн эрчимжүүлэлтэй холбогдуулан кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн 4.6.3 дахь заалтыг нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 хүн гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

68.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.”

гэж, Хөтөлбөрийн үр дүн “Нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулж, агаарын тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-н 3.3.2.11, АХ-8.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Баян-Өлгий аймгийн нисэх буудлыг 4 С ангилалын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “5” гэж, Нийт санхүүжилтийн дүн “95,120.9” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “28,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэж, Үндсэн хариуцагч “Зам тээврийн яам” гэсэн 1.9.2.5 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

69.Төслийн 2 дугаар хавсралтын 3.17 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Гамшгийн бэлтгэл бэлэн байдлын хувь нэмэгдсэн байна.” гэж, Төсөл, арга хэмжээ “Онцгой нөхцөл байдлын үед ашиглах богино болон хэт богино долгионы мэдээлэл харилцаа холбооны систем шинээр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Техник хэрэгслийн хангалт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “16” гэж, Зорилтот түвшин “70” гэж, Нийт санхүүжилтийн дүн “100,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “33,300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “ҮАБЗ-ийн Ажлын алба” гэсэн 3.17.1.4 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

П.Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Зарчмын хувьд үүнийг дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ “зөвхөн онцгой байдлын үед ашиглах богино хэт долгионы мэдээлэл харилцаа” гэж.

Уг нь энэ бол хууль сахиулах болон хууль сахиулах алба, онцгой байдал, магадгүй нөгөө эрүүл мэндийн юу бас орж ирдэг байхгүй юу. Яг нөгөө долгио алдахгүй. Иж бүрнээр нь харж болохгүй байсан уу? Энд эсвэл хамрагдах уу? Үүнийг бас нэг тодорхой зүгээр протоколд үлдээхээч.

Энэ чинь бол нийтлэг үүгээрээ ашиглана биз дээ? Яг энэ үед. Үүнийг нэг хариулт аваад протоколд үлдээчихье.

Р.Сэддорж: 3 номер хариулт.

Д.Ариунболд: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга, хошууч генерал Д.Ариунболд. П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Энэхүү төсөл буюу энэ системийг байгуулах бол яг гишүүний хэлсэн шиг хууль хяналт, төрийн цэргийн болон онцгой нөхцөл байдал, гамшгийн үед үйлчлэх бүхий л байгууллагуудыг хамарсан ийм улсын хэмжээний нэгдсэн тоон технологид суурилсан үндэсний тусгай зориулалтын систем байгаа. Бүгд ашиглана.

Сумын хэмжээнд хүртэл оруулахаар төлөвлөгдсөн ажиллаж байгаа.

М.Бадамсүрэн: Санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. /алх цохив/

15-аас 9 гишүүн дэмжиж, дэмжигдлээ.

70.Төслийн 2 дугаар хавсралтын 4.2 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлж, сөрөн тэсвэрлэх чадавх бүрдсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавх дээшилж, зэвсэглэл, техникийн бэлэн байдал хангагдсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-4.4.3.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Кибер аюулгүй байдлын программ хангамж техникийн лицензийн төлбөр” гэж, Шалгуур үзүүлэлт “Баталгаат программ хангамж” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “12,170.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “12,170.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Батлан хамгаалах яам” гэсэн 4.2.1.16 дахь дэд заалт нэмэх.

Асуулттай гишүүд байна уу? Асуулт байхгүй бол дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

15 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, дэмжигдлээ.

71.Төслийн 3 дугаар хавсралтын 4.11 дэх Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн: Монгол Улсын гадаад бодлогын байр суурийг бататгаж олон улс дахь нэр хүнд нөлөөг бэхжүүлсэн байна.” гэж, Зорилтот үр дүн “Монгол Улсын гадаад бодлогын байр суурийг бататгаж олон улс дахь нэр хүнд нөлөөг бэхжүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-4.4.2.21” гэж, Шалгуур үзүүлэлт “Нийт экспортод эзлэх уул уурхайн бус бүтээгдэхүүний үнийн хувь” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “8” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Хариуцах байгууллага “Гадаад харилцааны яам” гэж нэмэх.

Шалгуур үзүүлэлтийн хавсралт дээр тодорхой болгож оруулж байгаа санал гэсэн үг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

72.Төслийн 3 дугаар хавсралтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлж сөрөн тэсвэрлэх чадавхи бүрдсэн

байна.” гэж, Зорилтот үр дүн “Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлж сөрөн тэсвэрлэх чадавхи бүрдсэн байна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Тухайн жилд төлөвлөгдсөн арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “70” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Мэдээллийн эх сурвалж “Батлан хамгаалах яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “жил дутам” гэж, Хариуцах байгууллага “Батлан хамгаалах яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

15-аас 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

73.Төслийн 3 дугаар хавсралтын 3.10 дахь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн: “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Хүлэмжийн хийн ялгарал” гэж, Хэмжих нэгж “сая/тнCO2” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “-” гэж, Мэдээллийн эх сурвалж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “жил дутам” гэж, Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “8.4.2, 9.4.1, 12.2.2, 12.6.1, 13.2.2” гэж, Хариуцах байгууллага “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

16-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

74.Төслийн 3 дугаар хавсралт Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн “Хүний хөгжил”-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт “Ядуурлын түвшин” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж Суурь он “2022” гэж, Суурь түвшин “27.1” гэж, Зорилтот түвшин “22.0” гэж, Мэдээллийн эх сурвалж “ҮСХ” гэж Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик мэдээ” гэж Мэдээлэл цуглуулах давтамж “2 жил тутам” гэж Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “1.2.1, 1.2.2” гэж, Хариуцах байгууллага “Эдийн засаг хөгжлийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

М.Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай:74 дээр суурь түвшин нь өндөр мөртлөө зорилтот түвшин нь бага орж ирсэн байх юм. Зарим түвшнүүд нь болохоор зорилтот түвшин нь өндөр, суурь түвшин нь бага байсан. Тэгээд энэ яагаад ийм юутай юм бол? Суурь түвшнээсээ бага орж ирж байгаа юм бол.

Р.Сэддорж: 74 дүгээр саналаар санал хураалт. /алх цохив/

16-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

75.Төслийн 3 дугаар хавсралт Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн “Эдийн засгийн бодлого”-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт “Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс” гэж, Хэмжих нэгж “байр” гэж Суурь он “2024” гэж, Суурь түвшин “76/176” гэж, Зорилтот түвшин “73” гэж, Мэдээллийн эх сурвалж “Дэлхийн өв уламжлалын сан” гэж Мэдээлэл цуглуулах арга зүй “Олон эх үүсвэр” гэж Мэдээлэл цуглуулах давтамж “Жил тутам” гэж Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “0” гэж, Хариуцах байгууллага “Эдийн засаг хөгжлийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

16-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

76. Төслийн 3 дугаар хавсралт Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн “Эдийн засгийн бодлого”-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт “Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ” гэж, Хэмжих нэгж “оноо” гэж Суурь он “2024” гэж, Суурь түвшин “2.71” гэж, Зорилтот түвшин “3” гэж, Мэдээллийн эх сурвалж “МҮХАҮТ” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Монголын бизнесийн орчны судалгаа” гэж Мэдээлэл цуглуулах давтамж “3 жил тутам” гэж, Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “-” гэж, Хариуцах байгууллага “Эдийн засаг хөгжлийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

16-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

77. Төслийн 3 дугаар хавсралт Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн “Эдийн засгийн бодлого”-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт “Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж Суурь он “2023” гэж, Суурь түвшин “76.2” гэж, Зорилтот түвшин “78” гэж, Мэдээллийн эх сурвалж “ҮСХ” гэж Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик мэдээ” гэж Мэдээлэл цуглуулах давтамж “жил тутам” гэж Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт шалгалт “-” гэж, Хариуцах байгууллага “Эдийн засаг хөгжлийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

16-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

78.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Халдварт болон халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулсан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.15. 2.2.27, 9.1.9, ЗГҮАХ-2.3.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Хүрээ амаржих газарт шинэ эмнэлгийн тоног төхөөрөмж авах” гэж, Шалгуур үзүүлэлт “Тоног төхөөрөмж” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “13,316.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “13,316.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал

“Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэсэн 2.1.1.8 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

16-аас 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

79.Төслийн 2 дугаар хавсралтын 3.6.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, ШСБ-2.1.7, ЗГҮАХ-3.3.3.13” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорноговь аймаг, Айраг сум Цахилгаан станц барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “14,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “4,700.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 3.6.1.8 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн гишүүн тайлбар хэлье.

М.Бадамсүрэн: Энэ дээр нэг засвар байна. Энэ болохоор хэмжих нэгж дээр “тоо, ширхэг” биш, барилгын ажлын гүйцэтгэлийн “хувь” гэж орох ёстой.

Тэгээд суурь түвшин “0”, зорилтот түвшин “30”. Ийм одоо засварыг оруулж санал хураалгаж өгөөч ээ гэсэн санал байна.

Р.Сэддорж: Саяын өөрчлөлтүүдийг, ажлын хэсгийн даргын хэлсэн саналуудыг оруулаад санал хураалт. /алх цохив/

16-аас 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

80.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гадаад болон дотоодын тэмцээн, уралдаанд оролцох боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийг нэмэх.” гэсэн 2.1.16 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Эрдэнэбат.

Бүгдээрээ санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. /алх цохив/

16-аас 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

81.Төслийн 2 дугаар хавсралтын 3.3.1 дэх заалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг

нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.4.4, 3.3.4.14.” гэж, Төсөл, арга хэмжээ “Ноосон бордооны үйлдвэр байгуулна.” гэж, Шалгуур үзүүлэлт “Үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “15,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “4,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэсэн 3.3.1.5 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар.

Ш.Бямбасүрэн гишүүн тодруулж асууна.

Ш.Бямбасүрэн: Улсын төсвийн хөрөнгөөр яам нь хариуцаад үйлдвэр барина гээд байгааг яг сайн ойлгохгүй байгаа.

Ер нь бид малын гаралтай түүхий эдийг үр ашигтай болгох талаар, үйлдвэрийг барих талаар уг нь дэмжих ёстой. Гэхдээ үүнийг тэр хувийн хэвшлээр хийлгэх талаар нь бид явахгүй бол төр өөрөө үйлдвэр барина гээд оруулаад ирж байгаа дээр яам ер нь ямар бодлоготой байгаа юм? Яг энэ 81 дээр хариулт өгөөч гэж хүсье.

Р.Сэддорж: Хэдэн номер байна. 9 номер. Өөрийгөө танилцуулаарай. Ажлын хэсгийн гишүүн.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Тэгэхээр “Ноосон бордооны үйлдвэр” гэдэг бол Улсын Их Хурлын баталсан “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд зээлийн хүүгийн дотациар ноосон бордооны үйлдвэр болон ноосон дулаалгын материалын үйлдвэрийг дэмжинэ гэсэн бодлогын хүрээнд явж байгаа.

Яг одоо орж ирсэн санал бол энэ хувийн хэвшлийн хийх гэж байгаа. Үүнийг сая тодруулсан. Тэгээд худалдан авах ажиллагааны газар дээр техник, эдийн засгийн үндэслэл нь боловсруулагдаад 50 хувьтай явж байгаа юм байна.

Хувийн хэвшил хийж байгаа учраас үүнийг дэмжихэд түвэгтэй асуудал байна л гэж хэлье.

Р.Сэддорж: Ш.Бямбасүрэн гишүүн. Ажлын хэсгийн гишүүн тайлбар хэлье.

Ш.Бямбасүрэн: Тэгээд харин улсын төсвийн хөрөнгөөр төр хийх гээд байгаа юм уу, хувийн хэвшлээр хийлгэх гээд байгаа юм уу гэдгийг аягүй тийм тодорхой танай яамны чинь бодлого юу юм бэ гэдгийг асуусан.

Хэрвээ хувийн хэвшлээр хийлгэх гэж байгаа бол хувийн хэвшил чинь тэр техник, эдийн засгийн үндэслэл нь боловсруулагдаж байгаа юм байна лээ гэж байна. Тэгээд энэ юм нь байхгүй юм байна шүү дээ. Ер нь бол. Одоо энэ дээр байгаа мөнгөн дүн эд нар буруу гэсэн үг байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг хасах саналтай байна гэж Байнгын хорооны гишүүддээ хэлье.

Р.Сэддорж: Б.Мөнхсоёл гишүүн үг хэлнэ. Б.Мөнхсоёл гишүүн ажлын хэсгийн гишүүн.

Б.Мөнхсоёл: Ажлын хэсэгт байгаа гишүүд анхнаасаа энэ төслүүдэд санал оруулахдаа зарчмаа тохирсон. Өөрөөр хэлэх юм бол Төлөвлөгөөний хуулийн 6.10.2-оо барихыг хичээсэн.

Тэгээд мэдээж зарим техник, эдийн засгийн үндэслэл байхгүй ч юм уу, эсвэл төсвийн санхүүгийн эх үүсвэр нь зоогдоогүй, тэгсэн мөртлөө тэргүүлэх чиглэлд ач холбогдолтой гээд орсон энэ зүйлүүд дээр дараа нь төсөв хэлэлцэгдэх үед дахиж базагдах юм байна гэсэн зарим нэг үйл ажиллагаа, төслийг үлдээсэн талууд байгаа шүү.

Тэгээд тухайн яамнаас нь хамгаалах гэж ирсэн мэргэжилтэн, экспертүүд байхгүй үед Сангийн яамнаас ялангуяа маш их эх үүсвэр нь байгаа юу гэж асуусан.

Одоо энэ дээр өнөөдөр Эдийн засгийн байнгын хороон дээр голчлон ажлын хэсгийн гишүүд байна. Тэгээд хэдэн төсөл хамгаалах гэж байгаа юм шиг. Ялангуяа иргэд цаад мэдээлэл байхгүй үед буруу ойлгогдох вий гээд зориуд энэ тайлбарыг өгч байна шүү.

Мөн нэг барьсан чиглэл бол хувийн сектор орж ажиллах боломжтой тэр зах зээлийг булаацалдахгүй байх ёстой, төрийн оролцоо шаардлагагүй байх ёстой тэр хэсэг дээр аль болохоор төсөвт ачаалал үүсгэхгүй байх ёстой гэсэн зарчмыг баримталсан байгаа шүү. Янз бүрийн лобби орох боломжууд үргэлж байдаг.

Тэгэхээр манай ажлын хэсгийн гишүүд энэ дээрээ зарчмын байр сууриа илэрхийлээд явсан нь зөв байх гээд базаад ийм ганц тайлбар, тодруулгыг зориуд протоколд оруулъя. Баярлалаа.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Хөдөө аж ахуйн салбарын бодлогын хувьд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг дэмжиж байгаа гэж ойлгож байгаа. Тэр утгаараа энэ ноосон бордооны үйлдвэр бол байх шаардлагатай гэж харж ойлгож байгаа.

Тэгэнгүүт энд болохоор санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал дээр улсын төсөв гээд тавьсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар улс яахаараа ч бордоо хийх гээд байгаа юм. Тийм ээ.

Тэгэхээр тэр утгаар нь ерөнхийдөө энэ агуулгыг нь үлдээгээд, санхүүжилтийн эх үүсвэрийн ангиллын гадаад, дотоодын хөрөнгө оруулалт гэсэн ангилал болгоод тэгээд санал хураах саналтай байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн ахлагч.

М.Бадамсүрэн: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн ингэж томъёолж өгсөн учраас үүнийг бид хөндлөнгөөс өөрчилж санал хураахад ямар. Тийм. Тийм дэг байхгүй байх гэж бодож байна.

Р.Сэддорж: 81 дүгээр саналаар санал хураалт. /алх цохив/

16-аас 4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

82.Төслийн 2 дугаар хавсралтын 2.15 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ 3.3.6.14, АХ-1.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ ““Бүх нийтийн соёлын боловсрол II” арга хэмжээ хэрэгжүүлэх” хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “30” гэж, Зорилтот түвшин “70” гэж, Нийт санхүүжилтийн дүн “1,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “700.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэсэн 2.15.1.5 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин. Асуулт Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Энэ бол салбарын сайд нь өөрөө зарчмын зөрүүтэй санал гаргасан байна.

Тэгээд яагаад анхнаасаа Засгийн газар дээр, яамд дээр санал боогдож байхад үүнийгээ оруулаагүй юм? Тэгээд 700 сая төгрөгийг яг юунд зарцуулах гэж байгаа юм гэдэг дээр яамнаас тайлбар авмаар байна.

Р.Сэддорж: Яамнаас тайлбарлая. 5 номер.

Б.Сэргэлэн: Сайн байна уу? Соёл, урлагийн бодлогын зохицуулалтын газрын дарга Б.Сэргэлэн гэдэг хүн байна. Таны асуултад тайлбар хэлье.

Засгийн газрын 2024, 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэсний өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуй, соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчийг дэмжиж, соёлын боловсролтой эерэг хандлагыг бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.

Мөн монгол хүний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг дэмжих, үндэсний соёлын үнэт зүйлд суурилсан нийгмийн соён гэгээрлийн бодлого баримталж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлнэ гэсэн зорилт тусгагдсан байгаа.

Одоогийн байдлаар бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний хэмжээний төлөвлөгөө маань 2023-2024 оны биелэлт

- ▶ 2023 онд **96.0** хувь байсан,
- ▶ 2024 онд **89.5** хувьтай хэрэгжсэн.

Өөрөөр хэлбэл 2 жилийн дунджаар 92 хувьтай хэрэгжсэн болно гэж дүгнэгдсэн байгаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2020, 2024 **“БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ”** арга хэмжээний үйл ажиллагааны биелэлтийн хүрэх түвшин нь 60 хувьд хүрнэ хэмээн зорилт тавьсан бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг хувиар авч үзвэл өнөөдрийн байдлаар 56 хувьтай хэрэгжсэн гэж үнэлэгдсэн.

2025 онд хийгдэх ажлууд **“Бүх нийтийн соёлын, боловсрол-II”** арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ гэсэн зорилт тавьсан байгаа.

2026 онд бид “Бүх нийтийн соёлын боловсрол-2” хөтөлбөрөө бид 70 хувьд хүргэнэ гэсэн ийм зорилт тавьсан байгаа.

Р.Сэддорж: 5 номер нэмж хариулах уу? Хариулчихсан уу?

Б.Сэргэлэн: Урьд нь саналуудыг бүгд өгч байсан. Тухайн үед нь. “Бүх нийтийн соёлын боловсрол-II” хөтөлбөрөөрөө соён гэгээрлийн урлаг, соёлын болон урлагийн боловсролын олгогдох бүх нийтийн соёлын боловсролд.

Энэ нь яг мэргэжлийн уран бүтээлчдэд биш, нийтийн соёл, урлагийн боловсролд зориулсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заасан байгаа.

Р.Сэддорж: Ингээд Соёлын сайд өөрөө оруулсан байна. Тийм ээ. Энэ хөтөлбөрт гишүүнийхээ хувьд оруулсан юм байна.

Ингээд 82 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

16-аас 4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

83.Төслийн 2 дугаар хавсралтын 2.15 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.6.14” гэж, Төсөл, арга хэмжээ “Цахим соёл-II” арга хэмжээ хэрэгжүүлэх /CREATIVHUB, GLAM Галерей, номын сан, архив, музейн дундын цахим систем/” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “5” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “3,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэсэн 2.15.1.6 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин.

Ажлын хэсгийн дарга энэ саналууд дээр өөрийнхөө тайлбарыг хэлээч.

М.Бадамсүрэн: 83, 84, 85 дахь гэсэн энэ 3 саналыг Ч.Номин гишүүний гишүүнийхээ хувьд гаргасан саналыг ажлын хэсэг дэмжсэн байгаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дэмжсэн саналаар залуучууд соёл, урлаг, аялал жуулчлал гээд хамгийн гол л юмнууд л явж байна л даа.

Ажлын хэсгийн дэмжсэн саналаар санал хураалт. /алх цохив/ 83 дугаар санал хураалт.

16-аас 8 хүн санал авч санал дэмжигдсэнгүй.

84.Төслийн 2 дугаар хавсралтын 2.15 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.6.1, АХ-1.5.8” гэж, Төсөл, арга хэмжээ “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Үйл ажиллагааны хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “9,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “5,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэсэн 2.15.1.7 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин.

Ажлын хэсгийн дэмжсэн санал байна. Санал хураалт. /алх цохив/

16-аас 11 гишүүн санал өгч санал дэмжигдлээ.

85.Төслийн 2 дугаар хавсралтын 4.7 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг дээшлүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.6.4, ЗГҮАХ-4.1.1.17” гэж, Төсөл, арга хэмжээ “Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд болон зөрчлийн хэрэгт “Зөрчлийн бүртгэл мэдээллийн сан”-г бий болгох төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж” гэж, Шалгуур үзүүлэлт “Тоног төхөөрөмжийн тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “4,492.5” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “4,492.5” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Монгол Улсын Ерөнхий прокурорын газар” гэсэн 4.7.1.6 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Санал хураалт. /алх цохив/

16-аас 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

86.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “3.16.2.Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвсгөл аймгийн Дархадын хотгорын Багтахын голын гүүр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “3,500.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,166.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.12 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа.

10 минут завсарлая. Чуулганд орж ирцээ бүртгүүлээд. /алх цохив/

Байнгын хорооны хурлыг үргэлжлүүлье.

86.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “3.16.2.Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвсгөл аймгийн Дархадын хотгорын Багтахын голын гүүр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “3,500.0”

гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,166.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.12 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа.

Б.Бат-Эрдэнэ гишүүн саналаа тайлбарлая. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Б.Бат-Эрдэнэ: Эдийн засгийн байнгын хороон дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хөвсгөл аймгийн Дархадын хотгорын Багтахын гүүртэй холбоотой асуудал Дархадын хотгор дээр байгаа хамгийн гол ганц гүүр. Аялал жуулчлалын бас том бүс. Тэр Дархадын хотгорт байгаа 4 сумын нутаг дэвсгэрт байгаа иргэдийн хувьд энэ гүүрээр ганцхан гардаг юм.

Тэгээд одоо энэ гүүр урссантай холбогдуулаад тойрч явж байгаа. Тойрч явахдаа бараг 3 цаг явж байгаа. Уг нь 40 минутын дотор яваад ордог газар.

Тэгээд энэ гүүр байхгүй болсонтой холбогдуулаад цаг хугацаа зарцуулахаас авхуулаад олон асуудлууд үүсэж байгаа.

Эрүүл мэндийн болон бусад олон асуудлууд үүсдэг. Хүн амын эрүүл мэндийн төлөө бид байх ёстой. Энэ утга агуулгаараа цаг хугацаа хэмнэсэн энэ гүүрийг буцааж барьж байгуулахтай холбоотой асуудлуудыг бид шийдвэрлэхгүй бол болохгүй байгаа юм.

Тэгээд ковидын үе шиг аливаа асуудал үүсэх юм бол бас л нэлээн цаг хугацаа бачимдсан ийм зүйл болох гээд байгаа юм. Тэгээд үүнийг Дархадын хотгорын Багтахын голын гүүр барих асуудлыг Та бүхэн маань дэмжээд өгөөч ээ.

Ард иргэдийн эрүүл мэнд болон аялал жуулчлал, бүх л тал дээр маш том тус дэм болдог гүүр байгаа юм шүү. Гол нь эрүүл мэндийн асуудалтай холбоотой асуудал байгаа юм. Тэгээд үүнийг дэмжээд өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: 86 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдэж байна.

87.Төслийн 2 дугаар хавсралтын 1.6 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “1.6.1.Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг

нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, ЗГҮАХ-3.3.3.41” гэж, Төсөл, арга хэмжээ “Хөвсгөл аймаг Мөрөн хот 35 кв-ын ЦДАШ, 10 кв-ын ЦДАШ, 35/10 кв-тын 2Х2500 кВА чадалтай дэд станцын угсралтын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “5,757.6” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,878.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.12 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа.

Б.Бат-Эрдэнэ гишүүн саналаа тайлбарлая.

Б.Бат-Эрдэнэ: Эдийн засгийн байнгын хороон дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мөрөн хотод дулаан, цахилгааны холбоотой асуудал нэлээн асуудал дагуулаад байгаа. Ялангуяа уржнан жилийн өвөл манай төрөх эмнэлгүүдээс авхуулаад маш хүйтэн өвөлжсөн. Айл, гэрүүд маш хүйтэн өвөлжсөн. Түүн дотор ялангуяа эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөнүүдийн асуудал маш хүндээр хөндөгдсөн. Дөнгөж төрсөн нярай нэмэх 20 градусаас доош түвшинд очсон нэлээн хүйтэн өрөөнд дулааны хангамж, цахилгааны хангамж дутагдалтайгаас улбаалаад асуудлууд үүссэн юм.

Тэгээд үүнийг ер нь цаашдаа шийдвэрлэх ёстой гээд 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бид оруулах асуудлуудыг хөндөөд явсан юм.

Тэгээд энэ асуудлыг Та бүхэн маань дэмжиж манай эрүүл мэндийн салбар дээр үүсэж байгаа, айл өрхүүд дулаан өвөлжиж чадахгүй байгаатай холбоотой, аялал жуулчлалд цахилгааны эрчим хүч дутагдалтай байгаатай холбоотой ийм өргөтгөлийн асуудал явагдаж байгаа учраас дэд станцын угсралтын ажлыг Та бүхнийг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: 87 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

88.Төслийн 2 дугаар хавсралтын 1.6 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “1.6.1.Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.34, ШСБ-2.1.7, ЗГҮАХ-3.3.3.13,” гэж, Төсөл, арга хэмжээ “Бугат дэд станцын 35/10 кв-ын Т-1, Т-2 трансформаторыг 2Х4000 кВа болгож хүчин чадлыг нэмэгдүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0”

гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “380.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “380.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэсэн 1.6.1.13 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа.

Саналаа тайлбарлах уу? Б.Бат-Эрдэнэ гишүүн. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Б.Бат-Эрдэнэ: Саяынхтай одоо бас адилхан л процесс л доо. Нөгөө угсралттай холбоотой асуудлууд. Эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой, хөтөлбөрийн дүнтэй холбоотой ийм л асуудал байгаа юм.

Тэгээд сая би тайлбарласан учраас яг адилхан л гэсэн үг.

Р.Сэддорж: 88 дугаар саналаар санал хураалт явуулья. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдэж байна.

89.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн 3.16.2. “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23,” гэж, Төсөл, арга хэмжээ “Ханх-Хатгал чиглэлийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “864,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “288,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа гэсэн байна.

Б.Бат-Эрдэнэ гишүүн саналаа тайлбарлая.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Энэ бас аль аль намын мөрийн хөтөлбөрт орсон. Ханхаар орж ирж байгаа Ханх-Мондын боомт олон улсын зэрэглэлтэй боомт байхтай холбоотой урагшаа Хатгалын чиглэлд ерөөсөө зам байдаггүй. Өвлийн улиралд нуураараа явдаг. Бусад улиралд зам байхгүй. Ингээд цаг хугацааны хувьд бүтэн хэдэн өдөр

зарцуулдаг. Маш цэвдэг ихтэй. Дээрээс нь шалбааг, шавар ихтэй ийм газар байгаа юм.

Хэрвээ энэ зам баригдсан тохиолдолд Оросын Холбооны Улсаас орж ирж байгаа, хойд чиглэл олон улсын боомт болж байгаа учраас хойд чиглэлээс орж ирж байгаа жуулчдын тоо ихсэх боломжтой.

Дээрээс нь байгаль орчин сүйтгэх сөрөг нөлөөлөлгүй болох ийм нөхцөл байдалтай холбоотой асуудал байгаа юм.

Тэгээд Монгол Улсын Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ хойд бүсийн анхны зөвлөлдөх хурлыг хийсэн. Энэ хурлын үеэр Монгол Улсын Засгийн газраас, мөн тойргийн гишүүд энэ замыг явуулах боломжтой төслөө гэж үзсэн. Зураг төсөл нь бэлэн болсон ийм төсөл байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Г.Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Санхүүжилтийн дүн нь 864 тэрбум төгрөг. 2026 онд 288 тэрбум төгрөг үү?

Р.Сэддорж: Б.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгж ойлгож байгаа. Ер нь яах вэ, нийтдээ 140 орчим километр газар. Цэвдэг маш ихтэй газар. Нуур, гол ус ихтэй газар байхгүй юу.

Тэгэхээр тодорхой хэмжээнд Зам, тээврийн яам болон холбогдох зураг төсөл хийсэн компаниудын хувьд энэ түвшинд л техник, эдийн засгийн үндэслэл гарч ирсэн гэж ойлгож байгаа.

Р.Сэддорж: Б.Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Уучлаарай, ажлын хэсгийн гишүүн. Тэгэхдээ бас тодотгоод хэлье гэж бодож байна. Ажлын хэсгийн гишүүд дэмжээгүй санал.

Тэгээд бас тодруулж хэлэх зүйл бол Хөвсгөл нуурыг тойроод маш олон хувийн аялал жуулчлалын баазууд, компаниуд ажиллаж байгаа. Иргэд очиход бүр хашаалаад хашаалаад газар өмчилсөн байдаг. Энэ дээр хувь хүн, гишүүний хувьд хэлэх зүйл бол нэг болохоор “улсын өмчит дархан цаазат газар” гээд байдаг нөгөө болохоор нуураа тойроод баахан хувийн компаниуд хашаалсан. Иргэд шууд нуур луу орох зай завсаргүй болсон байдаг шүү. Үүнийг давхар анхаарах ёстой гэж бодож байна.

Яг энэ саналын тухайд ажлын хэсэг дэмжээгүй санал.

Р.Сэддорж: Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Б.Мөнхсоёл гишүүний хувьд тэр нуурын хажууд байгаа аялал жуулчлалын кемпүүд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар ашиглалтаар явж байгаа.

Хашаануудыг бүгдийг нь татахыг татаад зэрлэг амьтан нуураас орж ус уух боломжийг нь бүрдүүлээд бүгдийг нь цэгцэлсэн.

Яг нуурын эрэг дээр байсан аж ахуйн нэгжүүдийг тусгай зөвшөөрлийг нь цуцалсан. Шүүхийн шатанд явж байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлууд бий.

Замтай холбоотой асуудал дээр бол хоёр шийдэл ярьсан юм. Баруун талаараа явуулах уу, зүүн талаараа явуулах уу гэж. Баруун талаараа явах юм бол яг өнөөдрийн байгаа нөхцөл нь маш өндөр уурстай. Үүнээс их өндөр өртөгтэй болох нөхцөл байдалтай байгаа байхгүй юу. Одоо манай Урандөш, Чөчүү, ингээд бүх уулууд нь ерөнхийдөө баруун тал руугаа байдаг. Зүүн талдаа бол уул нь харьцангуй багатай ийм газар байхгүй юу.

Зүүн талын хувьд эдийн засгийн эргэлтэд ороогүй байгаа. Одоохондоо баруун талаа бодвол тийм их хэмжээний эргэлтэд ороогүй. Тодорхой хувийн хэвслүүд явж байгаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам тухайн үедээ аялал жуулчлалын бодлогыг гаргахдаа юу гэж явж байсан гэхээр томоохон хөрөнгө оруулалтуудыг 5 одтой, 4 одтой томоохон зочид буудлуудыг зүүн эрэг дагуугаа байрлуулъя. Баруун эрэг дагуу нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хэлбэр дээр кемп хэлбэр дээр явуулъя гэдэг ийм стратегийн ач холбогыг бид барьж ажиллаж байсан юм. Тэгээд тийм л утга учиртай.

Тэгэхээр хашаа сав, хотыг нэлээн цэгцэлсэн. Бүр цаашдаа явж байгаа төлөвлөгөө бол тухайн кемпүүдийг бүгдийг нь хашаагүй байлгахтай холбоотой асуудал хөндөж байгаа. Модор хашаалах буюу бутлаг ургамал тарьж хашаалах асуудлыг хөндөөд явж байгаа. Хашаануудыг хангалттай хэмжээнд авч байгаа. Бүх нүхэн жорлонгуудыг бид буулгасан. Бүгдийг нь өөрсдөө ариун цэврийн байгууламжтай байх асуудлыг хөндөж байгаа.

Зам дагасан тоосжилттой холбоотой асуудал энэ жилдээ багтаад дуусахаар ажиллаж байгаа.

Р.Сэддорж: 89 дүгээр саналаар санал хураалт явуулъя.

1 гишүүн дэмжиж, гишүүдийн гаргасан санал дэмжигдсэнгүй.

90.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн 3.16.2. “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.” гэж,

Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23,” гэж, Төсөл, арга хэмжээ “Солонготын даваа-Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “33.3” гэж, Нийт санхүүжилтийн дүн “334,400.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “111,466.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.11 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа.

Б.Бат-Эрдэнэ гишүүн тайлбарлая.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Солонготын даваа, Б.Жаргалант, Шинэ-Идэр, Мөрөн чиглэлийн хатуу хучилттай зам бол хангайн бүс баруун бүсээс хойд бүс рүү холбож орж ирж байгаа гол зам.

Энэ зам ашиглалтад орж хийгдсэнээрээ эдийн засгийн хувьд маш өндөр ач холбогдолтой зам гэж бид тооцож байгаа.

Дээрээс нь Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр болон Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт ч бас байгаа юм билээ. Бид энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулж явж байгаа. Бид энэ замыг ашиглалтад оруулж байж бүсчилсэн хөгжлийн бодлого, үзэл баримтлал маань хэрэгжих боломж бүрдэнэ. Зам харгуйгаа бид барихгүйгээр цаашдаа эрсдэлүүд өндөр.

Ялангуяа өнөөдөр явж байгаа замын хувьд яг ийм авто зам байхгүйтэй холбоотой. Хавар, намар өвлийн улирлууд дээр энэ даваатай холбоотой маш их асуудлууд үүсдэг. Дээрээс нь байгаль орчны сөрөг нөлөөллүүд маш өндөртэй олон салаа зам гарсан ийм хэлбэртэй байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг дэмжиж өгөөч ээ гэж Байнгын хорооны гишүүдээсээ хүсэж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: 90 дэх саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 1 хүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

91.Төслийн 2 дугаар хавсралтын 3.18 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Боомтын зорчигч, ачаа тээврийн нэвтрэлтийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “3.18.1.Идэвхтэй ажиллагаатай боомтын тоог нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-7.2.9, ЗГҮАХ-3.3.2.1,” гэж, Төсөл, арга хэмжээ “Ханх-Мондын боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөл, шинэтгэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “25” гэж, Нийт санхүүжилтийн дүн “45,900.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “11,475.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал

“Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.18.1.8 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Д.Үүрийнтуяа.

Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт, Зам, тээврийн яам Үндсэн хариуцагч нь биш. Энэ бол Боомтын сайд үүнийг хариуцах ёстой юм билээ.

Тэгээд үүнийг санал хураахдаа залруулж хурааж өгөөч гэж хүсэж байна. Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэснийг “Боомтын үндэсний хороо”. Нэг.

Хоёрдугаарт нь, өчигдөр тодруулаад танилцуулна гэсэн. Энэ зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл байгаа юу гэдгийг Зам, тээврийн яам энэ дээр хэлж протоколд тусгах нь зүйтэй байх.

Тэгээд санал хурааж өгөөч ээ.

Р.Сэддорж: 8 номер. Өөрийгөө танилцуулаад хариулъя.

Г.Батбаяр: Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр байна.

Саналын 91 дүгээр асуудал дээр боомтын асуудлыг Боомтын сэргэлтийн Үндэсний хороо хариуцдаг.

Зураг төслийн хувьд гишүүн та аль юуг хэлсэн бэ? Энэ боомтын сэргэлтийн ачаа тээврийг нэмэгдүүлсэн байна гээд. Манай дээр л лав энэ ажил байхгүй байгаа. Боомтын сэргэлтийн Үндэсний хороо л энэ дээрээ зураг төсөл, ТЭЗҮ-тэй эсэхээ хэлэх байх.

Р.Сэддорж: Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос хүн байгаа юу? Боомтын сайд Б.Тулга сайд ирсэн байсан. Эдийн засаг, хөгжлийн яам. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат.

Янэ яг хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагч болон сайдаас нь ийм санал манай дээр ирээгүй учраас бидэнд мэдээлэл байхгүй байна.

Р.Сэддорж: Гишүүдийн гаргасан 91 дэх саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

92.Төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” хэсгийн “1.6.Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна” гэсэн зорилтот үр дүнг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

Д.Энхтүвшин гишүүн санал тайлбарлая.

Д.Энхтүвшин: Тийм. Энэ миний саналууд болохоор төслийн 3 дугаар хавсралттай холбоотой саналууд байгаа. Мөнгө төгрөгтэй холбоотой саналууд байхгүй.

Энэ үзүүлэлтүүдийг нь сайжруулах, агуулгад нь нийцүүлэх гэсэн иймэрхүү заалтууд байгаа. Тэгээд эхний энэ саналын 92 дахь саналын хувьд яг үүнтэй адилхан заалт 3.6 дээр бас байгаад байна.

Тэгэхээр яг үүнтэй төстэй нэг үзүүлэлт хоёр газар заасан хоёр тохиолдол байгаа. Тэгэхээр аль нэгийг нь оруулахгүй бол. Тийм. Хоёр үзүүлэлт давхар яваад байх нь утгагүй байх гэж бодоод үүнийг хасъя гэсэн саналтай байна. 3.6 дээр яг адилхан заалт байгаа.

Р.Сэддорж: 92 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

93.Төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” хэсгийн “3.9. Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлсэн байна” гэсэн зорилтот үр дүнгийн “Хүлээн авах жуулчид” гэсэн зорилтот түвшин “1600” гэснийг “1000” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

94.Төслийн 3 дугаар хавсралтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн хэсгийн “4.4.Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлсэн байна” гэсэн зорилтот үр дүнг “4.4.Төрийн албыг чадавхжуулах.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

М.Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: “Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” гэсэн зорилтыг “Төрийн албаны хүний нөөцийн хууль бус томилгоог бууруулах” гээд хоёр өөр утга агуулгатай хоёр зүйлээр сольж байгаа нь яг ямар учиртай юм бэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Р.Сэддорж: Д.Энхтүвшин гишүүн хариулах уу? Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ зорилт, үр дүн нь болохоор “Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлсэн байна” гэж байгаа юм. Тэгэнгүүтээ энэ чадавхыг бэхжүүлсэн байгаа үзүүлэлтээ шалгуур үзүүлэлт нь болохоор “хууль бус томилгооны зөрчил” гэж байгаа юм.

Тэгэхээр нэг зорилтдоо нийцсэн шалгуур үзүүлэлт гарах хэрэгтэй.

Тэгэхээр би яг ямар үзүүлэлт бас гарахыг нь мэдэхгүй байгаа учраас ядаж хууль бус томилгооны зөрчлийг арилгая гэж байгаа юм бол зорилт, үр дүн гэдэг нэрийг нь өөрчилж байгаа юм. Тийм. Яамнаас нь.

Р.Сэддорж: 2 номер.

Ц.Эрдэнэбат: Тийм. Төрийн албаны зөвлөлөөс ирсэн саналаараа явж байгаа.

Тэгээд хэмжигдэхүйц байх ёстой учраас өөрсдийнх нь ирсэн санал нь “Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлсэн байна” гэдгээрээ явбал зөв байх гэж бодож байна. Тийм.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга томьёоллоо хэлье.

М.Бадамсүрэн: Тийм. Энэ өргөн мэдүүлсэн төсөл дээр нь энэ их ойлгомжгүй байгаа юм л даа.

Хууль бус томилгоог. Бүр ингэж бичсэн байсан юм. Тийм. Хууль бус томилгоог хүлээн зөвшөөрч байгаа юм шиг болоод. Үүнийг яг үнэндээ сайжруулъя гэвэл төрийн албан хаагчдыг аттестатчилна гэх юм уу, ер нь төрийн албаны бүтээмжийг нэмэгдүүлнэ гэх юм уу. Тийм утгаар орохгүй бол болохгүй байгаа юм.

Тэгэхээр төрийн албыг чадавхжуулах гэдэг томьёоллоор үүнийг хэмжих нь зүйтэй байх гэж бодож байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн даргын томьёолсноор 94 дүгээр саналаар “төрийн албыг чадавхжуулах” гэх мэт өөрчлөлтийг оруулаад 94 дүгээр саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 9 хүн дэмжиж, санал дэмжигдлээ.

95.Төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” хэсгийн “4.5.Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлсэн байна” гэсэн зорилтот үр дүнгийн зорилтот түвшинг “3” гэснийг “4” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

96.Төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” хэсгийн “4.6.Төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниудын засаглал сайжирч, зах зээлийн зарчимд шилжсэн байна” гэсэн зорилтот үр дүнгийн “Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөж (ROE)” гэснийг “Шинээр хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй арилждаг болсон төрийн болон орон нутгийн өмчит компанийн тоо” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

М.Мандхай гишүүн асуулт асууя. М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Энэ дээр “төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөж” гэснийг яагаад “шинээр хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй арилждаг төрийн болон орон нутгийн өмчит компанийн тоо” гэж өөрчилж байгаа вэ гэдэг.

Тэгэхээр одоо үндсэндээ бусад төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөжийг хэмжих боломжгүй гэсэн үг юм уу? Энэ дээр тодруулга хэлээч.

Р.Сэддорж: Д.Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Энэ бас яг зорилт, үр дүн, шалгуур үзүүлэлт хоёр нь зөрчсөн ийм үзүүлэлт байгаа. Өөрөөр хэлбэл төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжирч, зах зээлийн зарчимд шилжсэн байна гэдэг үзүүлэлтийг энэ хөрөнгийн өгөөжөөр, тэгээд хөрөнгийн өгөөжийн суурь түвшин “1” байгааг “3” болгоно гэсэн. Өөрөөр хэлбэл хөрөнгийн өгөөж RETURNING ASSET нэг куб байж байгаад тэрийг нь 3 хувь гэдэг энэ алдаа гарсан уу.

Тэгэхээр гол агуулга нь болохоор зах зээлийн зарчимд шилжүүлнэ гэж байгаа учраас нээлттэй болгох гэж алдсан юм биш байгаа. Энэ дээр уг нь тодруулга. Хариуцсан яамнаас байвал. Эдийн засаг, хөгжлийн яамнаас ч юм уу тодруулга авбал зүгээр байгаа.

Р.Сэддорж: 2 номер.

Ц.Эрдэнэбат: Ирүүлсэн саналыг нь би тодруулаад хэлье.

Р.Сэддорж: 96-г дахиж санал хураана. 97-г явуулж байя.

Төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн” хэсгийн “1.1.1.Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна” гэсэн Зорилтот үр дүнгийн Зорилтот түвшин “15” гэснийг “16” болгож өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Д.Энхтүвшин гишүүн тодруулга хэлье.

Д.Энхтүвшин: Энэ үзүүлэлтүүд нь болохоор бие даасан байдлыг нэмэгдүүлнэ гэсэн мөртлөө зорилтот түвшин 15-ыгаа 15-аар нь хадгална гэхээр нэмэгдүүлэх биш яг хэвээр нь байлгаж байна. Эсвэл нэрээ солих, хэвд нь хадгалах гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, бие дааж төсвөөс хамааралгүй байгаа аймгийн тоо 15 гэдэг тоо зөв үү, үгүй юу гэдэгт.

Тэгэхээр үүнийг өөр мэдээллээс 15 гэдэг бол өндөр байна гэсэн мэдээлэл байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулж өгөөч. Тэгээд үзүүлэлтийг нь ядаж нэгээр ч гэсэн нэмэгдүүлэхгүй бол нэмэгдүүлсэн гэдэг утга нь таарахгүй байна.

Р.Сэддорж: Хариулт. Эдийн засаг, хөгжлийн яам. 2 номер. Ц.Эрдэнэбат дарга.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат.

Энэ ийм агуулгатай юм байна. Нөгөө улсын төсвөөс дотаци авдаг аймгуудын тоо гэсэн агуулга юм байна.

Р.Сэддорж: Тэгээд энэ 97 дээр 15 гэснийг бууруулж. Тийм. 15-ыг бууруулах гэдгээр оруулж хэлээд байна. Тийм.

15-ыг 14 гэж бууруулах гэсэн саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

98.Төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн” хэсгийн “1.6.1.Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.” гэсэн зорилтот үр дүнг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

99.Төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн” хэсгийн “2.13.2. Хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлсэн байна” гэсэн зорилтот үр дүнгийн

“Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалинтай ажиллагчдын эзлэх хэмжээ” гэснийг “Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэснийг “мянган төгрөг” гэж, Суурь он “2023” гэснийг “2024” гэж, суурь түвшин “11” гэснийг “2.332.4” гэж, Зорилтот түвшин “10” гэснийг “3.500.0” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ бас яг зөрчилтэй. Үр дүн, шалгуур үзүүлэлт хоёр зөрчилтэй байгаа юм. Хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ гэнгүүтээ хөдөлмөрийн хөлснөөс доогуур үнэлгээтэй ажилчдын эзлэх хувийг гэсэн ийм үзүүлэлт байгаа юм.

Тэгэхээр ядаж цалингийн түвшнээ сайжруулна гэсэн үзүүлэлт байвал гэдэг ийм үзүүлэлт орвол яасан юм бэ гэсэн санал байгаа юм. Тэгээд яамтай ярьсан. Яамны холбогдох хүмүүстэй ярьсан. Үзүүлэлтүүд нь ингэж явж болж байна гэсэн. Өсөлтийг нь сүүлийн жилүүдэд нэрсэн цалингийн үзүүлэлт 24, 25 орчим хувийн өсөлттэй байгаа юм билээ.

Тэгэхээр 2024 оны өсөлтийг сүүлийн жилүүдийн яг дунджаар нь өсгөөд 3.5 сая төгрөг гэсэн үзүүлэлтээр өөрчлөх ийм санал байгаа.

Р.Сэддорж: 99 дүгээр саналаар санал хураалт. /алх цохив/

17-гоос 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

100.Төслийн 3 дугаар хавсралтын Хөтөлбөрийн үр дүн хэсгийн “3.15.1. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн байна.” гэсэн Зорилтот үр дүнгийн Зорилтот түвшин “13.3 хувь” гэснийг “15 хувь” болгон өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ 96 дугаар санал дээр Эдийн засаг, хөгжлийн яам төслийн 3 дугаар хавсралтын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн хэсгийн 4.6 төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниудын засаглал сайжирч, зах зээлийн зарчимд шилжсэн байна гэсэн зорилтот үр дүнгийн төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөж гэснийг шинээр хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй арилждаг болсон төрийн болон орон нутгийн өмчит компанийн тоо гэж өөрчлөх дээр тайлбар. 2 номер. М.Мандхай гишүүн асуусан. Тийм ээ. 5 номер.

Б.Цэнгэл: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид 2026 оны хөгжлийн хөтөлбөр дээр компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр хоёр л зорилго дэвшүүлээд байгаа шүү дээ.

- Бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлье.
- Зардлыг 15 хувиар бууруулъя л гэж байгаа юм.

Тэгэхээр төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд нэг өөр. Орон нутгийн өмчит компанийн хувьд зохицуулалт нь бас өөр байгаа.

Яагаад гэхээр нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага учраас тухайн орон нутгийн иргэдийн хурлынхаа шийдвэрээр явж байгаа юм.

Тэгэхээр миний бодлоор шинээр бий болж байгаа төрийн болон орон нутгийн өмч, тэгэхдээ хувьцаат компани гэж байна шүү дээ. Хувьцаат компанийн хувьд зохицуулалт нь арай өөр. Шууд засаг хувьцаат компанийн үйл ажиллагаанд шууд оролцоод байх боломж байхгүй.

Тэгэхээр тэр компанийнхаа хуулиараа зохицуулагддаг зарчимтай байгаа юм. Тэгэхээр миний бодлоор хуучин байгаа заалтаар нь явбал яасан юм бэ гэж.

Ер нь энэ асуудал Их Хурлын бүрэн эрх буюу Их Хурал үндсэн чиглэлийг нь батлаад Засгийн газарт жагсаалтаа гаргаад явдаг зохицуулалттай байгаа юм. Харин бид ойрын хугацаанд Засаг дээр Их Хуралд өргөн барих үндсэн чиглэлийг буюу биржээр IPO гаргах компаниудынхаа үндсэн чиглэлийг Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Гол нь өгсөн санал нь зорилт, үр дүнтэй нийцэхгүй болохоор арга ядаад ийм үзүүлэлт оруулсан юм.

Тэгэхээр танилцуулга дээр байсан зардлыг 15 хувиар буулгана, өгөөжийг 30 билүү. Нэмэгдүүлнэ гэсэн заалтаа энэ дотроо оруулаад **ROE /RETURN ON EQUITY/** гэдгийг. Хэзээ ч **ROE=1%** байгаа үзүүлэлтийг 1 гэж бараг аягүй хэцүү байхгүй юу. Оруулсан хөрөнгийн өгөөж 1-хэн хувь байна гэдэг. Тэрийг 3 хувь болгоно гэж шалгуур үзүүлэлт тавиулбал энэ жоохон зохимжгүй байх.

Тэгэхээр үүнийгээ хасаад оронд нь тэр **“зардал бууруулах”, “өгөөж сайжруулах”** гэдэг хоёр үзүүлэлтээ оруулбал яасан юм. Тэгээд санал хураалгая.

Р.Сэддорж: 5 номер.

Б.Цэнгэл: Хөрөнгийн өгөөж 2023 онд компаниудын хувьд 7.76 гарсан л даа. Ерөнхийдөө өсөлттэй байгаа.

Гэхдээ ерөнхийдөө олон улсын жишгээрээ 8 хувиас дээш бол эрсдэлгүй гэж үзэж байгаа. 8 хувиас дээшээ.

Тэгэхээр энэ түвшинд хараахан хүрээгүй байгаа. Гэхдээ өмнө нь 3 хувь, 2 хувь байсан бол 7.76 гэдэг бол бас эрсдэлгүй тал руугаа явж байна гэж бид үзэж байгаа.

Гэхдээ үүнийг өсгөөд. Зардал бууруулах талд бид 2.0 их наядын бууралтыг төлөвлөөд байгаа байхгүй юу. Гэхдээ үүнийг бүрэн бололцоотой гэж үзэж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга томьёоллоо хэлээд санал хураалт явуулъя.

М.Бадамсүрэн: Д.Энхтүвшин гишүүний гаргасан саналыг ажлын хэсэг дэмжсэн.

Гэхдээ өнөөдөр хэлэлцүүлэг өрнүүлэхээр бас нэлээн ийм бодлогын хувьд шал өөр юм руу орж байгаа учраас нөгөө үндсэн тэргүүлэх чиглэлийн бодлоготойгоо нийцүүлэх үүднээс төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөжийг 30 хувиар нэмэгдүүлэх. Нөгөө тэргүүлэх зорилт дээрээ байгаагаараа. Тийм. Байгаагаараа болон зардлыг бууруулах. 15 хувиар гээд тэргүүлэх зорилт дээр байгаагаараа яг тэр томьёоллоороо ингэж бичиж томьёолж санал хураалгая гэсэн саналыг гаргаж байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн гаргасан томьёоллоор 96 дугаар саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн дарга хоёр юу байгаа. Тийм ээ. М.Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Бид нарын зарчмын зөрүүтэй санал хураалгасны 44 дүгээр хэсэгт байгаа гүүртэй холбоотой заалт байгаа.

Энэ дээр байршил тавья гэсэн саналыг Зам, тээврийн яамнаас гаргасан. Энэ дагуу Дорнод аймаг, Чойбалсан хот гэж 44 дүгээр зүйл дээр байршлийг тавьж өгөх шаардлагатай байна гэдгийг Зам, тээврийн яамнаас санал өгсөн. Үүнийг хурааж өгөөч. Өөрчлөлт оруулж.

Хоёрдугаарт нь, тэр 34 дүгээр зүйл дээр байгаа заалтыг тэргүүлэх чиглэлийнхээ холбогдох заалттай нийцүүлэн уялдуулан түүндээ холбогдох өөрчлөлтийг оруулж 34 дэх заалтыг тэргүүлэх чиглэл дээрээ байгаа холбогдох заалтад нийцүүлж үүн дээр өөрчлөн найруулах энэ замаар оруулж өгье гэдэг ийм хоёр томьёоллоор санал хурааж өгөөч.

Р.Сэддорж: 34 дэх санал хураалтын томьёололыг хэлье. Ажлын хэсгийн дарга.

М.Бадамсүрэн: 34 дэх заалтыг тэр хасна гэж түрүүн санал хураалгасныг өөрчлөөд Төслийн 1 дүгээр хавсралт буюу 4.4 Шударга байдлын үзүүлэлтийг сайжруулна гэдгийн 4.4.1 дээр авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж, Трансперенси интернэйшнл олон улсын байгууллагын авлигын төсөөллийн индексийн оноог сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ гэдэг хэсэг рүү энэ хэсгийг уялдуулж үндсэн баримт бичгийнхээ заалттай уялдуулж энэ дээрээ оруулъя гэсэн ийм саналаар.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн даргын гаргасан саналын томьёоллоор 34 дүгээр санал дээр санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн дарга 44 дэх саналыг томьёолж хэлье. М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Зам, тээврийн яамны саналын дагуу энэ дээр байршил тавьж өгье л гэж байгаа юм.

Тэгээд Дорнод аймаг, Чойбалсан хот гэсэн байршлийг нэмэх. Дорнод аймаг, Хэрлэн сум гэсэн байршил.

Р.Сэддорж: 44 дүгээр санал Дорнод аймгийн Хэрлэн сум гэсэн байршлийг нэмээд санал хураалт явуулъя. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, 44 дүгээр санал дэмжигдлээ.

Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Өчигдөр ажлын хэсэг дээр хэлэлцсэн нэг асуудал энэ алдаа гараад орхигдсон байна. 33 дугаар санал байсан. Өчигдрийн ажлын хэсэг дээр.

Тэгэхээр энэ саналыг уншаад энэ санал хураалгах бас саналтай байна.

Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг Боловсролын зээлийн сангийн тэтгэлгээр гадаадад сургах, мэргэшүүлэх гэсэн 2.1.15 дахь заалт нэмэх гэсэн ийм саналыг өчигдөр ажлын хэсэг дээр хэлсэн. Санал хураасан.

Тэгээд энэ саналыг орхигдуулсан байна. Үүнийг Байнгын хороон дээр томьёолох уу.

Томьёолол нь Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг Боловсролын зээлийн сангийн тэтгэлгээр гадаадад сургах, мэргэшүүлэх гэсэн 2.1.15 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

Р.Сэддорж: С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ саналыг Боловсролын зээлийн сангийн ажлын хэсэг дээр бас ярьсан. Сүүлийн 30 жил гаруй нийтдээ 300 тэрбум орчим төгрөгийн тэтгэлэг явсан байна.

Яг энд ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш нарыг тэтгэлэг болон ямар нэгэн дэмжлэгээр гадаадад сургах асуудал ерөөсөө орхигдсон юм билээ. Өөрөөр хэлбэл боловсролын салбарынхаа хүмүүсийг орхисноос болоод боловсролын ялангуяа анхан шатын сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг ирэх жил “БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ЖИЛ” болгож байгаатай холбоотойгоор бодлогоор дэмжиж оруулж ирж дэмжье гэдэг саналыг оруулж байгаа юм.

Тэгээд мөнгө төгрөгийн хувьд Боловсролын зээлийн сан өөрөө төсөвтэй, хөрөнгөтэй. Үүнийг нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын байнгын хороо ч гэсэн ерөнхийдөө дэмжиж байгаа.

Тийм учраас үүнийг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна аа, гишүүддээ.

Р.Сэддорж: 101 дэх санал болж байна. Тийм ээ. Ингээд саяын гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

17-гоос 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Одоо Байнгын хорооны саналууд үүний дараа санал хураагдана. Одоо яаралтай санал хураалт байгаа тул 10 минут завсарлая. Чуулганд саналтад орьё.

Байнгын хорооны хурал үргэлжилж байна.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулж дууссан.

Одоо бусад Байнгын хороод Тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналуудаар санал хураалт явуулъя.

Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дэмжээгүй санал.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.3 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.23, ШСБ-3.4.1, ЗГҮАХ-3.3.4.15” гэж, Төсөл арга хэмжээ “3.3.1.5.Малын гаралтай түүхий эд, арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж” гэж, Шалгуур үзүүлэлт “Ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний экспортын өсөлт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “9,400.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилтийн хэмжээ “5,400.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэсэн 3.3.1.5 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт.

Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 9 хүн дэмжиж, санал дэмжигдлээ.

С.Бямбацогт гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт “3.4.10.“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд баруун бүс нутгийн өмнөх түвшиндээ хүрч чадахгүй байгаа газар тариалан, гурилын үйлдвэрийг сэргээн хөгжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлж, үйлдвэрлэл, хангалтыг нэмэгдүүлэх суурийг тавих.” гэсэн 3.4.10 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт “3.4.11.Газар тариалангийн салбарт үрийн үйлдвэрлэл, чанарт тавих стандартыг онцгой анхаарч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон өндөр ургац өгдөг, чанартай, баталгаат

үрээр хангах үрийн аж ахуйнуудыг бэхжүүлэх дэмжлэг урамшууллын тогтолцоо нэвтрүүлнэ.” гэсэн 3.4.11 дэх заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал.

Байнгын хорооны дэмжсэн 2 дахь саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт “3.4.12.Хүн амын хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүн хүнсний түүхий эд улаан буудайн стратегийн нөөцийг бүрэн бүрдүүлэх.” гэсэн 3.4.12 дахь заалт нэмэх.

Санал гаргасан. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал.

Байнгын хорооны дэмжсэн 3 дахь саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 9 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2 дахь хэсэгт “1.2.5.“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг эрчимжүүлж, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулж, бүсийн онцлогт тохирсон газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлд “Шинэ хоршоо 2.0” арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн 1.2.5 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг.

Байнгын хорооны дэмжсэн 4 дэх саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 6 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт “2.1.14.”Малчин залуу-манлайлагч” арга хэмжээг үргэлжүүлж, малчид хоршоологчдод мал аж ахуйн гаралтай түүхий эд, бэлтгэлийн үйл ажиллагаанд бүс нутаг, олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмших, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах ур чадварыг гадаад улсад олгоход чиглэгдсэн төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн 2.1.14 дэх заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг.

Байнгын хорооны дэмжсэн 5 дахь саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт “3.4.10.Малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн үе шат бүрт стандарт нэвтрүүлж, мал аж ахуйн салбарын кластерийн тогтолцоог бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.” гэсэн 3.4.10 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг.

Асуулт асуух хүн байна уу? 6 дугаар саналаар санал хураалт явуулъя.
/алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.6 дахь хэсэгт “3.6.5.Цөлжилттэй тэмцэх, гангийн үр нөлөөг бууруулах, бэлчээрийн газрын тогтвортой менежментийг сайжруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн 3.6.5 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа.

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 5 гишүүн дэмжиж, Э.Болормаа гишүүний санал Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдлээ.

Одоо Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2 санал хураалт үргэлжилнэ.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.5 дахь хэсэгт “4.5.6.Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэнэ.” гэсэн 4.5.6 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хоёр. Энэ саналыг Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй учраас зүгээр уншъя. Түрүүн хураасан санал.

2.Төслийн 2 дугаар хавсралтын 2.15 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд “Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг

нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.6.14” гэж, Төсөл, арга хэмжээ “Цахим соёл-II” арга хэмжээ хэрэгжүүлэх /CREATIVHUB, GLAM Галерей, номын сан, архив, музейн дундын цахим систем/” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “5” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “3,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “1,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэсэн 2.15.1.6 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин.

Санал хураагаад Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй байна.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Редакц хийх эрхийг нь олгож байгаа. 3 дугаар саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3.3 дахь заалтыг “2.3.3.Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, төрийн бүх албан хаагчдыг хүүхэд хамгааллын болон хүний эрхийн цахим сургалтад хамруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэнэ.” гэж өөрчлөн найруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.1 дэх заалтыг “2.2.1.Хүн амд зонхилон тохиолдож байгаа зүрх судас, хавдрын өвчлөлийг эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөн найруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа.

Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.2 дахь заалтыг “2.2.2.Гарцад суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг бэхжүүлэх хүрээнд тусламж, үйлчилгээ худалдан авагчийн чанар, төлбөрийн хяналтыг хиймэл оюун ухааныг ашиглаж боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үр ашгийг сангийн актуар тооцоолол дээр суурилан нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.4 дэх заалтыг “2.2.4.Төр, хувийн хэвшлийн үр ашигтай, үр дүнтэй түншлэлийг бий болгох хүрээнд эрүүл мэндийн салбарын төсөв дэх олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлдэг тогтолцоог бүрдүүлж, үр дүнг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана.” гэж өөрчлөн найруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.6 дахь заалтыг “2.2.6. Хүн амын амьдралын хэв маяг, зан үйл, орлого, боловсролын түвшин, орчин, ахуйн нөхцөл, соёл уламжлал зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг харгалзан, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгахад нөөцийг үр ашигтай хуваарилах замаар нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг оновчтой тодорхойлж, үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлснээр хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт “2.2.7.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, гэнэтийн осол, гадны шалтгаант нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.” гэсэн 2.2.7 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан. Санал хураалт.
/алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.3 дахь заалтын “бэхжүүлж,” гэсний дараа “яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан. Санал хураалт.
/алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1 дэх хэсэгт “1.1.5.Бүсийн зөвлөлд нийгмийн түншлэгч байгууллагууд, Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч байгууллагын оролцоог хангаж, Бүсийн хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн хэлэлцээр байгуулна.” гэсэн 1.1.5 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт.
Тайлбарлах уу? С.Эрдэнэбат гишүүн тайлбарлая.

С.Эрдэнэбат: Энэ ийм учиртай юм. Хуучин аймаг аймгаараа хэлэлцээр байгуулдаг байсан. Хөдөлмөр нийгмийн хэлэлцээр гээд Засгийн газар нь, Засаг дарга нар нь үйлдвэрчний эвлэлийн, ажил олгогч нар нь.

Одоо нөгөө бүсийн юу гэж байгаа учраас нөгөө аймгууд нэгдэж юмаа ярих энэ концепцыг нь, бүсийн хэлэлцээр гэдэг зүйлийг байгуулах шаардлага гарч байгаа учраас.

Тэгээд бүсийн зөвлөлүүд нь ер нь ороод явуулахгүй бол. Одоо бүсийн зөвлөлүүд дээр юу болж байна вэ гэхээр дандаа засгийн төлөөллүүд голдуу орсон. Нөгөө бизнес эрхлэгчдийнх нь төлөөлөл, ажилчдынх нь төлөөллүүд байхгүй байгаа учраас ингээд оруулъя гэдэг байдлаар оруулж байгаа шүү. Гишүүд ээ. Тийм.

Засаг бол өөрөө дэмжсэн. Үүнийг.

Р.Сэддорж: 8 дугаар саналаар Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3 дахь хэсэгт “2.3.7.Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг нийгмийн түншлэгч Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан бууруулна.” гэсэн 2.3.7 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт “2.2.8.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.” гэсэн 2.2.8 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай. Төсөв нь байгаа юм байна. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсэгт Төсөл, арга хэмжээ “2.1.1.8.Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга худалдан авах” гэж, Шалгуур үзүүлэлт “Худалдан авсан барилга” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “40,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “10,000.00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын тамгын газар” гэсэн 2.1.1.8 дахь төсөл, арга хэмжээ нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн.

Ж.Чинбүрэн гишүүн Байнгын хорооны дэмжсэн саналаа тайлбарлах уу? 11 дэх санал. Ж.Чинбүрэн гишүүн хуруугаа уншуулж байж орох юм байна.

Ж.Чинбүрэн: Эдийн засгийн байнгын хороон гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Баянзүрх дүүрэгт яагаад нэгдсэн эмнэлэг хэрэгтэй байгаа гэхээр 500 гаруй мянган хүн амтай. Бусад дүүргүүдээ бодох юм бол ийм улсын чанартай эмнэлэг байдаггүй.

Дээрээс нь төсвийг нь харах юм бол их боломжийн өртөгтэй. Та бүхэн мэдэж байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр барьсан эмнэлэг өөрөө 60 сая долларын өртөгтэй эмнэлэг шүү дээ.

Тэгэхээр бид зарим харьцуулалтыг нь харах юм бол жишээлбэл Сүхбаатар дүүрэгт 50 орчим тэрбум төгрөгөөр 100 ортой нэгдсэн эмнэлэг барьж чадсан туршлага байдаг.

Энэ бүгдийг ингээд харах юм бол бид богино хугацаанд барих гэж нэг тендер зарлаж баахан мөнгө төгрөг урсаж, хугацаа сунгаж, баахан зардал

нэмэгддэг бол богино хугацаанд бэлэн байгаа үйл ажиллагааг эхлүүлэх боломж бас байгаа.

Энэ талаар Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн газраас олон судалгаа хийгээд, судалгааны үндсэн дээр ийм барилгууд манай дүүргийн хэмжээнд байж болох юм байна гэдэг судалгаа гаргаад өнгөрсөн оны төсөвт тавьсан. Үүнийг тендерээ зарлаад хийж чадахгүй байсаар байгаад өнгөрсөн жил тавьсан байсан 10 тэрбум төгрөгөө алдсан. Нэг ёсондоо хэрэгжүүлж чадаагүй байхгүй юу.

Тэгэхээр би бас одоо үүнийг Та бүгдийг дэмжиж өгөөд, Баянзүрх дүүргийн энэ олон иргэд, нөгөө менежментийн хувьчлал гээд тэртээх 90-ээд оны үед Баянзүрх дүүргийн эмнэлгийг нь хувьчлаад авчихсан. Тэгээд ийм л хүнд байдалтай байгаа юм.

Тэгээд Та бүгдийг үүнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Р.Сэддорж: М.Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Та олон судалгаа хийгдсэн гэлээ. Яг одоо байгаа барилгатай дүйцэхүйц хэмжээний шинээр барилга баривал өртөг нь хэд болж байгаа юм? Баянзүрх дүүрэгт.

Гэхдээ Азийн хөгжлийн банкны тэр чинь арай өөр. Хэмжээ болон зохион байгуулалт.

Яг одоогийн байгаа шигээ барилга хэрэв барихаар болбол төсөвт өртөг нь хэдээр баригдахаар байгаа вэ?

Р.Сэддорж: Хариулт Ж.Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Нэгдсэн эмнэлэг гэдэг маань бүх л төрлийн үйлчилгээ үзүүлэх учраас доор хаяж л 20 мянган метр квадрат талбайтай барилгын асуудал яригдана.

20 мянган метр квадрат талбайг бид 5 сая төгрөгөөр бодъё л доо. Тийм ээ. Одоо зах зээлийн бодитой. Эмнэлгийн барилга чинь зүгээр орон сууцын барилгыг бодох юм бол илүү хана нь зузаан, дээрээс нь дэд бүтэц гэвэл агааржуулалтын, цахилгааны эх үүсвэр гээд л олон зүйлийг ярина.

Ингээд бодоход л энэ чинь бараг 100 тэрбум руу очих гээд байгаа байхгүй юу. 100 тэрбум руу очих гээд байгаа юм.

Р.Сэддорж: Асуулт. Ш.Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Барилгыг 40 тэрбум төгрөгөөр худалдаж авна гэж оруулж ирж байгаа юм байна.

Ер нь энэ хэдэн метр квадрат барилга юм бэ? Худалдаж авах гэж байгаа эмнэлэг маань. Тэгээд судалгаа нэлээн сайн хийсэн гэж байна. Нэг л ийм бүхэл дүнгээр орж ирээд байгаа байхгүй юу. 40 тэрбум гээд. Судалгаа хийсэн бол метр квадратын үнэлгээ юмнууд нь яагаад бүхэл дүнгээр орж ирж байгаа юм?

Тэгээд энэ эмнэлгийг бид худалдаж авлаа гэж бодоход. Яах вэ, барилга нь боллоо гэхэд цаашдаа бас тоног төхөөрөмж ер нь хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай вэ гэсэн хоёр асуултыг асууя.

Р.Сэддорж: Ж.Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Тухайн үеийн Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн газраас хийсэн судалгаагаар ойролцоогоор 1 метр квадрат нь 3.5 сая төгрөгт бүтэхээр. Дээр нь 5 тэрбум төгрөгт тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гээд нэмээд ингээд 40 тэрбумдаа болно гэсэн ийм тооцоо гаргаж өгч байсан.

Р.Сэддорж: Сангийн яам 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Энэ барилгын хувьд өмнө нь төсвийн хөрөнгө оруулалтын хууль дээр батлагдаж байсан.

Тэгээд тодотголын хүрээнд гэрээ байгуулагдаж амжаагүй учраас хасагдаж байсан төсөл, арга хэмжээ байна. Дүн нь яг энэ дүнгээрээ байсан.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа.

Ажлын хэсгийн дарга М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Зураг төсөв нь байгаа юу? Сангийн яамнаас.

Р.Сэддорж: 9 номер Сангийн яамнаас хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Хавдрын эмнэлгээс ялгаатай. Хавдрын эмнэлгийн хувьд 2025 оны төсөв дээр урсгал зардлаас түрээс байдлаар худалдаж авахаар тусгагдсан. Тусдаа эмнэлэг.

Энэ эмнэлгийн хувьд 2024 оны төсөвт Засгийн газраас өргөн барьсан дээр биш, Улсын Их Хурал дээр нэмэгдэж батлагдаж байсан. Худалдаж авах барилгын хувьд шинээр барих барилгаас ялгаатай нь зураг төсөв гэж байдаггүй. Яг зах зээлийн үнэлгээний компаниудаар хийсэн үнэлгээгээр худалдан авалт нь зарладаг ийм жишигтэй.

Худалдаж авна гэхээр хувийн өмч л байх. Бэлэн барилга байх. 2025 оны төсөвт байхгүй. 2024 он дээр байсан.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Хоёрдугаарт нь, яах вэ ер нь эмнэлэгтэй болохыг дэмжинэ. Одоо газар, байршил олдохгүй хүнд байгаа.

Гэхдээ энэ дээр санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал нь “орон нутгийн төсөв” гээд бичсэн байна. Энэ одоо аль шатны төсөв юм бол? Тэгээд бид үүнийг ингээд хөгжлийн төлөвлөгөө дээр тусгаж болох уу? Сангийн яамнаас л асуух гээд байна л даа. Саналаа өгөхөөсөө өмнө үүнийг асуух гээд байгаа юм.

Р.Сэддорж: Сангийн яам асуултад хариулъя. 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Тийм. Орон нутгийн төсөв, нийслэлийн төсөв гэхээр миний түрүүний хэлсэнчлэн нэгдсэн төсвийнхөө нийт зардалд мэдээж хязгаартай орно. Гэхдээ орон нутгийн төсөв бол улсын төсөв батлагдсаны дараа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрөө задалж баталдаг. Сангийн яамнаас зөвхөн дээд хязгаарыг нь баталж өгнө.

Р.Сэддорж: Энэ ноднин төсөв дээр байсныг Та бүхэн санаж байгаа байх. Тийм ээ. Энэ эмнэлэг чинь юу биз дээ. Хавдрын эмнэлэг л өргөтгөл хийж орно биз дээ.

Баянзүрх дүүргийн эмнэлэг орж байгаа юу. 11 дүгээр санал дээр санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 2 хүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

12.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсгийн Хөтөлбөрийн үр дүн
“2.1.3. “Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг үргэлжлүүлэх” гэж, Төсөл, арга хэмжээ “2.1.3.1.Б, Д вирустай иргэдийн эмчилгээг үргэлжлүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Вирусын эсрэг эмчилгээ” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, “Нийт санхүүжилтийн дүн”-д “20,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “20,000.00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэсэн 2.1.3.1 дэх төсөл, арга хэмжээ нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн гишүүн. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

13.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсгийн Хөтөлбөрийн үр дүн
“2.1.4.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн техник технологийг нэвтрүүлнэ” гэж, Төсөл, арга хэмжээ “2.1.4.1.Робот мэс заслыг Монгол Улсад нэвтрүүлэх, тус мэс заслын аргаар хагалгаа хийж эхлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хагалгаа хийсэн тоо” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “5,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “5,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал

“Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэсэн 2.1.4.1 дэх төсөл, арга хэмжээ нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

14.Төслийн 2 дугаар хавсралтын 1.10 дахь хэсэгт Төсөл, арга хэмжээ “1.10.1.2.Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор, /Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаар хороо/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “80,000.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт “42,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэсэн 1.10.1.2 дахь төсөл, арга хэмжээ нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир.

Б.Мөнхсоёл гишүүн тодруулж асууна.

Б.Мөнхсоёл: Хариуцах үндсэн хариуцагч нь Эрүүл мэндийн яам гэж байна шүү дээ. Тийм ээ.

Тэгээд Эрүүл мэндийн яамны багцад орж ирээгүй. Тэгээд төсөвт өртөг нь багагүй дүнтэй орж ирээд байгаа учраас Сангийн яамнаас тодруулах хэрэгтэй байх гэж бодож байна. Ж.Дэлгэржаргалаас.

Р.Сэддорж: Сангийн яам 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Гишүүн ээ, энэ 14 дүгээр санал уу? Тийм ээ. Энэ нь яг төсөв дээр сууж байсан тодорхой мэдээлэл энэ төсөл дээр байхгүй байгаа.

Тэгэхээр 300 ортой эмнэлэг гэхээр 80 тэрбум гэхээр шинээр барих тохиолдолд заавал зураг, төсөвтэй байх ёстой.

Одоо аймгуудад 300 ортой эмнэлэг 26 тэрбумаар баригдаж байгаа.

Тэгэхээр төсвийн төсөл дээр ч юм уу, ирэх оны төсөв дээр ийм төсөл төлөвлөсөн зүйл байхгүй байгаа.

Р.Сэддорж: 14 дүгээр санал хураалт. Налайх дүүргийн эмнэлгийн тухай. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 1 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

15 дахь санал хураалт хийгдсэн учраас шаардлагагүй.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналуудаар санал хураая.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт “2.2.7.Нийтийн эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөө /2026-2036/ батална” гэсэн 2.2.7 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 дэмжиж, Ж.Баярмаа гишүүний санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3 дахь хэсэгт “2.3.7.Гэр бүлийн цогц хөгжлийг дэмжих төвийг байгуулна.” гэсэн 2.3.7 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 12 гишүүн дэмжиж, Л.Энхнасан гишүүний санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт “2.1.14.Багш ажилчдын цалин хөлс, нийгмийн асуудлыг тэргүүн ээлжинд сайжруулна.” гэсэн 2.1.14 дэх заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

С.Эрдэнэбат гишүүн тайлбар өгье.

С.Эрдэнэбат: Ирэх жил яагаад багш, боловсрол гэж онцолж оруулаад байна вэ гэхээр 2026 ондоо багш, ажилчдын гээд. Ажилчдын гэхээр сургууль дотор, цэцэрлэг дотор байгаа үйлчилгээний ажилчид нь бас барьцаад байдаг юм билээ. Нэг байгууллага дотор байж байгаа хүмүүсийн багш нарыг нь дэмжихээд бусдыг нь хаячихна гэдэг тэр утгаараа орж байгаа юм шүү.

Түүнээс биш нийт ажилчдын гэдэг байдлаар биш.

Тэгээд дээрээс нь ер нь нэг салбарыг онцгойлон гэж. Тэгэхгүй гэдэг ерөнхий зарчим бол зөв. Гэхдээ нэг жилийг онцлог гэж зарлаж байгаа бол тэр салбарт нь энэ удаадаа жоохон онцлог байдлаар цалин хөлс, нийгмийн хамгаалал гэдэг юмыг нь жоохон шинэ шатанд гаргаад өгье гэдэг утгаараа л оруулаад байгаа юм шүү. Тийм.

Ирэх жилийг боловсролын жил болгоё гээд Засгийн газар чинь өөрөө зарласан. Тэгээд энэ багш, ажилтныхаа. Одоо үндсэн цалин гэхэд сая 400 мянган төгрөг байгаа шүү дээ.

Тэгээд гүйцэтгэлийн үнэлгээ гээд янз янзын дунд нь будилаантай юмнууд зөндөө байгаа юм билээ.

Тийм учраас ер нь яах вэ боловсролдоо жоохон хөрөнгө оруулалт хийх юмаа нэмж таарна гэдэг үүднээс л энэ жил онцолчихъё гэдэг утгаар нь оруулсан. Боловсролын яам нь ч гэсэн өөрөө тэгж үзэж байгаа. Засгийн газар ч гэсэн бас тэгж байгаа юм билээ.

Ажилчдын гээд яах вэ, Р.Сэддорж дарга аа, хасчихвал цөөхөн ордог. Харьцангуй цөөн масстай байдаг. Гэхдээ сургууль дотор байж байгаа нөгөө сургалтын менежер чинь яг нөгөө багшдаа ордоггүй. Яягүй чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Сургалтын менежерүүд.

Тэгээд нягтлан гээд сургууль нэг нэг л хүн. Яах вэ, тэгвэл багш гээд болно. Та хэд юугаараа.

Р.Сэддорж: Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, дэмжигдээгүй санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3 дахь хэсэгт “2.3.8.Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх” гэсэн 2.3.8 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Яагаад энэ хоёр салбарыг онцолсон бэ гэхээр хүний эрхийн 17 тогтвортой хөгжлийн зорилтын хоёр том юм нь манай Нэгдсэн Үндэстний Байгууллагынхан юу гэж үзсэн бэ гэхээр та нар суурь хоёр үйлчилгээ үзүүлдэг салбарынхаа ажилчдын цалин хөлсийг хаясан юм байна. Өрсөлдөх чадвар нь бүр доошоо орсон юм байна.

Тийм учраас нийтэд үйлчилж байгаа, ялангуяа улсын сургууль, улсын эмнэлгийн ажилчдын чинь гарах хөдөлгөөн үндэсний аюулгүй байдлынх нь түвшинд ирсэн юм байна. Одоо сувилагч нар гэхэд улсын хэмжээнд үндсэндээ бараг 20, 30 хувийн дутагдалтай, гадагшаа гараад явж байгаа хүмүүс нь маш их.

Ийм учраас би энэ эрүүл мэндийн салбарт цалин хөлсийг нь энэ хэвээрээ байлгаад байвал. Гэхдээ энэ дээр онцолж байгаа зүйл ерөөсөө биш шүү. Гүйцэтгэлийн үнэлгээгээр эмнэлгүүдэд санхүүжилтийг нь нэмээд өгөхөөр эмнэлгүүд нь цаанаа гүйцэтгэл гэж ярьсан мөртлөө цалин хөлс орлогуудыг нь

нэмэхгүй эмнэлгүүд зөндөө байгаа юм билээ. Нөгөө тоног төхөөрөмждөө зарцуулдаг, байшин засвартаа зарцуулдаг, тендертээ зарцуулдаг.

Тэгэхээр эмч нар яаж байна гэхээр улсын эмнэлэгт байж байсны оронд хувь руу явъя гээд аягүй олон сайн бэлтгэгдсэн, улсын мөнгөөр гадаад, дотоод сурсан, олон жил бэлтгэсэн туршлагатай туршлагатай эмч, ажилчид гадагшаа ерөөсөө нүүдэллэл нь аягүй их явагдаж байгаа. Боловсрол ч ялгаа байхгүй.

Тийм учраас энэ тал дээр тэр гүйцэтгэлийн үнэлгээн дотроо ажилчдын цалин хөлс, орлого нэмэгдсэн байх ёстой шүү гэдэг үнэлгээг нь тавьж өгөхгүй болохоор цаанаа очоод эмнэлгийн байгууллагууд нь менежментээ хийж чадахгүйгээс болоод цалин хөлсөө хаячхаад хувийн эмнэлэг рүүгээ ажилчдаа хаяад байгаа юм билээ.

Сувилагчийн хувьд бол бүр ярих юм байхгүй. Анагаахад сурч байгаа сувилагч нарын бараг 50 хувь нь гадагшаа гарах зорилгоор улсын сургуульд сурч байна гэж байгаа байхгүй юу. Төлбөрийг чинь үнэгүй заагаад өгч төлье гэхэд үгүй ээ, би сурчхаад гадагшаа явна, тийм гэрээ байгуулахгүй гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр үндсэндээ бид яг энэ хоёр салбар дээр одоо л анхаарал тавихгүй бол алдсаныхаа дараа буцааж авчирна гэдэг юм бол аягүй юу байгаа юм. Яах вэ, онцлох гэдэг дээр унах гээд байвал эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг гүйцэтгэлийнх нь үнэлгээнд нь тулгуурлан нэмэгдүүлэх гэдэг байдлаар.

Гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг чинь гүйцэтгэснээрээ нэмнэ л гэсэн үг шүү дээ. Тэгэхгүйгээр бусад салбарынхан барьцана гээд суугаад байх юм бол ямар ч гүйцэтгэлийн үнэлгээ хэрэггүй.

Харахад гүйцэтгэл боловч хувийн эмнэлэгт очихоороо 10 саяын хагалгаа хийнгүүтээ хувийн эмнэлэг 2 саяыг нь өгчхөж байгаа байхгүй юу. Шууд. Улсын эмнэлэгт ирэхээрээ нөгөө нөхрийн цалин бараг хэвээрээ байж байхаар ямар ч мотивац байхгүй болоод байгаа учраас гүйцэтгэлийн үнэлгээ гэдгийг нь тэгвэл нэмээд өгчихье. Дарга аа.

“Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг гүйцэтгэлийн үнэлгээнд нь уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ” гэдэг байдлаар. Гүйцэтгэлийн үнэлгээ дээр чинь бид мөнгийг нь тавиад өгсөн шүү дээ. 300 орчим тэрбум төгрөг.

Тэгэхгүй бол тоног төхөөрөмж, засвар луугаа хийдэг юм билээ. Нөгөө эмнэлгийн дарга, удирдлагууд чинь.

Р.Сэддорж: Б.Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Эмч, эмнэлгийн ажилтны цалинг эрс нэмэх ёстой. Энэ яах аргагүй. Зөвхөн энэ заалт биш. Нэмэх ёстой. Харин онцгойлоод “жил бүр

нэмэгдүүлэх” гээд иймэрхүү хэрэгжих боломжгүй муйхар заалт нэмэх юм бол харин нэмэх биш эсрэг үр дүнд хүргэнэ.

Тийм болохоор яг энэ заалтыг дэмжихгүй. Нэмэх бодлогыг дэмжинэ.

Р.Сэддорж: С.Эрдэнэбат гишүүн нэмж тайлбарлая.

С.Эрдэнэбат: Засгийн газрын 2024-2028 оны төлөвлөгөөнд “жил бүр нэмнэ” гээд тэртээ тэргүй суусан. Жил бүр. Гэхдээ онцлоод энэ хоёр салбарынхныг илүү нэмнэ гээд. Бүгд жигд байна гэдэг чинь бид социализмын л юм хийх гээгүй юм бол бүх хүний цалинг ижилхэн байлгана гэдэг чинь өөрөө утгагүй зүйл шүү дээ. Ер нь бол.

Тэгэхээр бид нарын хамгийн том эрсдэлтэй юу байна вэ гэхээр улсын эмнэлэг чинь сувилагч олдохгүй болоод байна. Суманд чинь эмч алга. Өнөөдөр эмчгүй сумууд аягүй их олон болж байгаа юм билээ. Аймгийн эмнэлэг дээр чинь маш олон эмнэлгийн ажилчид дутуу байгаа юм байна.

Тийм учраас энэ тал дээр онцгой тавихгүй бол одоо Их Хурлын гишүүдээсээ авхуулаад төрийн албан хаагч нар гэдэг юм уу, зарим нэгэн төрийн захиргааны албан хаагч нар нь эмч, багштайгаа барьцаад суугаад байвал болохгүй шүү дээ.

Тийм учраас энэ тал дээр аюулын харанга дэгдээд байгаа учраас онцгойлоод энэ хоёр салбарын цалин хөлс дээр нь тэр гүйцэтгэл нь байна уу, үндэс нь байна уу, өөр тэр бусад нийгмийн хамгааллын юмнууд нь байна уу, онцгой анхаараад өгөөч.

Тэгэхгүй бол манай улс төрчид маань нэмнэ, хэн ч нэмье гээгүй. Тэгэхдээ ингэж болохгүй гээд байхаар чинь үндсэндээ одоо бараг нэмэхгүй гэдгээ бараг шударга хэлсэн нь дээр байхгүй юу. Эрүүл мэндийн салбарынхныг бусад салбаруудтай нэмбэл адилхан нэмнэ, нэмэхгүй бол бүгдийг нь нэмэхгүй гэдэг л юмыг хэлж байна гэсэн үг шүү дээ.

Тийм учраас энэ хоёр салбар дээр яах вэ, би онцгойлж хэлээд байгаа нь нийгмийн бодлоготой ч гэсэн ярьсан. Онцгойлж хэлээд байгаа учраас яах вэ та бүгд маань дэмжээд өгвөл бас хэрэгтэй юм болов уу.

Тэгээд ер нь манай Эдийн засгийн байнгын хорооныхон нэг эмчийг бэлдэхэд хэчнээн төгрөг цаана нь зарсан бэ, нэг багшийг бэлдэхэд хэчнээн төгрөг зарсан бэ гээд эдийн засгийн бус аргаар нь тэр хүмүүст оруулсан хөрөнгө оруулалтыг бид зүгээр гадагшаа хаяад туучхаж байгаа юм байна лээ.

Тийм учраас энэ тал дээр гүйцэтгэлээр байна уу, цалингаар байна уу, яах вэ ер нь энэ хоёр салбартаа бид нэн түрүүнд ач холбогдол өгнө гэдгээр явахгүй бол 1 сая 400 мянган төгрөгийн цалинг 6 хувь нэмээд сая энэ жилийнх шиг 6 хувь нэмэхэд үсрээд 50, 60 мянган төгрөг нэмэгдэж байгаа юм. Өөр 5 сая

төгрөгийн цалинтай хүмүүсийн цалинг 6 хувиар нэмэхээр 300 мянгаар нэмэгдэж байгаа байхгүй юу. 5 дахины зөрүүтэй гараад байдаг.

Тийм учраас яах вэ, энэ хоёр салбар дээрээ л анхаарал хандуулбал энэ чинь өөрөө цаанаа тэр эмнэлэг барихаас чинь, сургууль барихаас чинь илүү чухал. Эмнэлэг, сургууль барилаа. Тэнд ажиллах хүн байхгүй болоод байгаа юм.

Тийм учраас энэ тал дээр л та хэд маань нэг оруулаад. Тэгээд Их Хурал дээр бас онцлоод дахиад ярих байх. Энэ тал дээр нь Эдийн засгийн байнгын хорооны гишүүд маань дэмжээд нэг түлхээд өгчихвөл хэрэгтэй юм болов уу л гэж бодож байна.

Р.Сэддорж: Хамгийн гол юм бол багш, эмч нарын цалинг нэмэх асуудал байгаа шүү дээ.

Тэгээд бусад юм чинь дараагийн асуудал болоод байгаа шүү дээ. Тийм учраас гишүүд саналаа өгөөд өөрсдийнхөө байр суурийг илэрхийлнэ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

17-гоос 9 хүн гишүүн дэмжиж, Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналууд. Санал хураалт үргэлжилж байна.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд доор дурдсан агуулгатай 4.1.5, 4.1.6 дахь заалтыг тус тус нэмэх:

“4.1.6.даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг өөрчилж, иргэнд үйлчлэх албаны хууль болгон шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.7.Төрийн албан хаагчийг улс төрийн болон удирдлагын хууль бус шийдвэр аливаа дарамт шахалтаас ангид байлгах эрх зүйн шинэчлэл хийнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа.

Төрийн байгуулалтын. Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Саналтай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Санал хураалт Төрийн байгуулалтын. Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, Байнгын хорооны дэмжсэн санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэл доор дурдсан агуулгатай 4.4.4 дэх заалтыг нэмэх:

“4.4.4.Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлээс хохирсон иргэд, бизнес эрхлэгчдийн хохирлыг шуурхай барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалт.
/алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Холбогдох хуулийн шаардлага хангасан аймаг, нийслэл орон нутгийн бонд гаргаж, томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Үнэт цаас” гэж, Үндсэн хариуцагч “Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж 1.1.1.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Д.Батлут гишүүн тайлбарлая.

Д.Батлут: Юуны өмнө Эдийн засгийн байнгын хорооныхоо дарга, гишүүдийн амрыг эрье.

4 санал байгаа. Монгол Улсын төсөвт төвлөрүүлдэг цөөхөн хэдэн аймаг байдаг. Тэр дундаа үнэт цаас гаргах, бонд гарах боломжтой аймаг бол Орхон аймаг, Өмнөговь аймаг, нийслэл гэсэн ийм гурван газар л байна.

Тэгээд бид бүхэн Эрдэнэт хот байхдаа нийт төсвийнхөө 66 орчим хувиар бүх асуудлаа шийдээд явдаг байсан бол 1994 оноос хойш аймаг болсноороо улсад төвлөрүүлдэг. Тэр нь 2000 оны оноос эхтэй. Байнгын төвлөрүүлдэг. Өөрт үлдэж байгаа хөрөнгө мөнгөөрөө өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагаа хангаж чадахгүй явсаар байгаад өнөөдрийг хүрсэн.

Яг үндсэндээ өнгөрсөн жилийн тооцооллоор 140 орчим тэрбум төгрөг тэгшитгээд 20 орчим тэрбумын хөрөнгө оруулалт хийгээд явж байх жишээтэй.

Тэгээд энэ бүхэн нь орон нутгийн хөгжилд, тухайн орон нутагт хүний хөгжилд, тэр дундаа орон нутагтаа хүн амьдран оршин суух нөхцөл байдлыг нэмэгдүүлэх тал дээр хөрөнгө оруулалт нь гүйцэхгүй байгаа учраас бид бүхэн бонд гаргая гэдэг саналыг хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан дээр тавьж, Засгийн газар ерөнхийдөө дэмжиж протоколд тусгасан байгаа.

Тийм учраас бонд гаргах саналыг 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд оруулаад явъя гэдэг саналаар энэ саналыг оруулж ирж байгаа юм.

Тэгэхдээ бусад гурван гарч байгаа санал нь үндсэндээ бонд босгосон хөрөнгөөрөө санхүүжүүлээд хөрөнгө оруулалтаа хийгээд явъя гэдэг ийм чиглэлтэй явж байгаа гэдгийг Та бүхэн маань бас сайн ойлгоорой.

Улсын төсөвт хамааралгүй. Орон нутгийн орон нутаг өөрөө бонд гаргаад тэр мөнгөөрөө л энэ бусад ажлуудаа хэрэгжүүлээд явъя гэдэг ийм чиглэл яригдаж байгаа юм.

Яг үнэндээ Дархан-Уул аймагтай манай Эрдэнэт хот сүүлийн үед харьцуулагддаг болсон. Дархан-Уул аймаг бүхэлдээ зам харгуйгаа засчихсан. Яг үнэндээ одоо тэгээд л лаг болсон шүү дээ. Тэгэхэд бид бүхэн замаа засаж чадаагүй. 140 километр авто замаа засаж чадаагүй. Өнөөдөр замын эвдрэл, асуудлуудаас болоод иргэд маань нэлээн бухимддаг ийм нөхцөл байдалд байна.

Иргэдийн о оршин сууж байгаа газар нутаг дээр эрчим хүчний хязгаарлалтууд их хийгддэг болсон. Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа учраас хүчдэлийн уналтууд бий болдог болсон. Зарим газраа оргил ачааллын үед 110 вольтын хүчдэлтэй байх жишээтэй ийм нөхцөл байдлууд үүссэн учраас бид замаа засъя, 35 киловаттын тойрог схемээ барьж байгуулъя. Тэгээд баруун бүсийн ложистикийн төвийг байгуулъя. Мөн дээрээс нь их дээд сургуулиудын кампусыг Засгийн газрын төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд барьж байгуулъя гэдэг ийм чиглэлээр саналуудаа тусгаад явж байгаа гэдгийг манай Байнгын хорооны гишүүд маань ойлгоорой.

Ингээд энэ саналуудыг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хариулна.

Энэ бонд босгох ажлыг энэ төлөвлөгөөнд ингэж суулгах уу? Энэ дээр хариулт авъя. 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Өрийн удирдлагын тухай хуулиараа орон нутгууд бонд гаргах боломжтой.

Өрийн удирдлагын тухай хууль дээр байгаа шаардлагаар тухайн жилийн жилийн төлөвлөгөөнд туссан байх гэдэг нэг шаардлага байгаа.

Тэгээд энэ туссаны дараа төсөв дээр саналаа хийгээд дараагийн шаардлагуудаа хангаад явна гэсэн үг.

Р.Сэддорж: 2 номер.

Ц.Эрдэнэбат: Манай яамны зүгээс санаа зовж байгаа нь шинэ саналуудын нийт үнийн дүн, тоо их өндөр болоод байгаад л санаа зовж байна л даа.

Зүгээр хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр бүсэлсэн хөгжил буюу бүсүүдийгээ хөгжүүлэх бодлого явж байгаа гэж л ингэж хэлье. Тийм.

Р.Сэддорж: М.Бадамсүрэн гишүүн эхлээд, дараа нь Д.Батлут гишүүн.

М.Бадамсүрэн: Орхон аймгийн энэ санаачилгыг дэмжиж байна.

Тэгэхээр хуулийнхаа дагуу төсвөө өөрөө сүүлийн 3 жилийн хугацаанд бүрдүүлсэн болон өөрөөр хэлбэл улсын төсвөөс дотаци авдаггүй ийм аймаг. Нэмэх нь 100 мянгаас дээш хүн амтай ийм аймгууд бонд гаргах эрхтэй байгаа. Үнэт цаас гаргах.

Тэгэхээр Орхон аймгийн энэ санаачилгыг дэмжээд, энэ дээр байгаа Орхон аймаг гэдэг дээр “шаардлага хангасан аймаг” гэж. “Орон нутаг” гэхгүйгээр “шаардлага хангасан аймаг” гээд. Ингэвэл энд Өмнөговь орно, Дорноговь орно, Дархан-Уул орно, Дорнод орно.

Тэгээд ингээд энэ аймгууд бие даагаад бонд гаргах эрхийг нь сая Сангийн яамны тайлбарласны дагуу энэ дээр тусгагдах юм бол нэг шалгуураа хангаж байгаа юм байна гэж ойлголоо.

Тийм учраас тэгээд нэгдүгээрт нь “Орхон аймаг орон нутгийн бонд гаргаж” гэдгийн оронд “шаардлага хангасан аймгууд орон нутгийн бонд гаргаж” гэж.

Хоёрт нь, үндсэн хариуцагчаар “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэсний оронд нөгөө “шалгуураа хангасан аймгууд” гэсэн ийм томъёоллоор хураавал нийт аймгуудынхаа асуудлыг шийдэхэд нэг боломжийг нь бүрдүүлэх юм байна гэж бодож байна.

Р.Сэддорж: Сангийн яам “шалгуур хангасан аймгууд” гэдэгт юуг оруулж болох вэ? 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Орон нутгийн бонд, аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах шаардлага бол 3 хуулийн хүрээнд явдаг.

Өрийн удирдлагын тухай хуулийн 28, 18, Засгийн газрын 2024 оны 168 дугаар тогтоол байгаа.

Тэгэхээр Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлага дээр яг энэ зах үнэт цаас гаргаж болно. Тэгээд 18.5.3 дээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байх гэдэг шаардлага байгаа.

Дээрээс нь дараа жилийн төсөв эхлэхээс 4-өөс доошгүй сарын өмнө Сангийн яаманд үнэт цаас гаргах хүсэлтээ ирүүлээд зөвшөөрөл дүгнэлтээ авдаг.

Тэгэхээр ерөнхий зорилт байдлаар оруулчхаад нэг шаардлагаа хангаад дараагийн процессууд нь хийгдээд явна гэсэн үг.

Р.Сэддорж: Д.Батлут гишүүн саналын томьёоллоо уншаадах уу?

Д.Батлут: Яах вэ, бас гишүүдээс санал гарч байна.

Тийм учраас би зарчмын зөрүүтэй санал болгож хэлье. Яах вэ, энэ дээр найруулгын өөрчлөлт ороод, тухайлах юм бол бонд гаргах асуудал дээр шаардлага хангасан аймаг, орон нутгуудад энэ визийг нь олгох нь өөрөө их зөв байх.

Бид чинь одоо төсөв дээрээ нэлээн том хязгаарлалтууд тавьсан байгаа шүү дээ. Яг үнэндээ. Алдагдалгүй төсөв батална гэсэн.

Тэгэхээр энэ бүхэн чинь өөрөө ирэх оны төсвийн боломж бололцоог нэлээн хязгаарлана.

Тэгэхээр яг шаардлага хангасан орон нутгуудад энэ бонд гаргах визийг нь өгөх юм бол тэд өөрсдөө улсын төсвөөс хамааралгүйгээр бондоо босгоод орон нутгийн чадамждаа тулгуурласан хөрөнгө оруулалтуудаа хийгээд явах боломжтой болох юм гэж үзэж байна.

Тийм учраас “шаардлага хангасан орон нутгууд” гэдэг зарчмын зөрүүтэй саналыг найруулга хэлбэрээр оруулаад санал хураалгая гэдэг саналыг оруулж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Сангийн яам одоо ийм юугаар орох гэж байна шүү дээ. Болж байгаа юу? Сангийн яам хэлэх үү? Тайлбар хэлэх үү? Болсон уу?

Ингээд саяын гаргасан томьёоллоор Орхон аймаг гэж явах юм уу? Орхон аймаг гэж явахгүй юм уу? Шаардлага хангасан гэдгээрээ.

Тэгэхээр “шаардлага хангасан аймаг, орон нутгийн бонд гаргаж, томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж. Ийм саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Сангийн яам 9 номер. Бонд гэдэг дээр 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Энэ дээр дарга аа, “холбогдох хуулийн шаардлага хангасан” гэж тодотгох нь зөв байх.

Р.Сэддорж: Ингээд холбогдох хуулийн шаардлага хангасан. Тийм ээ.

“Холбогдох хуулийн шаардлага хангасан аймаг, нийслэл”. Тэгээд үндсэн хариуцагчаар “аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд” гэж. Ийм томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.2.27” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Авто замын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “20” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж 1.1.1.11 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Д.Батлут гишүүн саналаа тайлбарлая.

Д.Батлут: Энэ замын ажил. Манай Орхон аймгийн зам үндсэндээ 40 гаруй жилийн насжилттай болоод нэлээн муудсан. Тэгээд одоо бүхэлд нь засвар хийх шаардлага бий болсон.

Яг үнэндээ Дархан-Уул аймагтай харьцуулагдаж сошиалаар ч яригддаг, хэвлэл мэдээллээр ч яригддаг, иргэд нь ч гэсэн энэ дээр нэлээн бухимдалтай явдаг ийм цаг хугацаа бий болоод байгаа юм.

Яг үнэндээ өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ бид бүхэн бас хангаж чадахгүй болсон. Төсвийн хөрөнгө оруулалтаараа.

Тийм учраас бонд гаргаад бондынхоо санхүүжилтээр энэ замын засварын асуудлуудыг шийдье гэж тусгаж оруулж ирж байгаа. Үндсэндээ улсын төсвөөс хамааралгүй гэж ойлгож болно шүү. Баярлалаа.

Р.Сэддорж: Санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.3.42.” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “50,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж 1.1.1.12 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Д.Батлут гишүүн.

Д.Батлут: Мөн зураг төсөвтэй ажил. Дээрээс нь манай Орхон аймаг зарим гэр хорооллын баг, алслагдсан газруудад эрчим хүчний уналтад ордог. Оргил ачааллын үед 110 киловольтын хүчдэл заадаг. Үүнээсээ болоод иргэд нэлээн бухимддаг асуудлууд бий болсон байгаа юм.

Тийм учраас 35 киловаттын энэ дэд станцыг барих, тойрог схемийг барьж байгуулах ажлыг хийж хэрэгжүүлэх гэж байгаа. Энэ бол саяын хэлсэн бондын санхүүжилтээр хийж хэрэгжүүлнэ. Улсын төсвөөс санхүүжилт байхгүй.

Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд орсон хоёр асуудал байгаа. Зам, энэ 35 киловаттын тойрог схем хоёр маань. Дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Ш.Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

Ш.Бямбасүрэн: Д.Батлут гишүүний оруулж ирж байгаа бонд гаргах асуудлыг дэмжиж байгаа.

Гэхдээ зарцуулалттай нь оруулаад ирэхээр энэ нь яг нөгөө орон нутгийнхаа нутгийн удирдлагынхаа эрх хэмжээ рүү халдаад байгаа асуудал биш шүү гэж нэгдүгээрт тодруулмаар байна.

Ерөнхийдөө Монгол Улсыг хөгжүүлэх урт хугацааны бодлоготой нийцэж байгаа гэдэгтэй санал нийлж байна. Одоо жишээлбэл бид бонд босгох асуудлыг нь шийдэж болно. Гэхдээ зарцуулах эрх мэдэл рүү нь бид орон нутгийн төсөв рүү нь орж байгаа. Тухайн шатынх нь аймгийн хурлын эрх мэдэл рүү бид нараас хэтэрхий ороод байгаа юм биш биз дээ гэсэн тийм болгоомжлол байна. Энэ дээр тайлбар өгөөч.

Р.Сэддорж: Хариулт. Д.Батлут гишүүн.

Д.Батлут: Энэ бонд босгох асуудалтай холбоотой асуудлыг манай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал авч хэлэлцээд өөрсдийн хэмжээнд шийдвэр гаргасан. Эхний хурлаараа.

Ингээд Засгийн газрын хойд бүсийн анхдугаар хуралдаанд оруулж дэмжлэг авсан байгаа.

Хоёрт нь, энэ дэмжлэг авсныхаа дараа ахин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаа хуралдуулаад эрэмбэлэгдсэн ажлуудынхаа жагсаалтыг баталсан. Тэр дотор орсон ажил байгаа учраас бид орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх хэмжээнд халдаагүй, Засаг даргын хэм эрх хэмжээнд халдаагүй. Эд бүхний оруулж ирсэн санал энд явж байгаа гэдгийг тайлбарлая. Баярлалаа.

Р.Сэддорж: Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцыг барина гэсэн энэ саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Өрсөлдөх чадвартай, тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн Дээд боловсролын үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, Эрдэнэт хотод хотхон байгуулан шилжүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “80,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж 2.5.1.4 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Д.Батлут гишүүн.

Д.Батлут: Монгол Улсын Засгийн газраас төвлөрлийг сааруулах бодлого хэрэгжиж байгаа. Тэр дундаа зарим нэг их дээд сургуулиудыг боломжтой гэсэн орон нутгууд руу гаргах, тэнд онол, практикийн цогцолбор байгуулах, хотхон байгуулах асуудлууд яригдаад тодорхой шийдлүүд гараад явж байгаа.

Энэ хүрээнд Орхон аймаг 50 га газрыг зохион байгуулаад бэлдсэн. Нэг ёсондоо оюутны кампус байгуулах газрынх нь асуудлыг шийдсэн. Одоо үүнийг зохион байгуулалтын хувьд, хөрөнгө оруулалтын хувьд хийгээд явах нь зүйтэй гэж бодож байгаа.

Энэ бол бүс нутгийн хөгжил, тухайн салбарын хөгжил, боловсон хүчин бэлдэхтэй холбоотой асуудал. Мөн төвлөрлийг сааруулах бодлоготой нийцэж байгаа гэж үзэж байгаа.

Энэ асуудлыг бид бас бондын хөрөнгө оруулалтаар зарим нэг асуудлуудаа шийдээд явах боломжтой болоод эрэмбэлж оруулж ирж хэлэлцүүлж байгаа юм гэдгийг Та бүхэндээ хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Энэ “улсын төсөв” гэдгийг авах уу, хасах уу? Үнэт цаас, орон нутгийн төсөв гэж явах уу? Д.Батлут гишүүн ээ.

Тэгээд үнэт цаасны нийлбэр хэд болов? Сангийн яам тайлбар хэлэх үү? Боловсролын яамнаас хүн байгаа юу? Сангийн яам 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Улсын төсөв гэсэн эх үүсвэрийг хасах саналтай байна.

Р.Сэддорж: Д.Батлут гишүүн саналын томъёоллоо эргэж та засварлаж хэлье.

Д.Батлут: Үндсэн хариуцагчийн хувьд Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар гэж байгаа.

Улсын төсвөөс тодорхой зүйл орох байх. Энэ бол Монгол Улсыг хөгжүүлэх 2024-2028 оны үндсэн чиглэлд орсон асуудал.

Тэгээд дээрээс нь бондын хөрөнгөөр шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг нь хийгээд явъя. Орон нутгийн түвшинд 50 га газрын асуудлыг яг энэ хотхон байгуулах хэлбэрт нь шийдсэн явж байгаа ийм л зүйл байгаа.

Тэгэхээр одоо бүгдээрээ төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд ч гэсэн тухайн салбар хойд бүсэд уул уурхайн салбар, онол практикийн цогцолбор байгуулах асуудал дээр дэмжиж өгөх нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Тэгээд гишүүд маань дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Тэгвэл орж ирсэн саналаар санал хураана гэсэн үг. Тийм ээ. Улсын төсөвт ийм өндөр ачаалал яах юм бол доо. Тийм ээ.

Саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Дэмжигдсэнгүй. Тэг.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна”

гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон Улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “46,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “28,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон Улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШСБ-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “137,500.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “30,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.11 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин.

Зам, тээврийн яамнаас байна уу? Зам, тээврийн яам. Эдийн засаг, хөгжлийн яам. Энэ хоёр зам ямар ялгаатай юм?

Эдийн засаг, хөгжлийн яам. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Тийм. Энэ яг нөгөө хариуцсан яам нь сайн мэдэх байх. Бидэнд ирүүлснээр бол замаа хоёр хуваасан юм гэж ойлгоод байгаа юм.

Р.Сэддорж: Тэгж ойлгохоор байна. Ингээд өөр асуулт асуух хүн байна уу? Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Бид 2026 оны хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж байна.

Тэгээд 6 цаг 30 минут хуралдаж байгаа. Тэгсэн яг одоо танхимд ажлын хэсгээс Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөлөл байна, Сангийн яамны төлөөлөл байна. Тэгээд бусад яамдын төлөөлөл ерөөсөө нэг хүн ч алга. Тийм.

Сайд нар нь одоо тэгээд огцорч байгаа гээд байдаггүй юм байгаа биз. Ядаж Төрийн нарийнууд нь яагаад суудаггүй юм бэ? Их Хурал дээр хөгжлийн төлөвлөгөө батлаад байдаг. Төрийн бодлого чинь ийм залгамж халаатай явах ёстой биз дээ.

Р.Сэддорж: Төсвийн байнгын хорооны дэмжээгүй хоёр дахь саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Б.Түвшин гишүүний санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логикийн цогцолборыг кластераар хэрэгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.3.5.1, 1.3.1.4, 3.3.2.5, 3.3.2.22” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрдэнэт хотод байгуулагдах бүсийн тээвэр логикийн төвийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, батлуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “ТЭЗҮ” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “2,000.00” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, ТӨҮГ” гэсэн 1.1.1.13 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут. Санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын 2.3 дахь хэсгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Олон улсад өрсөлдөхүйц чанартай, тэгш хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг бууруулсан байна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.1.19”, “ЗГҮАХ-2.2.1.7” гэж, Төсөл, арга хэмжээ “Олон жил гацсан ерөнхий боловсролын сургуулийн барилга барьж дуусгах” гэж, Шалгуур үзүүлэлт “Ашиглалтад орох сургууль” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн “40,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “40,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч

“Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 2.3.1.9 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Д.Батлут гишүүний санал дэмжигдсэнгүй.

5.Төслийн 2 дугаар хавсралтын 1.10 дахь хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Иргэдэд бүс нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “Зоонозын өвчин судлалын төвийн барилгын төсөл хэрэгжсэнээр баруун бүсэд зонхилон тохиолдох зоонозын халдварт өвчин, шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний эрт илрүүлэг, оношлогоог хурдан шуурхай оношлох, Монгол Улсын болон олон улсын стандартын дагуу шинжилгээ, судалгаа хийгдэх нөхцөл бүрдэнэ. Эмч мэргэжилтнүүдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах орчин бүрдэх, халдвартай материал сорьц алдагдахаас бүрэн сэргийлэх, мөн шаардлагатай тоног төхөөрөмж байрлуулж ажиллах орчин бүрдэнэ.” гэж, Төсөл, арга хэмжээ “1.10.1.2.Баруун бүсэд Зоонозын өвчин судлалын төвийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “4,018.00” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,009.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэсэн 1.10.1.2 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал.

Төсвийн байнгын хороо нь дэмжигдээгүй 5 дахь саналаар санал хураалт. Дэмжигдээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Өөрөөр хэлбэл Б.Заяабал гишүүний санал Байнгын хороон дээр дэмжигдсэнгүй.

6.Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна” гэж, Бодлогын үндэслэл “Улаангом, Баруунтуруун чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замыг барьснаар Увс аймгийн зүүн талын 6 сум /Баруунтуруун, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Малчин, Тэс/ хатуу хучилттай авто замд холбогдох

боломж бүрдэнэ. Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан баруун бүсийн газар тариалангийн гол бүс нутаг болох Баруунтурууны улаанбуудай, тэжээлийг зах зээлд нийлүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, гурил тэжээлийн үйлдвэр амжилттай ажиллах нөхцөл бүрдэх өндөр ач холбогдолтой авто зам болно” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаангом-Баруунтуруун чиглэлийн 180 км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн “360,000.00” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “36,000.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17-гоос 11 гишүүн дэмжиж, дэмжээгүй санал дэмжигдлээ.

Б.Заяабал гишүүний санал дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхээ гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 6 цаг 34 минут үргэлжилж, 17 цаг 14 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД